⁵ Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс асуусан агуулга (2024 оны 3-р сарын 7-ны өдөр)

⁶ E-Mongolia Academy-ээс сонссон агуулга (2024 оны 4-р сарын 23-ны өдөр)



Эх сурвалж: OECD веб сайт "Aid at a Glance Charts, Interactive summary charts by aid (ODA) recipients"(2024 сарын 2-р сард харав.)

Зураг 10 Монгол улсад дэмжлэг үзүүлж буй нийт ODA-ийн мөнгөний дүнгээр эхний 10 донор улсууд (2020-2021 оны днджаар , сая USD)

Монгол Улстай 2024 он хүртэлх түншлэлийн стратегийн дагуу цахим засаглалыг хэрэгжүүлэх чадавхийг хөгжүүлэх техникийн туслалцаа (төслийн нэр: Цахим засаглал ба дижитал өөрчлөлт) үзүүлж, MDDIC-тэй хамтран ажиллаж байна⁷. Мөн, дээр дурдсан Боловсролын яамны харья Боловсролын салбарын дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030(Education Sector Mid-Term Development Plan 2021-2030)-г ADB-ийн дэмжлэгтэйгээр боловсруулсан⁸.

2022 оны 4-р сард Монгол дахь НҮБХХ нь Дижитал үндэстэн стратегийн хэрэгжилтийг хурдасгах, дэмжих зорилгоор MDDIC-эй стратегийн түншлэлийн гэрээ байгуулсан. Мөн, Дэлхий банк нь 2022 онд Монголын засгийн газрын Шинэ төсөл болох "Smart Government II"-г дэмжиж байна. Smart Government II төсөл нь цахим технологийг найдвартай бөгөөд кибэр аюулгүй байдлыг хангаж ашиглах тал дээр Монгол улсын эрх зүйн байдлыг сайжруулах зорилготой төсөл юм⁹.

Хүснэгт 11 МХХТ, цахим үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хамтран ажиллах гол хөгжлийн түнш болон дэмжлэгийн агуулга

Development Partners	Support Contents
ADB	e-Government and Digital Transformation (Technical assistance)
ADB	Supporting the Implementation of Education Sector Medium-Term Development Plan (Technical assistance)
UNDP	Signing of a Strategic Partnership for the Implementation of the Digital Nation Strategy
World Bank	Promotion of the Smart Government II Project
Estonia e-Governance Academy (Non-Profit Organization)	Promotion of e-Government
United Nations Asian and Pacific Training Centre for Information and Communication Technology for Development (APCICT)	Cooperation in the Promotion of e-Government and Human Resource Development / Provision of Training to Enhance Government Officials' Basic Understanding and Skills in Information and Communication Technology
ITC	Formulation of an Export Strategy

Эх сурвалж: MDDIC—"Digital Nation" approval guidelines" болон бусад төрөл бүрийн олон нийтэд нийтлэгдсэн мэдлээллийг үндэслэн судалгааны баг боловсруулав.

⁷ ADB (2022) "Technical Assistance Report Mongolia:e-Government and Digital Transformation"

⁸ Ministry of Education and Science (2020) "Education Sector Mid-Term Development Plan 2021-2030"

⁸ ADB (2022) "Technical Assistance Report Mongolia:e-Government and Digital Transformation"

⁸ Ministry of Education and Science (2020) "Education Sector Mid-Term Development Plan 2021-2030"

⁹ World Bank (2022) "Mongolia: New Project Helps the Government Go Digital and Grow the Economy"

Мөн дээрхээс гадна Цахим үндэстэн хөтөлбөр дахь Олон улсын НҮБ-ын Сансар судлалын агентлаг(United Nations Space Agency: UNOOSA)болон NASA-тай сансарын салбарт MoU-г байгуулахаар төлөвлөж байна. Мөн Монголын Засгийн газар Google,Meta(хуучин Facebook),Amazon, Microsoft зэрэг томоохон дэлхийн хэмжээний МХХТ-ын компанитай хамтран ажиллах тогтолцоог бий болгосон. Тухайлбал, Google нь MDDIC-тэй хамтран 1000 МХХТ-ийн хүний нөөцийн авъяас чадварыг хөгжүүлэх зорилготой Google Mongolia төсөл дээр хамтран ажиллаж байгаа бөгөөд 2024 оны 6-р сарын байдлаар 350 хүн сургалтад хамрагдаж байна. Сургалтад оролцогчдын насны хувьд 18-65 нас хүртэл өргөн хүрээтэй байгаа ба намтар нь янз бүр байна. Сэдвийн хувьд өгөгдлийн анализ, UX дизайн, кибер аюулгүй байдал, цахим маркетинг гэх мэтээр өргөн хүрээг хамрахын зэрэгцээ англи хэл болон софтскилд (зөөлөн ур чадвар) суралцана. Мөн энэхүү сургалт нь сургалтын тэтгэлэгт бүтэн хамрагдсан. ¹⁰Түүнээс бусад ААН-ийн хувьд жишээлбэл Meta нь олон нийтийн сүлжээг оновчтой ашиглах, бизнес эрхлэхэд хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, Amazon нь AI болон үүлэн компьютержилт гэх мэт дэвшилтэт технологийн хөгжүүлэлтийг дэмжих зэргээр Монголын засгийн газартай хамтран ажиллаж байна¹¹.

(2) Гарааны бизнесийн экосистемийг үүсгэн байгуулах

(а) Засгийн газрын урт хугацааны алсын хараа болон гол бодлогууд

Дээр дурдсанчлан Монголын засгийн газар урт хугацааны хөгжлийн төлөвлөгөө болгож "Vision 2050"-г хэргжүүлж байгаа бөгөөд тэнд 9 гол бодлогыг дурдсан байна. Гарааны бизнес болон Бизнес эрхлэлтийн талаар хэд хэдэн бодлогод дурдагдсан байгаа бөгөөд голлох нь "THE QUALITY OF LIFE AND MIDDLE CLASS"-д дурдагдсан байна. Харин дурдагдсан байгаа зорилтууд нь чанарын агуулгатай бөгөөд тоон үзүүлэлт нь зөвхөн "эмэгтэйчүүдийн бизнэс эрхлэлт"-тэй холбоотой үзүүлэлтүүд байна.

Чанарын зорилтууд(Гол зүйлийг түүж дурдав)

- 3.3.13. *Work out and implement the "Youth Entrepreneurship" national program.* ("Залуучуудын бизнэс эрхлэх сэтгэл зүй"-н сэдэвтэй хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх.)
- 3.3.14. *Take comprehensive measures on providing the young people engaged in start-up business with the necessary knowledge and skills to expand and step up their business and promote the related infrastructure.* (Бизнес эрхэлж буй залуучуудад бизнесээ өргөжүүлэх, ахиулахад шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх, холбогдох дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авна.)
- 3.3.15. *Introduce modern forms of financing designed for start-ups and establish an effective financial system.* (SU-д зориулсан санхүүжилтийг нэвтрүүлэн хэрэгжүүлж, үр дүнтэй санхүүгийн тогтолцоог бий болгоно.)
- 4.3.4. *Create start-up capital funds and train professional investors for the financing a start-up businesses.*
(Гарааны бизнесд зориулсан сангуудыг бий болгох, санхүүжүүлэх чадвартай мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг сургах)
- 7.4.26. *Establish a special investment fund to support innovation in the sector and invest in start-up businesses, and create a legal environment for its functioning.* (Инновацийг дэмжиж, гарааны бизнесд хөрөнгө оруулах зорилготой сан байгуулж, эдгээр үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлэх)
-

Тоон зорилтууд

indicator	Base	Target		
		2025	2030	2050
Entrepreneurship indicators ¹²	67.8	70.0	72.5	82.5

¹⁰ Mongolian National News Agency (2024 оны 6-р сарын 26-ны өдрийн нийтлэл) ,news.mn (2024оны 4-р сарын 5-ны өдрийн нийтлэл)

¹¹ MDDIC (2022)“Digital Nation”approval guidelines”

¹² World Bank https://wbi.worldbank.org/en/data/exploretopics/wbi_rb World Bank's annual index of women's entrepreneurship and business management

Түүнээс гадна гарааны бизнесийн экосистемийг бий болгохтой холбоотой өнөөг хүртэлх гол бодлого болон арга хэмжээнүүдийг доор дурдав.

Policies and Initiatives	Start Year	Content
Science and Technology Fund (STF)	1993	- A national fund to contribute to the sustainable development of Mongolia by providing funds to raise Mongolia's research and development level to global standards - The types of research activities that can be funded by the STF are determined by the Ministry of Education and Science - Through 2018 and 2021, a total of 1,520 research projects were funded with a total of 24 billion MNT (approximately 910 million yen).
Investment Law	2013	- When a factory for products including nano and innovation technologies is constructed, the tariff on imported technologies and equipment is exempted during the construction period, and the value-added tax is reduced to 0%. - Non-tax incentives for investors, such as incentives for financing innovation projects and guarantees for financing the production of innovation products for export, are provided
Innovation Act	2014 (Revised in 2019)	- stipulates government obligations and activities related to innovation - There are tax incentives for startups, but the definition of startup is narrow and the target is very limited
Vision 2050	2020	- Establish ICT and innovation as one of the priority areas and aim to support and increase the contribution of this area to the economy - Ecosystem development through financing methods and support programs for startups and chemical technology development - Develop human resources by providing support programs and opportunities for entrepreneurs and researchers
ICT Industry Promotion Act	2024	- Describe the authority and responsibility of the national and local governments in promoting the ICT industry - It stipulates that the role of the government is to establish a virtual zone to support the ICT industry and to provide tax and non-tax support (Provision of subsidies for patent registration and certification of international quality and standards at the time of export) to companies registered in the virtual zone

Эх сурвалж: Олон нийтэд нийтлэгдсэн төрөл бүрийн мэдээллээс судалгааны баг боловсруулав.

Зураг 11 Гарааны бизнесийг хөгжүүлэхтэй холбоотой гол бодлого, арга хэмжээ

(б) Бодлого боловсруулалт, хэрэгжүүлэх тогтолцоо(Засаглалын тогтолцоо, хөгжлийн түнш байгаа эсэх)

① Хэрэгжилтийн тогтолцоо

Гарааны бизнес болон инновацитай холбоотой дэмжлэгийн гол байгууллага нь Ministry of Economy and Development(Эдийн засгийн хөгжлийн яам)байна. 2022 он хүртэл Боловсрол, шинжлэх ухааны яам (2024 оны 7-р сард нэрээ Боловсролын яам болгон өөрчилсөн) нь тус санаачилгын үндсэн байгууллага байсан ч энэ үеэс эхлэн Эдийн засгийн хөгжлийн яам удирдан чиглүүлэхээр болгож Засгийн газар шийдвэрлэсэн. Харин бодит хэрэг дээр Эдийн засаг хөгжлийн яам, Боловсролын яам, Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яамууд өөр өөрийн яамны харьяалах салбарын хүрээнд оролцож байгаа байдалтай байгаа ба одоогийн байдлаар хоорондын хамтын ажиллагаа гэх тодорхой зүйл харагдахгүй байна.

② Хөгжлийн түнш

Гарааны бизнесийн экосистемийг бий болгохтой холбоотой олон улсын доноруудын үзүүлдэг гол дэмжлэгийн агуулга нь дараах байдалтай байна.

Хүснэгт 12 Гарааны бизнесийн экосистемийг бий болгохтой холбоотой хөгжлийн гол түншүүдийн дэмжлэгийн агуулга

development partner	Contents of support
JICA	Provision of acceleration program MONJA Conducted Ecosystem Survey (MONGOLIAN STARTUP ECOSYSTEM)
EBRD	Provision of the European Bank for Reconstruction and Development (hereinafter EBRD) Star Venture program
ADB	ADB Ventures has formed a partnership with KITE ¹³
UNDP	Conducted a baseline survey on Mongolian entrepreneurs as part of the “Activated 2030” initiative.
World Bank	“Entrepreneurship-Focused Socioemotional Skills for the most Vulnerable Youth in Rural Mongolia Project(2020-2025)” : Provision of socioemotional skills and entrepreneurship education to 6,000 young people from 25 of Mongolia's poorest rural communities

Эх сурвалж: Олон нийтэд нийтлэгдсэн төрөл бүрийн мэдээллээс судалгааны баг боловсруулав.

¹³ Mongolian accelerator. <https://kiteaccelerator.com/>

(3) Нээлттэй өгөгдлийн ашиглалт

(а) Засгийн газрын урт хугацааны алсын хараа болон гол бодлогууд

Монголын засгийн газар засгийн газрын хэрэг эрхлэх газар нь нээлттэй өгөгдлийг "хөгжил, цэцэглэлтийн төлөөх олон нийтийн өгөгдөл" гэж заасан байдаг. Тус судалгааны үр дүнд, одоогийн Монголын засгийн газарт нээлттэй мэдээллийн хэрэглээ, ашиглалтын талаар тэдгээрт зориулсан арга хэмжээ, чиглэл болон үйл ажиллагааны төлөвлөгөө, урт хугацааны алсын харааг багтаасан засгийн газрын стратеги зэрэг нь тодорхой бус, эсвэл одоохондоо тодорхой шийдвэр гаргаагүй байдалтай байна. Нээлттэй өгөгдлийн талаарх ерөнхий чиглэл болон эцсийн зорилт нь тодорхой бус байгаагаас холбогдогч этгээд тус бүрийн тодорхой зорилгыг биелүүлэхэд тохирох үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулагдаагүй байгаа нь өнөөдрийн бодит байдал байна.

Мөн Засгийн газрын ил тод байдлыг сайжруулах үүднээс мэдээллийг ил байлгахтай хобоотой үйл ажиллагааны төлөвлөгөөг улс хоорондын санаачлагч болох "Open Government Partnership"-ын нэг хэсэг "Mongolia National Action Plan for Open Government" гэж саяхан 4 дахь үеийн төлөвлөгөө боловсруулагдсан ба Монгол улсын дотоодод тасралтгүй хэрэгжүүлж байгаа боловч нээлттэй өгөгдлийн ашиглалтын талаар бараг дурдагдаагүй, нээлттэй өгөгдлийн хоёрдогч ашиглалт болон арилжааны чиглэлээр ашиглах бодлогын хүрээг хараахан тогтоогоогүй байна.

(б) Бодлого боловсруулалт, хэрэгжүүлэх тогтолцоо(Засаглалын тогтолцоо, хөгжлийн түнш байгаа эсэх)

Монголын засгийн газар нь 2015 оноос 2022 он хүртэл хөгжлийн түнш болох Дэлхийн банкны групп байгууллага болох Олон улсын Хөгжлийн нийгэмлэг(International Development Association доор IDA гэх)тэй хамтарч МХХТ-ыг ашигласан Монголын төрийн үйлчилгээний хүртээмжтэй байдал, ил тод байдал, үр ашигтай байдлыг сайжруулахыг зорьсон Ухаалаг төр төслийг хэрэгжүүлсэн. Түүний нэг хэсэг болгож Монгол дахь Монголын засгийн газар болон холбогдох байгууллагын хадгалж буй өгөгдлийг олон нийтэд нээлттэй болгох болон гуравдагч этгээдэд¹⁴ бизнесийн зориулалтаар ашиглах зэрэг хоёрдогч хэрэглээг дэмжих нь нээлттэй өгөгдлийн ашиглалтыг хөгжүүлэх зорилго мөн гэж тодорхойлогдох ба засгийн газрын удирдлага дор нээлттэй өгөгдлийн портал анх байгуулагдсан.


Summary	- Implemented with financial support from the World Bank, <u>the project aims to improve the accessibility, transparency, and efficiency of public services in Mongolia through the use of ICT</u> - Support from the International Development Association (IDA)(USD 190,000)
Objective	- Led by the Cabinet Secretariat, with participation from the National Statistics Office and the Communications and Information Technology Authority. - Strengthening mechanism for citizen participation and feedback. - Establishing the foundation for smart governance through the digitalization of public services. <u>Promoting open data.</u> - Providing support for project implementation. - Ensuring the sustainable supply of high-quality data - Supporting the development of a vibrant open data ecosystem driven by demand-led innovation.

Зураг 12 Ухаалаг төр төслийн ерөнхий байдал

Тус порталд дотоодын 37 яам агентлагын тээвэр /хүнс/ХАА/үйлдвэрлэл/нийгмийн халамж/хөдөлмөр/боловсрол/соёл/шижлэх ухааны салбартай холбоотой өгөгдлийн иж бүрдэл нь "хөгжлийн зориулалттай өгөгдөл" хэмээн 2020 оноос Засгийн газрын веб хуудаст нийтлэгдсэн байна. Нээлттэй болгосон байгуулга нь Үндсэний статистскийн газар гэх мэт, хэлбэр нь

¹⁴ Өгөгдөл эзэмшигч, нээлттэй өгөгдлийн порталын удирдагчаас гадна сонирхогч тал болох нээлттэй өгөгдлийн ашиглагчийг гуравдагч этгээд гэж нэрлэнэ.

XML,XLXS,CSV,JSON-ны аль нэгэнд тохирсон байх бөгөөд нээлттэй өгөгдлийн нээлтийн түвшинг илэрхийлэх 5 Star Open Data-нд таарсан нээлтийн хэлбэртэй байна. Мөн тус портал нь Японы орон нутгийн захиргааны байгууллагуудад хэрэглэгдэж буй Дата каталогийн сайтыг үүсгэхэд хэрэглэгдэж буй нээлттэй эхийн програм хангамж болох Comprehensive Knowledge Archive Network (CKAN)-г ашиглан бүтээгдсэн. Харин хэрэгтэй өгөгдлийг олоход бэрхшээлтэй байх, мета өгөгдлийн чанар, нээлттэй өгөгдлийн хэлбэр нь хязгаарлагдмал байгаа г.м. нь Open Data Inventory дахь тухайн орны чанарын үнэлгээний дүгнэлтэд заагдсан байна. Цаашид хувийн хэвшил болон хувь хүний хэрэглээ өсөхийг харгалзан, улам хэрэглэхэд дөхөм нээлттэй өгөгдлийн порталыг байгуулах шаардлагатай. Харин одоогийн байдлаар харилцах хэл нь зөвхөн Монгол хэл байгаа боловч нээлттэй өгөгдлийн хэрэглээний хувьд өөрийн орны хэрэгцээг нарийн сайн мэддэг дотоодын хөрөнгө оруулалттай ААН-ийн ашиглалт нь гол хэсгийн эзлэх байдал харагдаж байгаа тул англи хэл зэрэг олон хэл дээрх хэрэглээг нэн яаралтай шийдэх шаардлага хараахан харагдахгүй байна.



Зураг 13 Нээлттэй өгөгдлийн портал(Open Data Portal)-ын Монгол хувилбарын ашиглалтын дэлгэцийн төсөөлөл

Цаашилбал, MDDIC-тэй хийсэн асуулгаас харахад дээрх нээлттэй мэдээллийн порталуудаас гадна Монголд 1212.mn, Shilen зэрэг хэд хэдэн нээлттэй мэдээллийн порталууд байдаг нь тогтоогджээ. Доор тэдгээрийн нарийвчилсэн мэдээлэл болон хуваарилалтыг мэдэж байгаа хүрээндээ цэгцлэн харуулаа.

Монголд одоогийн байдлаар хэд хэдэн нээлттэй өгөгдлийн порталуудыг нэгтгэх хандлага байхгүй бөгөөд юуны түрүүнд нээлттэй өгөгдлийн нийт багтаамжийг нэмэгдүүлэхээр яам агентлагууд хоорондоо өрсөлдөх байдалтай байна. Японд бол e-stat хэмээн засгийн газрын статистикийн өгөгдлийн ерөнхий сайт байгаа бөгөөд ашиглагчын хувьд нэгдсэн цонх байх нь илүү ашиглахад дөхөмтэй тул цаашдаа тус бүрийн нээлттэй өгөгдлийн порталд тодорхой хэмжээний өгөгдлүүд цугларсан үед нэгтгэх үйл ажиллагаа явагдаж магадгүй юм.

Хүснэгт 13 Монголын дотоодын нээлттэй өгөгдлийн порталын жагсаалт

Name of the Portal	Link of Website	Overview
OPEN DATA GOV.MN	https://opendata.gov.mn/	An open data portal established as part of the Smart Government Project, a joint initiative with the World Bank. It supports only the Mongolian language. (2020)
1212.mn	https://www.1212.mn/en	A statistical data catalog operated by the National Statistics Office of Mongolia. It publicly provides over 700 statistical datasets, including national census data managed by the office, in open formats (Excel/CSV/Text/JSON) that are available for secondary use by the general public. The portal supports both Mongolian and English languages, and the datasets are licensed under the CC-BY license, allowing for secondary use for commercial purposes.
Shilen.gov.com	https://shilen.gov.mn/	Established in 2023. Managed by the MDDIC. Supports only the Mongolian language.
1313.mn	https://1313.mn/	Managed by the Center for Health Development in the Ministry of Health. Supports only the Mongolian language.

Мөн орон нутгийн захиргааны хэмжээнд бол, 2015 оноос хойш Улаанбаатар хотын Мэдээлэл технологийн алба бие дааж Nadoor технологийг үндэслэн нээлттэй өгөгдлийн пратформыг байгуулах ажлыг эрхлэн явуулж байгаа бөгөөд(Ulaanbaatar Big and Open Data Project),тус хотын 10 захиргааны байгууллагад ойролцоогоор 60 том өгөгдлийг багтаасан өгөгдлийн иж бүрдэлийг олон нийтэд нээлттэй болгосон гэх мэдээлэл бий.

Доорх хүснэгт нь Монгол улс дахь нээлттэй өгөгдөлтэй холбоотой засгийн газрын байгуулга, захиргааны байгуулгуудын нэр болон хэрэгжүүлж буй үйл ажиллагааны нөхцөл байдлын тухай юм.

Хүснэгт 14 Нээлттэй өгөгдөлтэй холбоотой засгийн газар • захиргааны гол байгууллагууд болон хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд

Name of the organization	Role	Results
CITA (Communication and Information Technology Authority of Mongolia)	- Drafting policies related to open data, data protection laws, and national programs for e-government - Agency directly under the Cabinet Office	Administration and management of "The Guidance on Developing State Open Data Systems, and use of the System"
NDC (National Data Center)	Development of the National Data Exchange Platform	Development of systems such as "Khur" and "Speed"
NSO (National Statistics Office)	- Implementation of open data initiative - Handling of government open data - Independent Administrative Agency	Developed 1212.mn,an API data exchange platform(open data portal)
PCSP (Government Agency for Policy Coordination on State Property)	- Collaboration between the Open Government Partnership and the Open Data Initiative - Leading national open data initiative	Operates the website http://opendata.tender.gov.mn , which publishes API for bidding information in the national electronic procurement system
GSR (General Authority for State Registration)	Stipulating The National Registration Package Law (2018)	Developed a public registry information portal such as corporations,addresses,and real estate

(в) Өгөгдөлтэй холбоотой дүрэм журам(хувь хүний мэдээллийг хамгаалах, өгөгдлийг хэрэглэх, ашиглах, UAF тогтолцоо зэрэг багтсан)

Нээлттэй өгөгдлийг хэрэглэх, ашиглах тухай тус улсын хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлийг доор нэгтгэсэн ба хамгийн сүүлд гарсан Article 12.6 2023-ыг үл тооцвол бүгд засгийн газрыг ил тод байдлыг сайжруулах мэдээллийг нийтлэхтэй холбоотой хуулиуд байгаа бөгөөд эдгээр мэдээллийн ил тод байдал болон мэдээлэл авах эрхийн тухай хууль нь нээлттэй өгөгдлийн хэрэглээг дэлгэрүүлэх боломжийг

дэмжих боловч нээлттэй өгөгдлийг хэрэглэх, ашиглахад чиглэсэн эрх зүйн орчиныг бүрдүүлэх ажил нь саяхныг хүртэл бараг явагдаагүй байсан. Нөгөө талаар 5-р бүлгийн 4.(1)-д дурдсанчлан 2022 оноос хойш нээлттэй өгөгдлийн хэрэглээ, ашиглалтыг нэмэгдүүлэхтэй холбоотой хэд хэдэн хууль тогтоомж нь боловсруулагдсан ба засгийн газрын дотоод нээлттэй өгөгдлийн бэлтгэлд чиглэсэн ойлголт болон хүчин зүтгэл нэмэгдэж байна.

**Хүснэгт 15 Монгол улсын дотоодын өгөгдлийн ашиглалтын талаарх хууль дүрэм
журамын жагсаалт**

Regulation	Year of Enactment
Law on Information Transparency and the Right to Information	2011
The Glass Account Law (Mandating the reporting and public disclosure of government budget information, including funding and debt information.)	2014
Government Resolution 159 (Providing guidelines for the handling and sharing of data within government electronic databases.)	2017
Law on Protection of Personal Data (A law that extensively stipulates the protection of personal information and the use of personal data by public and private entities. It also regulates the collection, processing, and utilization of personal data collected by government agencies.)	2021
Fourth Mongolia National Action Plan for Open Government (The multilateral initiative Open Government Partnership (OGP) supports the Mongolian government in formulating an action plan to improve information disclosure. As part of the long-term plan extending to 2050, the action plan for 2021-2023 is currently underway.)	2021
Article 12.6 of the Law on Transparency of Public Information (A law that mandates that accompanying data of the data listed by each national agency to be uploaded to the respective ministries' websites and the national open data system within the period stipulated by the Information Disclosure Act 12.6.)	2023

Мөн Монголын засгийн газрын нээлттэй өгөгдлийн хоёрдогч ашиглалт, лицензтэй холбоотой журам болох Монголын дотоодод нээлттэй өгөгдлийн ашиглах нийтлэг лицензийн журам байгаа эсэхийг тогтоож чадаагүй. Гэвч нээлттэй өгөгдлийн порталын зарим хэсэгд (1212.mn) бүтээлч нийтлэг лицензийн BY/Attribution (Зохиогчтой холбоотой мэдээллийг ил байлгахын зэрэгцээ сайжруулж ашиглах болон ашгийн төлөө ашиглах зөвшөөрөл) өгч байгаа нь тодорхой байна. Ингэснээр Монголын засгийн газрын нээлттэй өгөгдлийн байх ёстой төлвийг тодорхойлж, тус улсын засгийн газрын байгууллагуудад олон тоогоор байгаа нээлттэй порталуудыг нэгдсэн лицензээр порталыг ашигладаг болгох Creative Commons лиценз гэх мэт олон улсын дүрэм журмыг дагах зэргээр тус улсын хувьд нэгдмэл дагаж мөрдөх дүрэм журмыг тогтоох хэрэгтэй байна.

(г) Өгөгдлийг уялдуулах суурь бүтэц (платформ)

Нээлттэй өгөгдөлтэй төстэй өгөгдлийн уялдааг хангах суурь бүтцийн талаар авч үзнэ. Нээлттэй өгөгдөл нь засгийн газар, захиргааны байгууллагын эзэмшиж буй өгөгдлийг хүн бүрд хандаж ашиглах боломж олгож олон нийтэд нээлттэй болгодог бол өгөгдлийн уялдааны платформ нь засгийн газар болон захиргааны байгууллагын эзэмшиж буй өгөгдлийг хязгаарлагдмал хүрээнд буюу тодорхой хэсэг хувийн хэвшлийн ААН -үүд л хандаж, ашиглах боломжтой¹⁵. Засгийн газар болон захиргааны эзэмшиж буй өгөгдөлд хандах эрхтэй субъект нь өөрчлөгдсөн ч өмнө нь засгийн газар болон захиргааны өгөгдлийг ашиглах эрхгүй байсан хувийн хэвшлийн ААН нь эдгээрийг үр дүнтэй ашигладаг болсноор оршин суугчдын үйлчилгээг сайжруулж, орлогыг нэмэгдүүлэх гэсэн зорилго нь ижил болно.

3-р бүлэг 3-р хэсэг. (1) дэх хэсэгт дурдсаны дагуу Монголын засгийн газар цахим засаглалын үйлчилгээ E-Mongolia-г ажиллуулж байна. Энэхүү E-Mongolia-гийн доор захиргааны байгууллагын E-Mongolia-г 2017 онд бий болгосон ХҮР гэдэг өгөгдлийн уялдааны суурь бүтэц байдаг бөгөөд энэхүү ХҮР нь яам агентлаг хоорондын нэгдмэл өгөгдлийн солилцооны платформын үүргийг гүйцэтгэж байна. ХҮР нь Х-

¹⁵ Өгөгдлийг уялдуулах ерөнхий платформ гэж хэд хэдэн захиргааны байгууллага хоорондын мэдээллийн платформыг уялдуулахыг хэлэх бөгөөд тус тайланд төр болон хувийн хэвшлийн мэдээллийн платформыг уялдуулах талаар үзүүлнэ.

Road¹⁶-оос санаа авсан уу гэж E-Mongolia-г хөгжүүлэгчээс асуухад "албан ёсоор X-Road-г үндэслэн архитекторыг зохиож, системийг зохиогоогүй ч X-Road нь нээлттэй эх сурвалж тул хөгжүүлэлтийн шатанд зарим хэсгээс санаа авсан байж магадгүй" гэсэн хариулт авсан. Интерфейс болох E-Mongolia-д хэрэглэгчдээс цуглуулсан өгөгдлүүд нь Үндэсний өгөгдлийн төвд (National Data Center) хуримтлагдаж байна. Интерфейсийн E-Mongolia нь захиргааны байгууллагууд хоорондын өгөгдлийг уялдуулахаас гадна хувийн хэвшилд зориулсан өгөгдлийг уялдуулах ажлыг хэдийнэ хийсэн байна. Хувийн хэвшлийн ААН -үүдийн үйлчилгээнүүдийг E-Mongolia-тай уялдуулахаар бол ААН нь тус тусдаа E-Mongolia-аас API token¹⁷ олгохыг хүсэх өргөдөл гаргана(төлбөртэй). Мөн өргөдөл гаргахдаа тодорхой шалгуурууд хангах журамтай. Хэдийнээ хувийн хэвшлийн ААН-тай хамтан ажиллаж байгаа жишээ хэд хэд байгаа бөгөөд цаашид энэхүү API -ийн үйлчилгээг өргөжүүлэн хувийн хэвшлийн үйлчилгээтэй уялдаа холбоог бэхжүүлэн үйлчилгээний үр ашгийг улам сайжруулахыг зорьж байна. Хувь хүний мэдээлэлтэй харьцах тухайд хэрэглэгчдийг бүртгэх арга хэрэглэдэг бөгөөд зарим хэрэглэгчдээс хэт олон мэйл ирдэг гэсэн шүүмжлэл ч бас дагуулдаг. Мөн одоо үзүүлж буй үйлчилгээний тоо болон үйлчилгэний талаар мэдэж чадаагүй байгаа ба дараа уулзаж асууж тодорхой болгоно.


3. МХХТ, цахим үйлдвэрлэл болон гарааны бизнесийн экосистемийн өнөөгийн байдал

(1) МХХТ, цахим үйлдвэрлэлийн хөгжүүлэлтийн өнөөгийн байдал

(a) МХХТ-ийн үйлдвэрлэлийн зах зээл

① МХХТ-ийн үйлдвэрлэлийн ДНБ-н харьцаа

Одоогийн байдлаар Монголын МХХТ -ийн үйлдвэрлэлийн ДНБ-тэй харьцуулах харьцаа нь ойролцоогоор 2% байна. ДНБ-ний харьцаа хамгийн их байх нь уул уурхай болон Хөдөө аж ахуй ба тус бүр 23%, 13% буюу өндөр хувийг эзлэж байна. Түүхийг харахад дээрх уламжлалт аж ахуйн хувь өндөр байгаа ч, ялангуяа уул уурхайн салбар нь олон улсын зах зээлийн байдал болон баялагын үнийн нөлөөнд автамтгай үйлдвэрлэл тул Монголын эдийн засгийн хөгжлийг урагшлуулахад голлох тулгуур үйлдвэрлэл болох өөр үйлдвэрлэл хэрэгтэй болоод байна.




Эх сурвалж: Монголын үндэсний статистикийн ерөнхий хорооны өгөгдлийг үндэслэн судалгааны баг боловсруулав.

Зураг 14 Монголын салбар бүрийн ДНБ-ийн өөрчлөлт (Сая төгрөг, одоогийн үнээр)

¹⁶ Эстони улсын засгийн газрын байгууллагууд болон хувийн хэвшлийн ААН-үүд өгөгдлүүдээ аюулгүй, үр дүнтэй хуваалцах боломжтой уялдуулах платформ.

¹⁷ API-д хандахад зориулсан Нэвтрэх нэр (ID), түлхүүр үгийг орлуулах баталгаажуулах мэдээлэл. Тодорхой хэрэглэгч болон програмд олгогдоно.




Эх сурвалж: Монголын үндэсний статистикийн ерөнхий хорооны өгөгдлийг үндэслэн судалгааны баг боловсруулав.

Зураг 15 Монголын салбар бүрийн ДНБ-ийн өөрчлөлт (2022 он, одоогийн үнээр)

② Дотоодын зах зээлийн хэмжээ


Монголд гар утас өргөнөөр нэвтэрсэн байгаа ба хэдийнэ орон нутгийн төвүүдэд 4G сүлжээнд холбогдсон байна. Интернетийн хувьд хөрш орны Хятад, Оростой шилэн холбооноос хамааралтай болсон ба 2021 он гэхэд хүн амын 84% хүртэл нэвтэрсэн байна.

МХХТ-ийн үйлдвэрлэлийн зах зээлийн хэмжээ(харилцаа холбооны салбарын нийт ашиг орлого)нь 2012 оноос өссөөр байгаа ба 2017 онд ойролцоогоор 1.4 дахин их, 2022 онд ойролцоогоор 3 дахин их болж 1.7 их наяд төгрөг (ойролцоогоор 73 тэрбум иен)хүртэл өссөн байна. Энэ өсөлт одоогийн MDDIC-ны "2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн алсын хараа(2016)" -д дурдсанчлан гар утасны интернет харилцаа холбооны сүлжээг өргөсгөн, чанарыг сайжруулсан нь Засгийн газрын хүчин чармайлт юм. Монголын Хөрөнгө оруулалтын ерөнхий газар (Invest Mongolia)-ын мэдээлээр, засгийн газар нь ийнхүү МХХТ-ийн үйлдвэрлэлийн хөгжилд бүх талын дэмжлэг үзүүлсэнээр МХХТ-ийн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэх боломжийг бий болгосон гэж дурджээ.



Зураг 16 Интэрнет нэвтрэлтийн хувь


Эх сурвалж: Дэлхийн банк, Монголын үндэсний статистикийн ерөнхий хорооны өгөгдлийг үндэслэн судалгааны баг боловсруулав.



Зураг 17 Монголын МХХТ-ийн салбарын нийт ашиг орлогын өөрчлөлт

③ Гол тоглогч

Монголын МХХТ-ийн салбарт програм хангамжийн үйлчилгээний (програм хангамжийн хөгжүүлэлт, хангамж) компаниуд дийлэнх хувийг эзэлж байгаа бол харилцаа холбооны дэд бүтцийн компаниуд (суурин холбоо (суурин утас, ADSL, шилэн кабелийн шугам зэрэг), үүрэн холбооны (гар утас, PHS гэх мэт) үйлчилгээг үзүүлдэг компаниуд) гэх мэтээр үргэлжилнэ. Програм хангамжийн үйлчилгээний компаниуд гэвэл 1990-ээд онд үүсгэн байгуулагдсан Mogul Group, INTERACTIVE зэрэг компаниуд байдаг бөгөөд ялангуяа INTERACTIVE компани нь АНУ, Их Британийн хувийн компаниуд, Киргизийн засгийн газраас гадна, НҮБХХ, ДБ зэрэг олон улсын байгууллагуудаас захиалга авч ажиллаж байгаа ба 2006 онд "e-Mongolia үндэсний хөтөлбөр"-т хамрагдах зэрэг МХХТ-ийн салбарт чухал үүрэг гүйцэтгэж байна. Сүүлийн жилүүдэд бий болсон бусад венчур компаниудын гэвэл 2017 онд үүсгэн байгуулагдсан, Финтек зэргийг ажиллуулдаг AND Global, мөн цахим худалдаа эрхэлдэг Shoppy.mn, хиймэл оюун ухаанд суурилсан дуу таних технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Chimege Systems зэрэг програм хангамжийн үйлчилгээний компаниудыг нэрлэж болно. Бусад томоохон харилцаа холбооны компаниуд Мобиком, Юнител, Скайтел болон Датаком нь голлох компаниуд байна.




Эх сурвалж: Судалгааны баг SPEEDA-д үндэслэн боловсруулав.

Зураг 18 МХХТ, цахим үйлдвэрлэлийн задаргаа

(б) МХХТ-ийн үйлдвэрлэлийн орлого, зарлагын тэнцэл


Доорх зурагт харуулсаны дагуу Монгол Улсын орлого, зарлагын тэнцэл нь саяхныг хүртэл алдагдалтай байсан ба гадаад худалдааны тэнцэл ашигтай болсон боловч МХХТ-ийн үйлчилгээг хамарсан үйлчилгээний орлого, зарлагын тэнцэл нь алдагдалтай хэвээр байна.



Эх сурвалж: Монголын үндэсний статистикийн ерөнхий хорооны өгөгдлийг үндэслэн судалгааны баг боловсруулав

Зураг 19 Монголын орлого, зарлагын тэнцлийн өөрчлөлт

Үйлчилгээний тэнцлийн задаргааг харвал 2023 оны үйлчилгээний орлого зарлагын нийт тэнцэлийн авлага(Credit)нь 1,331.5 сая ам. доллар (ойролцоогоор 198.8 тэрбум иен), өглөг (Debit)нь 3,234.91 сая ам.доллар (ойролцоогоор 483 тэрбум иен) байсан бол МХХТ -ийн үйлчилгээг багтаасан "Telecommunications, computer, and information services" -ийн авлага(Credit)нь 43.85 сая ам.доллар (ойролцоогоор 6.5 тэрбум иен), өглөг(Debit)нь 124.89 сая ам. доллар (ойролцоогоор 18.6 тэрбум иен) бөгөөд цэвэр үлдэгдэл 81.04 сая ам.доллар (ойролцоогоор 12.1 тэрбум иен) болж авлага болон өглөг талууд хоёулаа үйлчилгээний нийт тэнцлийн 3 %-иас хэтрэхгүй байна. Үйлчилгээний тэнцлийн дийлэнх хувийг "3. Тээвэр", "4. Аялал" эзэлж байгаа бол өглөг (Debit)талд "10. Бизнесийн бусад үйлчилгээ" (технологи, гадаад худалдаа, бизнесийн бусад үйлчилгээ) үйлчилгээ тэнцлийн алдагдалд нөлөөлж байна.




Эх сурвалж: Монголын үндэсний статистикийн ерөнхий хорооны өгөгдлийг үндэслэн судалгааны баг боловсруулав

Зураг 20 Монголын үйлчилгээний орлого, зарлагын өөрчлөлт

Цаашлаад "9. Telecommunications, computer, and information services"-ийн задаргааг харахад "9.1. Telecommunications services"-ний авлага(Credit)тогтмол өөрчлөгдөж байхад "9.2. Computer services" нь сүүлийн жилүүдэд өссөөр байгааг харж болно. Цаашлаад "9.1. Telecommunications services"болон "9.2. Computer services" -ийн өглөг (Debit)сүүлийн жилүүдэд их хэмжээгээр өсөж Гадаад валютыг олохын тулд МХХТ-ийн үйлдвэрлэлийг гадаадад өргөжүүлэхийн зэрэгцээ дотооддоо МХХТ-ийн үйлчилгээг дотооддоо бүтээж гадаадаас авдаг үйлчилгээг орлуулахыг дэмжих нь чухал гэж үзэж байна.

Service account - Breakdown of Telecommunications, computer, and information services (USD million)



Эх сурвалж: Монголын үндэсний статистикийн ерөнхий хорооны өгөгдлийг үндэслэн судалгааны баг боловсруулав


Зураг 21 Монголын үйлчилгээний орлого, зарлагын доторх харилцаа холбоо, компьютер, мэдээллийн үйлчилгээний өөрчлөлт

(в) E-government

① Засгийн газрын хэрэгжүүлж буй арга хэмжээ


Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яам (хуучнаар Мэдээлэл, харилцаа холбооны технологийн газар (МХТГ))-ын доор одоогийн e-Mongolia-ийн өмнөх үе болох "e-Mongolia үндэсний хөтөлбөр"-ийг 2005 онд эхлүүлсэн. Цахим засаглалыг багтаасан МХХТ-ын програмыг хөгжүүлж МТ-ийн ур чадварыг дээшлүүлэх, PPP-г хөгжүүлэх, МТ -ийн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг бэхжүүлэх зэргийг зорилго болгож тавьсан боловч цахим улс бий болгох талаарх тодорхой үр дүнд хүрээгүй. Үүний дараа 2020 онд "Алсын хараа 2050" -г боловсруулж 2030 он гэхэд технологид суурилсан инновацийг бий болгохыг зорьж байна МХХТ, цахим үйлдвэрлэлийг бэхжүүлэх зорилго тавьж 2024 он хүртэлх хугацаанд захиргааны үйлчилгээний 90%-г цахимжуулахыг зорьж байна. Тус оны 10-р сард "e-Mongolia" платформыг байгуулсан.

e-Mongolia (1) Авлигатай тэмцэх, засаг захиргааны засаглалыг бэхжүүлэх болон (2) өргөн уудам газар нутагт дэд бүтэц сайн хөгжөөгүйгээс болж засаг захиргааны үйлчилгээний хүртээмжгүй байдлыг засах зорилгоор нэвтрүүлсэн. Эстони зэрэг дэвшилтэт туршлага бүхий орнуудтай хамтран ажиллаж байна. Мобайл програм болон вэб хувилбарууд байгаа бөгөөд гадаад паспортын мэдүүлэг,жолооны үнэмлэхний мэдүүлэг зэрэг 2024оны4сарын байдлаар 83 бүртгэлийн байгууллагуудад 994 үйлчилгээг онлайнаар гүйцэтгэх боломжтой.



Эх сурвалж: Судалгааны баг боловсруулав.

Зураг 22 e-Mongolia-гийн түүхэн замнал




Эх сурвалж: Судалгааны баг боловсруулав.

Зураг 23 e-Mongolia Гар утасны програмын дэлгэц(дүрс зураг)


② e-Mongolia-г нэвтрүүлсний үр дүн, ашиглалтын байдал

e-Mongolia -г нэвтрүүлснээр нэвтрүүлэхээс өмнөхтэй харьцуулбал 2022 онд засгийн газрын дотоод зардал болох цаас, шуудан, тээвэр гэх мэтэд зарцуулах зардал, цалин хөлсний зардал нийлээд 30 сая ам.доллараар (ойролцоогоор 4,5 тэрбум иен) буурч, авлига, хээл хахуулийн талаарх гомдол 30 хувиар буурсан гэсэн тооцоо бий. Улмаар өмнө нь 2-3 цаг зарцуулдаг байсан захиргааны үйлчилгээнүүд одоо дунджаар 2-5 минут болж богиноссон байна. Үүний үр дүнд 2021 оны эцсийн байдлаар үйлчилгээний хугацааг жилд 3,581 цагаар бууруулж чадсан. Эдгээр үр дүнгээс харахад захиргааны засаглалыг бэхжүүлэх, захиргааны үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх анхны зорилтуудыг биелсэн гэж хэлж болно.

2023 оны 9-р сарын байдлаар e-Mongolia нь 1.7 сая хэрэглэгчтэй болсон бөгөөд энэ нь нийт хүн амын 51 % орчим нь тус үйлчилгээг хэрэглэж байгаа гэсэн үг болно. Ашиглалтын түвшинг цаашид нэмэгдүүлэх шаардлагатай байгаа ч хэрэглэгчдийн хүн амын давхаргыг харахад 20-30 насныхан голлосон болоод 10-аас 50-иад нас хүртэл өргөн хүрээны хүмүүсийг хамарсан байна. Тодруулбал, ахмад настнуудад захиргааны байгууллагын ажилтнууд хэрхэн ажиллуулахыг зааварлаж, тус үйлчилгээг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. Мөн орон нутгийн ашиглалтын хувьд Улаанбаатар хотын хэрэглэгчтэй харьцуулахад 50:50 харьцаатай байгаа нь захиргааны үйлчилгээний хүртээмж муу бүс нутагт e-Mongolia үйлчилгээ илүү их нэвтэрч байгааг илтгэнэ.



Зураг 24 e-Mongolia-н хэрэглэгчийн насны бүтэц



Зураг 25 e-Mongolia-н хэрэглэгчийг бүс нутгаар харуулсан задаргаа

Эх сурвалж: e-Mongolia Academy-ийн бичиг баримтанд суурилж судалгааны баг боловсруулав.

③ Цахим засаглалын индекс(цахим засаглалын хөгжлийн үзүүлэлт)

UNDESA(НҮБ-н эдийн засаг нийгмийн газар)нь 193 гишүүн орнуудыг хамарсан цахим засаглалын индекс(цахим засаглалын хөгжлийн үзүүлэлт)-г нийтлэсэн. Тус үзүүлэлт нь онлайн үйлчилгээ үзүүлэлт, сүлжээнд холбогдох байдал, хүний чадвар гэсэн 3 талаас цогц үнэлгээг хийдэг. Монгол улс нь 2018 он, 2020 онуудад 92-р байранд ордог байсан бол e-mongolia-ын үйл ажиллагааг эхэлснээс хойш 2022 онд 74-р байр хүртэл дээшилсэн байна. Ийнхүү засгийн газрын e-mongolia-г хөгжүүлэх арга хэмжээ авсны үр дүнд бий болсон цахим засаглал нь Олон улсын хэмжээнд үнэлэгдсэн.

Хүснэгт 16 Монголын цахим засаглалын индексийн өөрчлөлт

2018	2020	2022
92nd out of 193 countries	92nd out of 193 countries	74th out of 193 countries

Эх сурвалж: IT Park-ийн мэдээллийн дагуу судалгааны баг боловсруулав

(г) ICT ба Цахим хүний нөөц

① Иргэдийн цахим иэдлэг чадвар

2018 онд хэрэгжсэн "Монголын МХХТ-ын чадварын судалгаа" -нд компьютер, ухаалаг гар утсаар

мэдээлэл авах чадвартай хүмүүс 31%-д хүрсэн байна¹⁸ гэж дүгнэгдсэн. Нөгөөтэйгээр 2021 оны Үндэсний статистикийн газар(NSO)болон Цахим хөгжил, хөгжлийн яам(хуучнаар мэдээлэл харилцаа холбооны технологийн яам (ICTA))-ны хэрэгжүүлсэн "Өрх болон хувь хүний МХХТ-ийн ашиглалтын байдлын судалгаа"-гаар 43.8% нь интернет ашиглан мэдээллийг цуглуулах, өгөгдлийг хадгалж чаддаг з¹⁹ гэж үнэлэгдсэн байна.

Нөгөөтэйгүүр видео яриа болон текст, мессежээр харилцах чадвартай нь 38.8% байх бөгөөд 27% хүнмүүс нь онлайн банк болон цахим худалдаа хийж чаддаг гэж тодорхойлогдсон бөгөөд аль аль нь 50%-д хүрэхгүй байгаа тул иргэдийн МХХТ-ийн чадвар нь өндөр биш гэж хэлж болохоор байна. Улмаар компьютер ашиглан өгөгдлийн дүн шинжилгээ хийх болон програминг хийж чадах хүний тоо нь 9.4% орчим байна.

Өнөөгийн байдлаас дүгнэхэд, засгийн газар нь иргэдийн ерөнхий МХХТ-ийн чадварыг дээшлүүлэхийг дэмжээд зогсолгүй програминг зэрэг өндөр түвшний чадварыг хөгжүүлэх зорилгоор боловсролын тогтолцоог шинэчлэх, ажил эрхлэгчдэд чадвараа дээшлүүлэх боломжоор хангах шаардлагатай байна.

② Хүний нөөцийн эрэлт хэрэгцээний тэнцвэр, чанар

а). Эрэлт нийлүүлэлтийн тэнцвэр

МХХТ-ийн хүний нөөцийн эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрийн тухайд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас (Ministry of Family, Labor and Social Protection)гаргасан "Хөдөлмөрлөх хүчний эрэлтийн барометр судалгаа (2019)"²⁰ болон Үндэсний статистикийн хорооноос гаргасан (2019)²¹ мэдээгээр 2016 оны байдлаар МХХТ-ийн салбарт ажиллагсдын тоо 11,322, шинээр нээгдэж буй ажлын байрны тоо 1200 байсан бол 2020 онд МХХТ-ийн салбарт ажиллагсдын тоо 13,900, нээлттэй ажлын байрны тоо 1600 байна. Эндээс харахад МХХТ-ийн хүний нөөцийн эрэлт нь жилээс жилд нэмэгдэж байна гэж хэлж болно. МХХТ-ийн хүний нөөцийн хамгамжийн хувьд Их сургууль, Мэргэжлийн сургуульд бэлтгэгдсэн МХХТ-ийн боловсон хүчний тоон мэдээлэл нийтлэгдээгүй боловч Боловсролын Яамнаас лавлахад 2019-2020 оны хичээлийн жилд Их сургуулиас МХХТ-ийн мэргэжлээр 591 төгсөгч, 2022-2023 оны хичээлийн жилд 613 төгсөгч гэх мэтээр ерөнхийдөө нэмэгдэх хандлагатай боловч үсрэнгүй өсөлт харагдаагүй байна. (Нарийвчилсан агуулгыг 0г үзнэ үү). Мөн Боловсролын яамнаас соссноор 2024 оны 4-р сарын байдлаар Их сургуульд МХХТ-ийн мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудын тоо 7,835 байна. Мөн, Япон маягын мэргэжлийн сургуульд 2020 оны үеэс мэдээлэл боловсруулах мэргэжлийн ангийг нээсэн ба 2025 онд анхны төгсөгч нар гарна.

Харин MJЕЕD -ийн тамгийн газар болон Шинжлэх ухаан техникийн их сургууль г.м.-ээс сонсноор бол одоогийн байдлаар МХХТ-ийн салбарын оюутнуудыг ажиллуулах сонирхол их байгаа ба Монголын МХХТ-ийн ААН нь байнга хүний нөөцийн дутагдалтай байна. МХХТ-ын мэргэжлийн болон Их сургуулийн тухайд Их сургуулийн 3-р курсийн оюутнуудыг ААН-үүд ажилд авдаг болсноор сурлага сайтай оюутнууд 3-р курсдээ ажлын байр нь шийдэгддэг болжээ. Ялангуяа ШУТИС гэх мэт МХХТ-ийн мэргэжлийн дотооддоо дээгүүр байр эзлэдэг их сургуулийн оюутнууд ажил хурдан олддог ба ихэнх оюутнууд 4-р курсд орохоос өмнө ажлын байр нь шийдэгддэг байна. Улмаар МХХТ-ийн оюутнууд 2-р курсээс эхэлж компани дээр дадлага хийж байна. Бусад салбарын оюутнуудаас эрт компани дээрх дадлагад оролцож оюутан болон компани аль аль нь эртээс ажлын байр болон хүний нөөцөө хангадаг байна.

б). Хүний нөөцийн чанар


Тус хэсэгт хүний нөөцийн "чанар" -ын тал дээр шинэ төгсөгчдийн МХХТ-ийн чадвар болон компани ажилчдын техник технологийн чадварын тухай хэлэлцэнэ. Шинээр төгсөгчдийн МХХТ-ийн чадварын тухайд 1 дэх удаагийн ажлын байрны яармаг дээр зохион байгуулсан асуулгын үр дүнг үзвэл ААН -ийн 80% нь оюутнуудын чадварын түвшин тэднээс хүлээж байгаа түвшинд хүрч байгаа гэж дүгнэсэн байв.

¹⁸ MDDIC"“Digital Nation”approval guidelines" (2022)

¹⁹ дээрхтэй ижил

²⁰ BAROMETER SURVEY ON LABOR MARKET DEMAND (2019)

²¹ Brief Presentation on ICT Statistics Experiences of Mongolia(2019)



Эх сурвалж: Асуулгын үр дүнг үндэслэн судалгааны баг боловсруулсан.
Зураг 26 АНН-ээс асуулга Ажилд авсан оюутнууд АНН -ийн шаардсан чадвар, туршлагатай байсан уу?(n=11)

Нөгөөтэйгүүр, Монголын МХХТ-ийн групп компани(Mogul Group)-ээс асуухад шинээр төгсөгчдийн МХХТ-ийн чадварыг өндөр гэж хэлж чадахгүй ч ойролцоогоор 2-3 жил ажлын байран дахь сургалтаар практик ажил болон технологийн чадвараас суралцаж өөртөө эзэмшиж авдаг. МХХТ-ийн хүний нөөцийн зах зээлийн хэрэгцээ их байгаатай холбоотойгоор, АНН-үүд нь ажилд авсны дараа ажлын байран дахь сургалаар хүний нөөцийн чадварыг дээшлүүлэх учраас ажилд ороход нь оюутнуудад өндөр технологийн чадварыг шаардахгүй байх нь олонтаа ажиглагдлаа. длгосон.

Хөдөлмөр эрхэлж буй насанд хүрэгчдийн МХХТ-ийн ур чадварын тухайд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хийсэн "Монгол Улсын ур чадварын эрэлтийн судалгаа" (2022) ²²-нд ажилтнуудын ур чадвар дутмаг сөрөг нөлөө үзүүлж байна гэж компаниуд үзэж байгаа ажлуудын дунд программ хангамж боловсруулах ажил, МХХТ-ийн үйлчилгээтэй холбоотой ажлууд 2, 4-р байранд орсон байна. Энэ нь, МХХТ-ийн компаниудад төдийгүй нийт ажил эхрлэгчдийн МХХТ-ийн чадавхи дутмаг, МХХТ-ийн компаниудын дотор ч боловсон хүчний техникийн ур чадвар шаардлагатай түвшинд хүрэхгүй байна гэсэн хоёр зүйлийг харуулж байна.

Тиймээс Монгол дахь МХХТ-ийн хүний нөөцийн чанарын тал дээр шинэ төгсөгчид болон ажил эрхлэж буй хүмүүсийн аль нь ч өндөр гэсэн үнэлэлт авч чадахгүй байгаа ба Монголд АНН-үүд үр ашигтай бизнес явуулахад шаардагдах МХХТ-ийн чадвар дутагдалтай байгаа нь тулгамдсан асуудлын нэг мөн.

(2) Гарааны бизнесийн экосистемийг үүсгэн байгуулах өнөөгийн байдал

Гарааны бизнесийн тоо

Монголын гарааны бизнесийн тоог зөв тодорхойлоход бэрхшээлтэй байгаа боловч гарааны бизнесийн мэдээллийн сан (Pitchbook)болон нийтлэгдсэн тайлангийн тоон утгыг үндэслэн тооцоолвол ойролцоогоор 100 АНН байхаар байна. Доор лавлах материал болох тоон утгыг харуулав.

- Pitchbook дээрх Монголд төв компанитай гарааны бизнесийн тоо: 103 компани(2024 оны 2-сарын 21-ний бадлаар)※биржид бүртгээгүй компани бөгөөд зөвхөн төв компани нь Монголд байгаа компаниудыг түүж авав
- JICA、START(2024)"Baseline survey of the MONGOLIAN STARTUP ECOSYSTEM 2023" -ын судалгаанд хамрагдсан тоо: 91 компани
- JICA、KITE、Mongolian Marketing Consulting Group(2022)"Baseline survey of the Mongolian start-up ecosystem -ийн судалгаанд хамрагдагсдын тоо: 80 компани

²² [Skills Demand in Mongolia \(2022\)](#)

Монголын гарааны бизнесийн гол жишээ

AND Global

- Хөрөнгө босгох: А цувралын санхүүжилтийг хийж хөрөнгө оруулагчид Монголоос гадна гадаадын хөрөнгө оруулагчдаас санхүүжилт авсан(SBI инвэстмэнт, Марүбэни г.м.)
- Гадаадад зах зээлээ тэлэх: Шинээр хөгжиж буй голдуу 12 улс оронд зах зээлээ тэлсэн, Marubeni America корпорацитай 2024 оны 2-р сард санамж бичигт гарын үсэг зурсан.



Зураг 27 SBI хөрөнгө оруулалтын хэвлэлийн мэдээ




Зураг 28 Марүбэни Америкийн компанитай санамж бичигт гарын үсэг зурсан байдал

Эх сурвалж: [AND Global хэвлэлийн мэдээ](#)

Экосистемийн үзүүлэлт

"Global Startup Ecosystem Index²³"-н 2023 оны хэвлэлээр бол Монголын гарааны бизнесийн экосистем нь 100 орны 79-р байрыг эзлэж байгаа ба эзлэсэн байр нь жилээс жилд дээшилж байна.



Эх сурвалж: "Global Startup Ecosystem Index"

Зураг 29 Global Startup Ecosystem Index-дахь Монголын ангилал

(3) Нээлттэй өгөгдлийн ашиглалтын өнөөгийн байдал

(a) Нээлттэй өгөгдлийн ашиглалт

Судалгаагаар монголын дотоод дахь засгийн газрын нээлттэй өгөгдлийг нээлттэй өгөгдлийн портал зэргээр дамжуулан хоёрдогч ашиглалт хийж бизнес болгож чадсан тохиолдол харагдсангүй. Таамаглаж болох хэд хэдэн хүчин зүйлс байж болох ба (1)Монголын засгийн газар болон холбогдох байгууллагуудын ажиллуулдаг нээлттэй өгөгдлийн портал зэргийн өгөгдлийн каталог нь ашиглахад бэрхшээлтэй, нөөцөлсөн өгөгдөлд шинэлэг чанар байхгүй тул хувийн хэвшлийн АНН нь бизнес болгоход ашигтай мэдээллээ тодорхойлж чадахгүй, (2)нээлттэй өгөгдлийн ашиг тус болон үр өгөөжтэй ашиглах аргыг хувийн хэвшил нь ойлгоогүй зэрэг асуудлыг дурдаж болно. (1)-ны хувьд засгийн газар болон холбогдох байгууллагын дотоодын МХХТ-ийн хүний нөөцийн чадвар хангалтгүйгээс болж өгөгдлийн каталогыг хувийн хэвшлийн байгууллагуудад ашиглахад амар хялбар болгож хийгээгүйгээс шалтгаалсан байна. Энэ талаар MDDIC мөн онцолж, MDDIC-ийн Нээлттэй мэдээллийн хакатон тэмцээний менежер хэлэхдээ, "Монголд нээлттэй мэдээллийн каталог анхан шатандаа байгаа тул нээлттэй мэдээллийн порталыг ашиглахад хялбар болгоход дэмжлэг үзүүлэхийг хүсч байна" гэлээ. (2)-ийн тухайд, нээлттэй өгөгдлийн бизнесийн үр ашгийг хувийн хэвшлийн АНН-дэд уриалах хэмжээний засгийн газар болон хувийн компаниудын хоорондын холбоо байхгүйгээс болж байна гэж үзэж болно.

²³ StatupBlink компани жил болгон гаргадаг тайлан. Улс бүр, хот тус бүрийн гарааны бизнесийн экосистемийг "Quantity Score", "Quality Score", "Startup Business Environment"-ын үүднээс дүн шинжилгээ хийж ангилал тогтоосон байна.

Бодит байдал дээр Эстони улсын туршлагаар 2018 оноос хойш хувийн хэвшилд зориулсан нээлттэй өгөгдлийн хэрэглээ ихэссэнээр хувийн хэвслүүдийн бизнес болгосон тохиолдлууд нэмэгдэж семинар болон кейс судалгаа, хакатон гэх мэт хэлбэрээр засгийн газар хувийн хэвшлийн хоорондох харилцааг идэвхжүүлснээр хувийн хэвшлийн нээлттэй өгөгдлийг бизнесд зориулж хэрэглэсэн тохиолдлыг бий болгох эхний алхам гэж хэлж болно. Мөн, 2023 онд MDDIC-ээс зохион байгуулсан нээлттэй дата хакатон нь өргөдөл гаргагч байхгүйн улмаас цуцлагдсан нь хувийн компаниудын сонирхол бага байгааг харуулж байна. Дээр дурдсан (1) (2)-ын таамагласан хүчин зүйлийг баталгаажуулахын тулд хакатон ба PoC-ийн үр дүнг 7-р бүлэгт нэгтгэлээ.

Монгол дахь нээлттэй мэдээллийн ашиглалтын байдлын талаарх MDDIC-ээс өгсөн тайлбарыг бид энд лавлагаа болгон орууллаа.

Хүснэгт 17 MDDIC-ээс гаргасан Монгол дахь нээлттэй мэдээллийн ашиглалтын талаарх

МЭДЭГДЭЛ

Although the opening of government data itself is already being carried out through government agency websites such as "1212.mn," private companies do not understand how to utilize government open data for business purposes.	MDDIC (June 7, 2023)
To promote the digital economy, we aim to open and utilize not only government data but also private sector data. We are currently in the process of obtaining consent for the utilization of corporate data.	MDDIC (June 7, 2023)
There are particular challenges in the opening and effective utilization of public data in rural areas.	MDDIC, Department of Policy and Planning (October 27, 2023)

(б) Өгөгдөл уялдуулах платформын ашиглалт

3-р бүлгийн 2-р хэсэг. (3)-д дурдсанчлан E-Mongolia нь ХҮР нэртэй өгөгдөл уялдуулах платформор дамжуулан хувийн хэвшлийн АНН-дэд төрийн болон захиргааны мэдээллийг ашиглах боломжийг олгоно. E-Mongolia Academy-иас авсан ярилцлагаас харахад, ашигласан жишээ гэвэл банк, бичил санхүүгийн байгууллага зэрэг санхүүгийн байгууллагууд ХҮР-г ашиглан зээлийн нөхцлийг статусыг ойлгож, зээлийн шинжилгээнд ашигладаг жишээнүүд байна. Мөн үл хөдлөх хөрөнгийн өмчлөлийн байдлыг мэдэж, нийгмийн даатгалын шимтгэлийг төлүүлэхэд ашигласан тохиолдол бий.

Нээлттэй өгөгдлийг үр дүнтэй ашиглах жишээ олдоогүй ч өгөгдлийн уялдааны платформд дээр дурдсанчлан өгөгдлийн интеграцийн платформыг ашигласан зарим жишээнүүд энд тэнд харагдсан. Ийм ялгаатай байдлын шалтгаан нь нэгдүгээрт, үйлчилгээ тус бүрийн зорилгын ялгаа, хоёрдугаарт, өгөгдөл нь нээлттэй эсвэл хаалттай байхаас шалтгаалж боловсруулах өгөгдөл ялгаатай байна уу даа гэж бодогдлоо. Эхний зүйлийн тухайд, нээлттэй өгөгдлийг ашиглах зорилго нь төрийн мэдэлд байгаа мэдээллийг олон нийтэд нээлттэй болгож, хувийн хэвшлийн компаниудад ашиглах боломжийг олгох явдал юм. Гэхдээ өгөгдлийг хэрхэн ашиглах нь хувийн хэвшлийн компаниудын санаачлагаас хамаарна. Нөгөөтэйгүүр, өгөгдлийг уялдуулах платформууд нь одоо байгаа хувийн хэвшлийн үйлчилгээнд олон нийтийн мэдээллийг нэгтгэснээр үйлчилгээг сайжруулах зорилготой ба өгөгдлийг ашиглах арга нь ихэнх тохиолдод урьдчилан тодорхой болсон байдаг. Хоёрдахь зүйлийн тухайд, өгөгдөл уялдуулах платформор холбогдсон өгөгдөл нь хаалттай байдаг ба энэ нь ихэвчлэн хувийн мэдээллийг агуулсан тодорхой өгөгдөл байдаг тул эдгээрийг хувийн хэвшлийнхний үйлчлүүлэгчдийн өгөгдөлтэй холбож нэгтгэх нь хялбар.

4-р бүлэг Судалгааны чухал салбаруудыг нарийвчлан тодорхойлох

4-р бүлэгт Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэх бодлого болон ЛСА-гийн тусламжийн саналыг хэлэлцэх үед илүү төвлөрсөн судалгаа шаардлагатай салбаруудыг тодорхойлно. Асуудлыг цэтгэлэх бодит дарааллын хувьд нэгтгээрт 3-р бүлэгт судалсан тус бүрийн судалгааны зорилъ болон өнөөдрийн байдлын зөрөө ялгааны дүн шинжилгээ хийж асуудлыг тогтоох. 2-рт, асуудал тус бүрийг дараах 3 тулгуур хэмжээс болон үзэл бодлоос нь үнэлгээ хийж тэдгээрийн үр дүг үндэслэн тус асуудлын түвшинг(том, дунд, жижиг)тодорхойлно.

Хүснэгт 18 Асуудлын цар хүрээг тогтоох үнэлгээний үзүүлэлт

Цаг хугацааны тэнхлэг	Үнэлгээний байр суурь
Стратегийн хувьд хэр чухал болох(их, дунд, бага)	Тухайн асуудлыг шийдвэрлэснээр МХХТ үйлдвэрлэл, гарааны бизнесийн хөгжилд хэрхэн нөлөө үзүүлэх вэ? Тоон үзүүлэлтээр үнэлэхэд хүндрэлтэй үзүүлэлт тул чанараар үнэлэх болно.
Асуудлын ноцтой байдал(их, дунд, бага)	Тухайн асуудал нь хэр ноцтой болох? Тоон үзүүлэлтээр хэмжиж болох ч одоогийн байдал нь зорилтын 50%-д хүрээгүй бол асуудал том, 50% -иас дээш 75 %-иас бага бол дунд, 75%-иас их байвал асуудал бага гэж үзнэ. Тоон үзүүлэлтээр хэмжих боломжгүй зүйлүүдийг чанараар үнэлнэ.
Асуудлыг шийдвэрлэхийн тулд одоо авч байгаа арга хэмжээ(байна, байхгүй)	Монголын засгийн газар болон хөгжлийн түншүүдээс одоо хийгдэж байгаа арга хэмжээ байгаа эсэх, эсвэл стратегийн үүднээс хойшид хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа арга хэмжээ байгаа эсэх.

Жишээлбэл одоо хэрэглэж байгаа арга хэмжээ "байгаа" ч тэдгээрийн хэрэгжилтийн хэмжээ харилцан адилгүй байна. Тиймээс тухайн асуудлын эцсийн үнэлгээг хийхдээ стратегийн хувьд чухал байдал, асуудлын ноцтой байдал, асуудлыг шийдвэрлэхийн тулд одоогоор хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байгаа эсэх зэргийг цогцоор нь харж байж, судалгааны баг болон ЖАЙКА-ийн холбогдох хүмүүстэй хэлэлцсэний үндсэн дээр эцсийн үнэлгээг гаргасан. Үнэлгээ хийх зарчим 3-р шатны хувьд ч гэсэн ижил байна.

3-рт, том юмуу дунд гэж үнэлэгдсэн асуудлуудыг одоо хамтарч буй хөгжлийн түнш байгаа эсэх болон Японы тусламжийн нөөц байгаа эсэхээс хамааран, цаашид Монголын засгийн газар болон ЛСА-гийн шинээр бодлого хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх боломжтой салбар мөн эсэхийг тодорхойлно. Тус салбарыг судалгааны чухал салбарт тооцож 5-р бүлэгд гүнзгийрүүлсэн судалгааг хийх болно:

1. МХХТ, Цахим үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь

(1) МХХТ, цахим үйлдвэрлэлийн зах зээл

МХХТ, цахим үйлдвэрлэлийн бүтэц тус бүрийн тулгамдаж буй асуудлыг авч үзэхээс өмнө, МХХТ, цахим үйлдвэрлэлийн зах зээлийн ерөнхий байдлыг, зах зээлийн өсөлтийн хувь, зах зээлийн хэмжээ, зах зээлийн ДНБ -д харьцуулсан харьцаа гэсэн 3 үзүүлэлтээр тодорхойлно.

(а) Асуудал

МХХТ-ийн зах зээлийн өсөлтийн хувь нь 2020 оны байдлаар 12% байх бөгөөд 2027 он хүртэлх хугацаанд 25% болгохыг зорьж байна.²⁴ Нөгөөтэйгүүр МХХТ-ийн үйлдвэрлэлийн зах зээлийн хэмжээ нь Монгол улсын үндэсний статистикийн ерөнхий газрын мэдээгээр 2022 оны байдлаар 1.7 их наяд төгрөг(ойролцоогоор 73 тэрбум иен)байгаа ба цаашдын зорилтот үзүүлэлтийг тогтоогоогүй байна.

Улмаар, бусад аж үйлдвэрлэлтэй харьцуулсан МХХТ-ийн шийдвэрлэх асуудал нь ДНБ-д харьцуулж харвал ойлгомжтой байдаг. МХХТ-ийн зах зээлийн ДНБ-д харьцуулсан харьцаа нь 2022 оны байдлаар дөнгөж 2%, бусад аж үйлдвэрүүдтэй харьцуулахад ч маш бага байна (Нарийвчилсан мэдээллийг 3-р бүлгийн 3.1)-ээс үзнэ үү. Мөн Vision2050-дээр 2050 хүртэлх хугацаанд ДНБ-д эзлэх харьцааг аж үйлдвэрлэл нь 10.9%-иас 27.4%-д, тээвэрлэлт нь 4.6%-иас 11.6%-д хүргэхээр зорьж байна. Харин МХХТ-ийн үйлдвэрлэлийн хувьд зорилтот тоон үзүүлэлтийн талаар дурдагдаагүй байна. Эдгээр зүйлсийг

²⁴ MDDIC""Digital Nation"approval guidelines" (2022)

үндэслэн нийт МХХТ-ийн үйлдвэрлэлийн шийдвэрлэх асуудал нь ДНБ-д эзлэх харьцаа маш бага байгаагын дээр бусад үйлдвэрлэлүүдээс ялгаатай тал нь тодорхой зорилтыг тогтоогоогүй байгаад оршино.

Үйлдвэрлэлийн хөгжлийн хувьд, зорилт нь тодорхой биш байвал чиглэх чиглэлийг шийдэх боломжгүй болж тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна. Тиймээс зорилтыг тодорхой болгож түүнийг биелүүлэхэд чиглэсэн төлөвлөгөөг боловсруулах нь чухал бөгөөд стратегийн хувьд ч чухал гэсэн үнэлгээ авна. Одоогийн байдлаар МХХТ-ийн нийт үйлдвэрлэл, МХХТ-ийн хүний нөөцийн хөгжил, Гарааны бизнесийн хөгжүүлэлт, нээлттэй өгөгдлийн ашиглалт тус бүрийн зорилтыг тодорхойлоогүй, шийдвэрлэх асуудлын ноцтой байдал нь "их" гэсэн үнэлгээтэй байна. Одоо хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухайд, Олон улсын худалдааны төв(International Trade Centre:ITC)-ийн дэмжлэгээр Эдийн засгийн хөгжлийн яам(Ministry of Economy and Development) нь Уул уурхайн бус тэргүүлэх салбарын Үндэсний экспортын стратеги (National Export Strategy for Prioritized Non-Mining Sectors, хойшид NES гэх)-г боловсруулж байна. NES-д хамруулж байгаа 6 салбар²⁵-ын 1-рт Мэдээллийн технологийн үйлчилгээний экспортын стратеги (цаашид Экспортын стратеги гэх)орно (бусад 5 салбар нь Adventure and cultural tourism, Cashmere and other wool, Meat and meat products, Leather and leather products, Sea buckthorn and pine nuts). Энэхүү Экспортын стратегийг Эдийн засгийн хөгжлийн яам, MDDIC-тэй хамтран боловсруулсан бөгөөд боловсруулалтын явцад мэдээлэл технологийн парк, програм хангамжийн холбоод зэрэг холбогдох байгууллагуудын саналыг цуглуулсан.²⁶ Энэхүү Экспортын стратеги нь иж бүрэн агуулгатай бөгөөд MDDIC одоогоор ерөнхий төлөвлөгөөгүй байгаа энэ үед МХХТ, цахим салбар дахь төрийн бодлого, цаашдын санаачилгыг тодорхойлсон чухал стратеги гэж үзэж байна. Нөгөө талаар тус Экспортын стратеги нь анхнаасаа экспортод чиглэсэн стратеги байна. МХХТ-ийн үйлдвэрлэлийн хөгжилд шаардагдах бүх арга хэмжээнүүд нь экспортыг голлох үед бүгд багтах боломжгүй байдаг. Тиймээс MDDIC нь МХХТ-ийн салбарыг дэмжих стратегийг бий болгоход манлайлах шаардлагатай гэж үзэж байна.

²⁵ ITC Веб сайт "[Mongolia: National Export Strategy](#)" (2024 оны 7-р сарын 2-ны өдрийнхийг үзнэ үү)

²⁶ Мэдээлэл технологийн паркаас авсан Монголын МТ-ийн үйлчилгээний Экспортын стратегийн төсөл (2023 оны 10-р сарын байдлаар)

**Хүснэгт 19 Алхам 1. Асуудлыг нарийвчлан тодорхойлох
(МХХТ, цахим үйлдвэрлэлийн зах зээл)**

Зүйл	Зорилт болон өнөөгийн байдлын зөрүү			Асуудал	Асуудлын үнэлгээ			Үнэлгээний үр дүн: Асуудлын хүрээ (том/дунд/жижиг)
	Зорилт	Өнөөгийн байдал	Нөөц		Стратегийн чухал байдал (том /дунд /жижиг)	Асуудлын хүндрэлтэй байдал (том /дунд /жижиг)	Одоо хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байгаа эсэх (Байна/байхгүй)	
МХХТ-ийн орлогын өсөлт	25% 2027 он	12% 2020 он	Зорилт/Одоогийн нөхцөл байдал : Цахим үндэстэн	- МХХТ-ийн үйлдвэрлэлийн ДНБ нь бусад бизнесийн салбаруудадтай харьцуулахад маш доогуур байна. - Бусад бизнесийн салбаруудаас ялгаатай тал нь зорилтуудыг тогтоогоогүй.	Их: Аж үйлдвэрийн салбарын хөгжилд зорилтыг тодорхойлоос гадна түүнийг биелүүлэхэд чиглэсэн төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай.	Их: МХХТ үйлдвэрлэл, хүнийн нөөц, гарааны бизнес, нээлттэй өгөгдөлийн олон салбар зорилтгүй байна.	Байна: Экспортын стратеги боловсруулах(Экспортын стратеги нь цогц агуулгатай ч угтаа бол экспортод тулгуурласан стратеги)	Их
МХХТ үйлдвэрлэлийн хэмжээ	- (нөхцөл тавиагүй)	1.7 их наяд төгрөг(Ойролцоогоор 73 тэрбум иен) 2022 он	Одоогийн байдал: Монгол улсын үндэсний статистикийн газар					
МХХТ-н зах зээлийн ДНБ-д эзлэх хувь	- (тохиргоо байхгүй. МТ парк нь 5%-г зорьж байгаа боловч хугацаа нь тодорхой биш)	2% 2022 он	Зорилт: ТМ паркын 3-р ажлын хэсгээс танилцуулсан материал Өнөөгийн байдал: Монгол улсын үндэсний статистикийн газар					

(б) Монголын засгийн газар болон Жайка-гийн дэмжлэгийг тусгах судалгааны чухал салбарууд

МХХТ үйлдвэрлэл нь одоохондоо зах зээл жижиг бөгөөд зорилтын утга нь тогтоогдоогүй гэсэн асуудлыг шийдвэрлэхэд мастер төлөвлөгөө боловсруулах нь нэгэн шийдэл болно. Мастер төлөвлөгөө боловсруулахад MDDIC нь хэдийгээр МХХТ-ийн салбарыг хөгжүүлэхэд чиглэгдсэн мастер төлөвлөгөө биш ч гэсэн өмнө дурдсанчлан Мэдээллийн технологийн зөвлөх (ИТС) нь хөгжлийн түншээр ажиллаж, Экспортын стратегийг боловсруулахад дэмжлэг үзүүлж байна.

Хүснэгт 20 Алхам 2. Монголын засгийн газар болон Жайка-гийн дэмжлэгийг тусгах судалгааны чухал салбаруудыг нарийвчлан тодорхойлох (МХХТ, цахим үйлдвэрлэлийн зах зээл)

Зүйл	Асуудал	Асуудлыг шийдвэрлэхэд ЖАЙКА-гийн тусламж шаардлагатай эсэх/боломжтой эсэхийг судлах		Үнэлгээний үр дүн: Судалгааны чухал салбар
		Хөгжлийн түнш байгаа эсэх	Японы дэмжлэгийн эх үүсвэртэй эсэх	
МХХТ-ийн зах зээлийн өсөлтийн эзлэх хувь	- МХХТ-н үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь бусад бизнесийн салбаруудтай харьцуулахад маш доогуур байна. - Бусад биенесийн салбаруудаас ялгаатай тал нь зорилтоо тогтоогоогүй явдал юм.	Байгаа: - ИТС(Экспортын стратеги боловсруулалт) - UNDP(Цахим үндэстэн санаачлагыг хэрэгжүүлэхэд зориулсан стратегийн түншлэлийг байгуулав.)	Байгаа: ЖАЙКА-гийн мастер төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг авсан туршлагатай	Судалгааны чухал салбарууд
МХХТ-н үйлдвэрлэлийн зах зээлийн хэмжээ				
МХХТ-ийн зах зээл ДНБ-н эзлэх хувь				

(в) Монголын засгийн газар болон ЖАЙКА-гийн дэмжлэгийн чиглэл

2 дахь үе шат хүртэлх хэсгийн агуулгыг цэгцлэсний үндсэн дээр МХХТ, цахим үйлдвэрлэлийн зах зээлийг хөгжүүлэх асуудлын нийтэд хамрах Жайка-гийн дэмжлэгийг санал болгож дараах хүснэгтэд харуулсанчлан мастер төлөвлөгөөг боловсруулах нь үр дүнтэй гэж үзэж байна. Мастер төлөвлөгөөг боловсруулах талаар MDDIC- ээс "Мастер төлөвлөгөө бол зайлшгүй шаардлагатай ч МХХТ-ийн салбар гэх технологийн хурдацтай дэвшил нь хурдацтай өөрчлөлтийг туулж буй салбарт бол мастер төлөвлөгөөний оронд хэрэглэдэг тав, арван жилийн урт хугацааны төлөвлөгөө нь тохиромжгүй ба хэд хэдэн жилийн хугацаатай богино хугацааны төлөвлөгөөгөө хэрэгжүүлэнгээ цаашид шинэчилж байх нь илүү тохиромжтой" гэсэн тайлбар ирэв. Тиймээс энэ удаагийн мастер төлөвлөгөөг богино хугацааны бөгөөд тодорхой үйл ажиллагаа, болон хэрэгжилтийн тогтолцоог тодорхой болгосон үйл ажиллагааны төлөвлөгөөтэй ижил агуулгатай төлөвлөгөө байхаар төсөөлж байна. Мөн Экспортын стратегитай хэрхэн уялдан ажиллах , мөн үүргээ хувиарлах нь чухал.

Хүснэгт 21 Алхам 3. Монголын засгийн газар болон ЖАЙКА-гийн дэмжлэгийн чиглэл(МХХТ, цахим үйлдвэрлэлийн зах зээл)

Зүйл	Үнэлгээний үр дүн		ЖАЙКА-гийн дэмжлэгийн чиглэл			
	Асуудлын цар хүрээ	Судалгааны чухал салбарууд	Дэмжлэгийн цэс	Гол үйл ажиллагаа	Таамагласан схем	Түнш
МХХТ-ийн зах зээлийн өсөлтийн хувь	Их	чухал салбар	МХХТ, цахим үйлдвэрлэлийн хөгжлийн мастер төлөвлөгөөг боловсруулах	- Цогц МХХТ, цахим үйлдвэрлэлийн хөгжлийн мастер төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлэх(гараны бизнес хөгжүүлэлтийг оролцуулах) - Холбогдох байгууллагууд хоорондын үүрэг хуваарилалтыг тодорхойлох - Үйл ажиллагааг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгох	Хөгжлийн төлөвлөгөөний судалгааны хэлбэрийн техникийн хамтын ажиллагаа	MDDIC
МХХТ-ийн зах зээлийн хэмжээ						
МХХТ-ийн зах зээл ДНБ-нд эзлэх харьцаа						

(2) Цахим худалдааны баланс

Гадаад валютын орлого нь ашигт малтмалаас хараат байгаа ба энэ байдлаас гарах нь Монгол улсын хувьд том асуудал бөгөөд түүний нэг том тулгуур болох МХХТ, цахим үйлдвэрлэлийн гадаад дахь нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, дэмжлэг үзүүлэх чиглэлийг Дижитал худалдааны баланс²⁷ аас тодруулж болно.

(a) Асуудал

Судалгааны үед Монголын засгийн газарт цахим худалдааны балансын зорилтот утга байгаагүй, Экспортын стратегид цахимтай холбоотой арилжааны мэдээг цуглаалах хувийг дээшлүүлэх нь цаашид хийх үйл ажиллагаанд орсон бөгөөд асуудлын шийдлэг нарийвчлан тодорхойлох нь цаашдын асуудал болж байна. Нөгөөтэйгүүр одоогийн байдлаар олж авах боломжтой Урсгал дансны үлдэгдэлийг ашиглаж аль болохоор цахим худалдааны балансыг тооцож болох бөгөөд 2023 оны байдлаар баланс нь 616 сая USD(ойролцоогоор 91.9 тэрбум иен)-ий алдагдалтай байна.

Монголын эдийн засагт гадаад валютын орлого нь ашигт малтмалын хараат байдалтай байгаа ба үүнээс гарах нь том асуудлын нэг бөгөөд шинэ экспортын үйлдвэрлэлийн тулгуурыг бий болгох нь стратегийн хувьд маш сулал юм. Одоогийн байдлаар урсгал дансны үлдэгдэл(зээл)-д эзлэх гадаад худалдааны баланс(зээл: ашигт малтмал нь ихэнх хувийг эзлэж буй)нь 94% орчим байгаа бөгөөд ашигт малтмалын хараат байдал ноцтой хэмжээнд байна.

Эдийн засгийн хөгжлийн яамны удирдсан Экспортын стратегийг боловсруулах, АНУ-ын баруун эрэгд төв нь байдаг Төв ази, Монгол гаралтай Бизнес эрхлэгчын нийгэмлэг болох Торгоны зам инновацийн төвтэй хамтрах зэрэг МХХТ, цахим үйлдвэрлэлийн гадаадын зах зээлд нэвтрэх арга хэмжээ 2023 оноос

²⁷ Үйлчилгээний балансын задаргаан дотор "Charges for the use of intellectual property" "Telecommunications, computer, and information services" "Other business services" -уудын нийт дүн

эхэлсэн байгаа ба одоохондоо хэрэгжсэн арга хэмжээний тоо олон биш байна.

Тиймээс асуудлын үнэлгээний хувьд "том" гэж үзээд тэргүүний ээлжинд хэрэгжүүлэх асуудал гэж бодож байна.

Хүснэгт 22 Алхам 1. Асуудлыг нарийвчлан тодорхойлох(Цахим худалдааны тэнцэл)

Зүйл	Зорилт болон өнөөгийн байдлын зөрүү			Асуудал	Асуудлын үнэлгээ			Үнэлгээн ий үр дүн: Асуудлын хүрээ (том/дунд /жижиг)
	Зорилт	Өнөөгийн байдал	Нөөц		Стратегийн чухал байдал (том /дунд /жижиг)	Асуудлын хүндрэлтэй байдал (том /дунд /жижиг)	Одоо хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байгаа эсэх (Байна/байхгүй)	
Цахим худалдааны тэнцэл	- (тохиргоо байхгүй ※ Экспортын стратегид мэдээ цуглуулах хувийг нэмэгдүүлэх нь үйл ажиллагаанд багтаж байна.)	•Тэнцэл: 616 сая USD(91,9 тэрбум иен)-ын алдагдал •Дебит тал: 803 сая USD(119,8 тэрбум иен) •Зээлийн тал: 186 сая USD(27.7 тэрбум иен) (1.5%) (2023 он, % нь урсгал дансны тэнцэл)	Өнөөгийн байдал : Монгол улсын үндэсний статистик газар, Төв банк	•МХХТ-ийн хүний нөөцийн хомсдол •Гадаадын зэх зээлд гарч бизнес эрхлэхэд санхүүжилт дутагдалтай •Монголын МХХТ-ийн брэнд дэлхийд танигдаагүй •МХХТ-ийн үйлдвэрлэлтэй холбоотой статистик хангалттай биш	Их: Гадаад валютыг олж авахад ашигт малтмалын хараат байдлаас гарах нь том асуудал	Их: Одоогийн байдлаар урсгал дансны(дебит тал)эзлэх гадаад худалдааны үлдэгдэл(зэвгийн тал: ашигт малтмал ихэнх хувийг эзэлдэг)нь 94% орчим байгаа бөгөөд ашигт малтмалын хараат байдлын хувь өндөр байна	Байна: Экспортын стратеги боловсруулах, Silkroad Innovation Hub-тай хамтран ажиллаж байна	Их

(б) Монголын засгийн газар болон Жайка-гийн дэмжлэгийг тусгах судалгааны чухал салбарууд

Дижитал худалдааны баланс болон МХХТ, цахилгаан үйлдвэрлэлийг гадаадын зах зээлд гаргахад дэмжлэг үзүүлэхэд үүсэх асуудал бол МХХТ-ийн хүний нөөцийн хомсдол, гадаадын зах зээлд гарахад хэрэглэх санхүүжилтийн дутагдал, Монголын МХХТ нь хангалттай танигдаагүй, МХХТ үйлдвэрлэлтэй холбоотой статистикийн мэдээ хангалттай бус зэргийн асуудлыг дурдаж болно.

Энэхүү асуудлын талаар МХХТ нь Экспортын стратегийг боловсруулахад дэмжлэг үзүүлж, EBRD нь хурдасгах хөтөлбөрийн хүрээнд зарим компанид гадаадын зах зээлд гарахад нь дэмжлэг(голдуу Европын орнууд) үзүүлж байна. Дэмжлэг үзүүлэхэд Японы талд ашиглах эх үүсвэр гэвэл гадаадын зах зээлд гарч ажиллах тогтолцоо бий болгох, гадаадад нэрийн бараагаа таниулах, хүний нөөцийг хөгжүүлэх, статистикийн тогтолцоог сайжруулах зэрэг өргөн хүрээн салбарт дараах хүснэгтэнд бичигдсэн байгууллагуудыг ашиглах боломжтой.

Хэдийнгээр асуудал том боловч өнөөдрийн байдлаар хөгжлийн түншүүдийн дэмжлэг цөөхөн бөгөөд харин Японы талд хэд хэдэн эх үүсвэртэй байгаа тул цахим худалдааны тэнцлийг сайжруулах нь судалгааны чухал салбар болно гэж бодогдож байна.

Хүснэгт 23 Алхам 2. Монголын Засгийн газар болон Жайка-гийн дэмжлэгийг тусгах судлагааны чухал салбарыг сонгох (Цахим худалдааны тэнцэл)

Зүйл	Асуудал	Асуудлыг шийдвэрлэхэд ЖАЙКА-ийн тусламж шаардлагатай эсэх/боломжтой эсэхийг судлах		Үнэлгээний үр дүн: Судалгааны чухал салбарууд
		Хөгжлийн түнш байгаа эсэх	Японы дэмжлэгийн эх үүсвэртэй эсэх	
Цахим худалдааны тэнцэл	• МХХТ-ийн хүний нөөцийн хомсдол • Гадаадын зэх зээлд гарч бизнес эрхлэхэд санхүүжилт дутагдалтай • Монголын МХХТ-ийн бренд дэлхийд танигдаагүй • МХХТ-тай холбоотой статистикийн мэдээлэл хангалттай биш	Байна: ИТС(Экспортын стратеги боловсруулах), EBRD-н хурдасгах хөтөлбөр(Star Venture)	Байна : • МХХТ, цахим үйлдвэрлэлийн гадаадын зах зээл дэх тэлэлтэнд дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгох болон олонд таниулах(брендинг зэрэг): Японы Эдийн засаг, худалдаа,аж үйлдвэрийн яам болон JETRO-ийн J-Startup-аар баталгаажсан арга хэмжээг гүйцэтгэх зэрэг • МХХТ, цахим үйлдвэрлэлийн гадаадын зах зээлд гарахад шаардагдах хүний нөөцийг хөгжүүлэх: DXCUP-аар хамтардаг JDLA, ЖАЙКА-ийн өвсний үндсэний техникийн хамтын ажиллагааны хүрээнд аж үйлдвэрийн DX хүний нөөцийг хөгжүүлж байгаа Нагаока Коосэн г.м. • МХХТ, цахим үйлдвэрлэл болон гадаадын экосистемтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх: Шинагава дүүрэг зэрэг Японы орон нутгийн байгууллагууд • МХХТ, цахим үйлдвэрлэлтэй холбоотой статистикийн мэдээллийг бүрдүүлэх: Цахим худалдааны тэнцлийг тооцдог Японы Дотоод хэрэг, харилцаа холбооны яам г.м.	Судалгааны чухал салбар

(в) Монголын засгийн газар болон ЖАЙКА-гийн дэмжлэгийн чиглэл

Цахим худалдааны тэнцлийг сайжруулж, МХХТ, цахим үйлдвэрлэлийг гадаадын зах зээлд гарахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хувьд дараах хүснэгтэд харуулсанчлан асуудал тус бүрийн дагуу 5 үр дүнд хүрэхийг зорьсон техникийн хамтын ажиллагааны төслийг боловсруулсан. Түнш нь цахим салбарыг бүхэлд нь хянадаг MDDIC болон цахим салбарыг гадаадад өргөжүүлэх үүрэгтэй МТ парк байх төлөвтэй байна.

Хүснэгт 24 Алхам 3. Монголын Засгийн газар болон ЖАЙКА-гийн дэмжлэгийн чиглэл(цахим худалдааны тэнцэл)

Зүйл	Үнэлгээний үр дүн		ЖАЙКА-ийн дэмжлэгийн чиглэл			
	Асуудлын цар хүрээ	Судалгааны чухал салбар ууд	Дэмжлэгийн цэс	Гол үйл ажиллагаа	Таамагла сан схем	Түнш
Цахим худалдааны тэнцэл	Их	чухал салбар	Монголын МХХТ, цахим үйлдвэрлэлийн гадаадын зах зээл дэх тэлэлтийг дэмжих төсөл	- Монголын МХХТ, цахим үйлдвэрлэлийн гадаадын зах зээл дэх тэлэлтийг дэмжих тогтолцоог бий болгох(Ажлын хэсэг байгуулах г.м.) - Монголын МХХТ, цахим үйлдвэрлэлийг олон нийтэд таниулах (Брэндийнг г.м.) - Монголын МХХТ, цахим үйлдвэрлэлийн гадаадын зах зээл дэх тэлэлтэнд хувь нэмэр оруулж чадахуйц хүний нөөцийг бэлтгэх (Технологийн болон бизнесийн аль ч чиглэлийн сургалт г.м.) - Монголын МХХТ, цахим үйлдвэрлэлийн гадаадын экосистемтэй холбогдох үйл ажиллагааг дэмжих(MoU байгуулах, Японд урих, бизнесийн тохироо хийх гэх мэт) - Монголын МХХТ, цахим үйлдвэрлэлтэй(ялангуяа гадаад орнуудтай арилжаа хийх)холбоотой статистикийн мэдээллийг бүрдүүлэх	Техникийн хамтын ажиллагааны төсөл	MDDI С, МТ парк, Үндэсний статистикийн хороо, Монголын төв банкны статистикийн судалгааны газар

(3) Цахим засаглал

(а) Асуудал

Цахим засаглал дахь асуудлын талаар,(1)захиргааны үйлчилгээг цахимжуулах, (2)цахим засаглалын индексийн 2 үзүүлэлтээс дүн шинжилгээ хийнэ.

① Захиргааны үйлчилгээг цахимжуулах

Захиргааны үйлчилгээг цахимжуулах дүн шинжилгээний хувьд үйлчилгээ үзүүлэгч талаас болон үйлчилгээ авагчийн талаас үнэлгээ хийнэ.

Үйлчилгээ үзүүлэгч талаас хийх дүн шинжилгээний хувьд Монголын засгийн газрын Алсын хараа 2050-д 2024 он хүртэлх хугацаанд захиргааны үйлчилгээний 90 %-ийг цахимжуулна(800-аас илүү үйлчилгээг цахимаар үзүүлэх боломжтой болгоно)гэж зорьсон байна. 2022 оны байдлаар 994 үйлчилгээг цахимаар үзүүлж байгаа бөгөөд тэгснээр засгийн газрын ашиглалтын зардал 30 сая USD(ойролцоогоор 4. 5тэрбум иен)хасагдаж, авилгал хахууль, авилгалтай холбоотой гомдлын тоо 30% буурсан байна. Мөн E-Mongolia нь хувийн хэвшлийн үйлчилгээнд ч холбогдсон байна. E-Mongolia-г ажиллуулдаг төрийн өмчийн компани E-Mongolia Academy нь 2024он 4-р сарын байдлаар e-Mongolia-д 1173 үйлчилгээ

үзүүлж байгаа бөгөөд түүнээс 60-70%-ийг засгийн газар, 30-40%-ийг хувийн хэвшлийн компани үзүүлж байна²⁸

Үйлчлүүлэгч талаас харсан дүн шинжилгээний хувьд e-Mongolia-д үйлчлүүлэгчээр бүртгүүлсэн хүмүүсийн ашиглалтын хувь нь ашиглалтад орсноос хойш 2 жилийн дотор хэдийнэ 1.7 сая хүнд(нийт хүн амных нь бараг 51%)хүрсэн байна. 3-р бүлгийн 3.(1)-д e-Mongolia-н ашиглалтын өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээг хийсэнчлэн үйлчлүүлэгчдийн насны бүтцийг авч үзэхээр 20-30-аад насныхан голлож байгаа бөгөөд 10-аад наснаас 50-аад насныхан хүртэл өргөн хүрээтэйгээр ашиглаж байна. Мөн, бүс нутаг бүрээр нь ашиглалтын хувийг харьцуулж үзвэл Улаанбаатар хотын үйлчлүүлэгч ба орон нутгийн үйлчлүүлэгч 50:50 хувийн харьцаатай байна. Ийм байдлаар захиргааны үйлчилгээний хүртээмж муутай орон нутагт ч гэсэн e-Mongolia нэвтэрсэн байна гэж хэлж болно. e-Mongolia ашиглагчын хувийг улам өсгөхөд цахим чадварын ялгаа(өндөр настан, малчид) гэх асуудал гарч ирж болзошгүй тул Монголын засгийн газар цахимаар захиргааны үйлчилгээг үзүүлэх болон ашиглалтыг нь нэмэгдүүлэх талын зорилтыг тодорхойлвол зохилтой.

e-Mongolia ашиглалтыг нэмэгдүүлэх нь цахим засаглал болон дотоодын МХХТ-ийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай хүчин зүйлийг харгалзан үзэж стратегийн чухал байдлыг "их" гэж үнэлж байна. Нөгөөтэйгүүр e-Mongolia-аар цахим засгийн газрын үзүүлэх үйлчилгээний хэмжээ (нийлүүлэлт) тодорхой хэмжээнд хүрсэн үр дүнтэй байгаа боловч, нөгөө талаар ашиглалтыг нэмэгдүүлэх(хэрэгцээ)тухайд үр дүнг нь улам сайжруулах хэрэгтэй гэж хэлж болох тул асуудлын ноцтой байдлын хувьд "дунд" гэж үзэж байна. Цахим засгийн газар байгуулах арга хэмжээний хувьд Монголын засгийн газар болон бусад хандивлагч орнуудын дэмжлэгийг авч идэвхтэй явагдаж байгаа ба ADB болон WB зэрэгт цахим засгийн газар, ухаалаг засгийн газрыг байгуулах төслийг хэрэгжүүлж байгаа зэргийг харгалзаж үзэж, ерөнхий асуудлын хэмээг "дунд" зэрэг байна гэж дүгнэж байна.

② Цахим засаглалын индекс

Цахим засаглалын индексийн талаар Монголын засгийн газрын тогтоосон тодорхой зорилт байхгүй. Монгол улс 193 гүшүүн орнуудын дотор 2018 он, 2020 онд дараалан 92-р байрыг эзлэж байсан ба e-Mongolia арга хэмжээг авнаас хойших 2022 онд 74 байр хүртэл байраа дээшлүүлсэн байна. Нөгөөтэйгүүр, яам, агентлаг бүртэй (ХХААХҮЯ, Эрүүл мэндийн яам, Зам тээврийн яам гэх мэт) хийсэн ярилцлагын үр дүнд яам, агентлаг бүр цахим засаглалыг бий болгох чиглэлээр ажиллаж байгаа боловч MDDIC-аас цахим засаглалын талаар дээрээс доош чиглэсэн тодорхой стратегийг танилцуулаагүй, яам, агентлаг хоорондын уялдаа холбоо дутмаг байгаа нь илт байна. Улмаар тус асуулгаар захиргааны ажилтнуудын (орон нутгийн захиргааны ажилтанг оролцуулан)цахим ур чадвар дутуу, яамуудын дотоодын цахим хүний нөөцийн(МХХТ-ийн мэргэжилтэн)тоо хангалттай биш гэх мэт асуудал байна. Энд яам газрууд хоорондын уялдаа холбооны дутагдалтай байдалд анхаарал хандуулж асуудлыг цэгцлэнэ. Монголын засгийн газар нь МХХТ-ийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг зорьж байгаа ба үйлдвэрлэлийг хөгжүүлэх эхний шатанд засгийн газрын захиалгаар хэрэгжих олон нийтийн чанартай төслийг нэмэгдүүлэх нь нэн чухал юм. Одоогоор засгийн газарт нэгдсэн чиглэл байхгүй, салбар тус бүр болон улсын хэмжээнд цахим засаглалын хурдыг нэмэгдүүлэх систем үүсгэх ажлын захиалга өгөгдөөгүй байна. Эдгээр байдлыг харгалзан цахим засаглалын индексийг сайжруулахын тулд зөвхөн MDDIC гэлтгүй Эрүүл мэндийн яам, Хөдөө аж ахуй яам, Үндэсний статистикийн газар, орон нутгийн засаг захиргаа зэрэг байгууллагууд хамтран ажиллаж цахим төрийн үйлчилгээг хамтран өргөжүүлэн хөгжүүлснээр дотоодын мэдээлэл технологийн салбарын аж ахуйн нэгжүүдэд үйлчилгээгээ хөгжүүлж өргөжүүлэх боломжыг олгох шаардлагатай байна.

Тиймээс, цахим засгийн газрын үйлчилгээг өргөжүүлэх нь дотоодын МХХТ-ийн ААН-г хөгжүүлэх урьдчилсан нөхцөл болох бөгөөд стратегийн хувьд чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн яамуудын хувьд захиргааны үйлчилгээний цахимжуулалт төдийлөн явагдаагүй, MDDIC болон бусад яамдын хоорондын хамтын ажиллагаа сул, яам болгон боловсон хүчний дутагдалтай зэрэг асуудлуудбайгаа тул асуудлын ноцтой байдлыг “өндөр” гэж үнэлж байна. Нөгөө талаар өдоо явуулж байгаа арга хэмжээний хувьд Эрүүл мэндийн яаманд ДЭМБ-ийн дэмжлэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд НҮБ-ын дэргэдэх ХХААБ-аас дэмжлэг үзүүлэх гэх мэтээр яам бүр тус тусдаа цахимжуулах арга хэмжээ хэрэгжүүлэх байна. Дээрхийг харгалзаж үзээд асуудлын хүнд байдлыг "дунд" орчим зэрэг гэж үнэлнэ.

²⁸ E-Mongolia Academy-иас авсан ярилцлага (2024 оны 4-р сарын 23-ны өдөр)

Хүснэгт 25 Алхам 1. Асуудлыг нарийвчлан тодорхойлох(Цахим засаглал)

Зүйл	Зорилт болон бодит байдлын зөрүү			Асуудал	Асуудлын үнэлгээ			Үнэлгээний үр дүн: Асуудлын хүрээ (том/дунд/жижиг)
	Зорилт	Өнөөгийн байдал	Нөөц		Стратегийн чухал байдал (том /дунд /жижиг)	Асуудлын хүндрэлтэй байдал (том /дунд /жижиг)	Одоо хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байгаа эсэх (Байна/байхгүй)	
Захиргааны үйлчилгээг цахимжуулсан	90% захиргааны үйлчилгээг цахимжуулсан	994 захиргааны үйлчилгээг цахимжуулсан (2022 он) - e-Mongolia хэрэглэгчийн бүртгэлийн тоо 1.7сая хүн	Зорилт: Алсын хараа 2050 Өнөөгийн нөхцөл байдал: e-Mongolia Academy	Захиргааны үйлчилгээг цахимжуулахад, зөвхөн засгийн газраас үйлчилгээ үзүүлэх биш, үйлчилгээний ашиглалтыг нэмэгдүүлэх талаас ч гэсэн зорилтыг тогтоох ёстой.	Их:e-Mongolia-гийн ашиглалтыг нэмэгдүүлэх нь цахим засгийн газрыг хөгжүүлэх болон дотоодын МХХТ-ын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай	Дунд : e-Mongolia-аар цахим засгийн газрын үйлчилгээг үзүүлэх(хангах)үр дүн нь тодорхой хэмжээгээр байна. Нөгөө талаар ашиглалтыг нэмэгдүүлэх(эрэлт хэрэгцээ) үр дүнгийн талаар сайжруулах шаардлага өндөр.	Байна: Азийн хөгжлийн банк болон Дэлхийн банк цахим засгийн газрыг байгуулах, ухаалаг засгийн газрыг байгуулах төслийг хэрэгжүүлж байна.	Дунд
Цахим засаглалын индекс	(тохиргоо байхгүй)	74 байр/193 орон	UN Department of Social and Economic Affairs	Засгийн газрын хэмжээнд цахим засгийн газрыг хөгжүүлэх, өргөжүүлэх, дотоодын МХХТ-ийн ААН-ийн үйлчилгээг оролцуулах боломжийг нэмэгдүүлэх нь чухал байна.	Их: Засгийн газрын цахим үйлчилгээг өргөжүүлэх нь дотоодын МХХТ-ийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх урьдчилсан хүчин зүйл байна.	Их: Яам бүрд захиргааны ажиллагааг цахимжуулах ажил төдийлөн ахицгүй, яам бүр MDDIC–д төвлөрсөн яам хоорондын хамтын ажиллагаа байхгүй, хүний нөөцийн хомсдол зэрэг асуудлуудтай тулгарч байна.	Байна: Эрүүл мэндийн яаманд Дэлхийн эрүүл мэндийн байгуулгын дэмжлэг, Хөдөө аж ахуйн яаманд Дэлхийн ХАА-н байгуулгын дэмжлэг зэрэг яам тус бүрийн түвшинд цахимжуулалтад чиглэсэн дэмжлэг үзүүлж байна.	Дунд

(б) Монгол улсын засгийн газар болон ЖАЙКА-гийн дэмжлэгийг тусгах судалгааны чухал салбарууд

① Захиргааны үйлчилгээг цахимжуулах

Хөгжлийн түншийн нэгэнд Эстони улсыг дурдаж болно. Эстонийн засгийн газар Монголын Эдийн засгийн форумд оролцож ирсэн бөгөөд Монголын засгийн газар e-Mongolia-г байгуулах үеэс e-Estonia-г загвар жишээ болгосон. Одоогоор Эстоний Цахим засаглалын академи MDDIC-тэй хамтран Монголын төрийн албан хаагчдын МХХТ-ийн чадавхийг хөгжүүлэх, мэргэжилтнүүдийг сургах, төрийн цахимжуулалтыг дэмжих стратеги боловсруулах, кибер аюулгүй байдлыг бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна.

Мөн Дэлхийн Банкны Ухаалаг төр- 2 төсөл(Хугацаа: 2023 он-2027 он/Дэмжлэгийн хэмжээ: Олон улсын хөгжлийн нийгэмлэгийн зээл 40.7 сая USD(ойролцоогоор 6.1 тэрбум иен))хэрэгжүүлж байгаа бөгөөд цахимжуулалтыг нэмэгдүүлэхтэй зэрэгцүүлж серверийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, кибер аюулгүй байдлыг бий болгохын төлөө Монгол дахь эрх зүйн орчинг бүрдүүлэх болон зохицуулалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлж байна ²⁹.

Нэмж дурдахад Азийн хөгжлийн банк нь цахим засаглал ба цахим өөрчлөлт төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд бусад хөгжлийн агентлагуудын адил MDDIC -тай түншлэн Цахим үндэстэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. (Төслийн нэр :Цахим засаглал болон Цахим өөрчлөлт(Техникийн туслалцаа)/Хугацаа: 2022 оны 12-р сар-2025 оны 12-р сар/Дэмжлэгийн хэмжээ: 1 сая USD(ойролцоогоор 0.149 тэрбум иен)Бодит агуулгын хувьд, (1)Захиргааны цахим үйлчилгээг ашиглах орчныг сайжруулах зорилгоор дахин зураг төсөл боловсруулах,(2)кибер аюулгүй байдлын ур чадварыг сайжруулах,(3)холбогдогч талуудын зүгээс цахимжуулалтад үзүүлэх дэмжлэг болгож техникийн хамтын ажиллагаа явуулна. Төслийн агуулгыг доор дурдав.

Цахим засаглалын санаачилсан Аюулгүй байдал, мэдээллийн технологийн чадавхийг сайжруулах, стратеги боловсруулах зэрэг ажлуудыг хөгжлийн агентлагууд дэмжиж байна. Нөгөө талаас, нүүдэлчид, ахмад настнуудад e-Mongolia -г ашиглахыг дэмжих талаар төрөөс тодорхой дэмжлэг үзүүлэхгүй байгаа нь асуудал гэж үзэж байна. Этгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд Японы засгийн газраас "Цахимжуулалтыг хэрэгжүүлснээр Орон нутагт тулгамдаж буй асуудлыг дижитал нэвтрүүлгээр шийдэж, хэнийг ч орхигдуулахгүй, хүн бүр цахимжилтын үр шимийг хүртэж сэтгэл ханамжтай амьдрах" -ыг зорилго болгож "Цахим цэцэрлэгт хот хэмээх төрийн үзэл баримтлал"-ын үндсэн дээр орон нутгийн засаг захиргаанд цахимжуулалтыг дэмжих мэргэжилтнүүдийг ажиллуулж, өндөр настан олонтой хөдөө орон нутагт цахимжуулалтыг дэмжих, орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж, орон даяар цахимжуулалтыг дэмжих менежерүүдийг ажиллуулж байна. Ийм байдлаар орон нутаг, хот суурин газрын цахим чадварын ялгааг арилгах Японы туршлага нь малчид болон өндөр настануудын цахим чадварын ялгааг арилгахад орон нутгийн захиргааны байгууллага нь голлон төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулж ажилладагын жишээ болно.

② Цахим засаглалын индекс

Хөгжлийн түншийн хувьд яам, агентлаг бүр цахим засгийн газрын хүчин чармайлтад дэмжлэг үзүүлж байна. Эрүүл мэндийн яамнаас асуухад ДЭМБ-тай хамтран эрүүл мэндийн салбарын цахимжуулалтын төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлж байгаа нь тодорхой болсон. ДЭМБ-ын дэмжлэгээр Алсын хараа 2050-д эрүүл мэндийн салбарын МХХТ-жуулалтийн чиглэлийг зааж, тэрхүү чиглэлийн дагуу Эрүүл мэндийн яамны МХХТ-жүүлэх стратегийг 2050 он хүртэлх богино хугацааны бодлогыг боловсруулж байна. Мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас асууж хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар дахь мэдээлэл технологийн системийн үнэлгээний судалгааг НҮБ-ын Хүнс, ХАА-н байгуулгын дэмжлэгээр гүйцэтгэж байгааг мэдэв. Түүнчлэн нүүдэлчдийн хувьд тэгш өндөрлөг газрын байгалийн нөхцөл байдлыг хянах системийг агуулсан програм боловсруулж, өндөрлөг газрын байгалийн нөхцөл байдлыг ажиглах хиймэл дагуулын мэдээлэл боловсруулах "Тогтвортой тэжээлийн менежментийн систем"-ийг Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр боловсруулж байна.

Японы хөгжлийн эх үүсвэрт Цахим агентлагаас зарласан "Цахим нийгмийг хэрэгжүүлэхэд чиглэсэн тэргүүлэх төлөвлөгөө" болон, Цахим агентлагын хууль тогтоомжийг нээлттэй өгөгдөл болгох, Хувийн аж ахуйн нэгжүүд "e-Gov портал" -аар төрийн байгуулгад хандаж өргөдөл гаргах боломжтой болсон гэх мэт арга хэмжээнүүдийг нэрлэж болно. Цахимжуулахад чиглэсэн үндэсний стратеги нь Монгол дахь ирээдүйн цахим захиргааны үйлчилгээг хөгжүүлэх, өргөжүүлэх болон дотоодын МХХТ-н

²⁹ Ухаалаг төр- 2 төсөл II веб хуудас (2024 оны 8-р сард хандалт хийсэн)

үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлийг судлахад хэрэг болохын зэрэгцээ, e-Mongolia-г хөгжүүлэхэд e-Gov порталаас санаа авч болох юм.

Хүснэгт 26 Алхам 2. Монголын засгийн газар болон ЖАЙКА-гийн дэмжлэгийг тусгах судалгааны чухал салбарыг нарийвчлан тодорхойлох (e-Government)

Зүйл	Асуудал	Асуудлыг шийдвэрлэхэд ЖАЙКА-ийн тусламж шаардлагатай эсэх/боломжтой эсэхийг судлах		Үнэлгээний үр дүн: Судалгааны чухал салбар
		Хөгжлийн түнш байгаа эсэх	Японы дэмжлэгийн эх үүсвэртэй эсэх	
Захиргааны үйлчилгээг цахимжуулсан	Захиргааны үйлчилгээг цахимжуулахад, засгийн газраас үйлчилгээ үзүүлэх зорилтоос гадна, үйлчилгээний ашиглалтыг идэвхжүүлэх талаарх зорилтыг тодорхой болгох хэрэгтэй	Байна(Дэлхийн банк, Эстони, ADB, APCICT)	Байна: Японы Засгийн газрын хэрэг эрхлэх газрын "Цахим цэцэрлэгт хот Үндэсний үзэл баримтлал	-
e-Government index	Нийт засгийн газрын хэмжээнд цахим засгийн газрын үйлчилгээг хөгжүүлж, өргөжүүлснээр дотоодын МХХТ-ийн АНН- үүдийн үйлчилгээг хөгжүүлэлтэнд нь оролцох боломжийг нэмэгдүүлэх нь чухал асуудал	Байна(WHO, FAO, ADB)	Байна • Цахимжилтын ерөнхий газар "e-Gov портал"(цахим үйлчилгээнд бүртгүүлэх, хууль тогтоомжийн хайлт хийх зэрэг) • Цахимжилтын ерөнхий газар "цахим нийгэм бий болгоход чиглэсэн чухал төлөвлөгөө"	-

(4) МХХТ ба Цахим хүний нөөц

(a) Асуудал

МХХТ болон цахим хүний нөөцийн хөгжилд холбоотой асуудлууд нь эрэлт хэрэгцээ талаас нь авч үзвэл(1)үндэсний цахим ур чадвар, нийлүүлэлтийн талаас нь авч үзвэл (2)МХХТ ийн хүний нөөцийн хэмжээ (3)МХХТ-ийн хүний нөөцийн чанар гэсэн 3 талаас талаас нь авч үзэж дүн шинжилгээ хийнэ.

① Иргэдийн цахим ур чадвар

Цахим банк болон цахим худалдаа ашиглаж чаддаг хүний тоо нь нийт хүм амын 27%³⁰байгаа нь цахим ур чадварын талаар хараахан асуудал байгааг харуулж байна. Харин, интернет ашиглаж мэдээлэл цуглуулах болон өгөгдлийг хадгалах зэрэг үйлдлийг хийж чаддаг хүн амын хувьд, Цахим үндэстэнд заасан зорилтыг (2027 онд 50% -г давна) 2021 оны байдлаар 43.8% -д хүрч зорилтын биелэлтийн хувь 80%-аас давсан бөгөөд³¹, тус асуудлын ноцтой байдал нь "бага" гэж үнэлнэ.

МХХТ-ийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхдээ юун түрүүнд нийлүүлэгч талын тоо, чанарыг сайжруулах нь илүү чухал байгаа тул хэрэглэгч талын асуудал болох цахим ур чадварын стратегийн чухал байдлыг "дунд" гэж үнэлнэ. Мөн, 2005 оноос эхэлсэн e-Mongolia үндэсний хөтөлбөрт цахим ур чадварыг

³⁰ MDDIC (2022)"“Digital Nation”approval guidelines"


³¹ дээрхтэй ижил

дээшлүүлэхийг зорьж сургуулиудад интернетийн орчин бүрдүүлсэн бөгөөд 2006 онд гаргасан 2006-2015 оны боловсролын хөгжлийн мастер төлөвлөгөөний дагуу сургуулиудад МХХТ-ийн төхөөрөмжийг суурилуулах болон багш нарт МХХТ-ийн сургалтыг явуулах зэрэг цахим ур чадварыг сайжруулах арга хэмжээг урьд өмнөхөөс илүү хэрэгжүүлж байна. Дээрх үр дүнг үндэслээд асуудлын хүрээг "бага" гэж үнэлнэ.

② МХХТ-ийн хүний нөөцийн хэмжээ

3-р бүлгийн 3.(1)-ийн (Д)-д тайлбарсанчлан 2020 оны МХХТ-ийн үйлдвэрлэлийн чиглэлээр ажиллаж байгаа хүний тоо нь 13,900 хүн байсан бол 1600 хүний нээлтэй ажлын байр байсан³²³³. Нөгөө талаар.) Боловсрол яамны мэдээллээр 2019-2020 оны хичээлийн жилд МХХТ-ийн мэргэжлээр төгссөн төгсөгчид 591 хүн байгаа бөгөөд энэ нь 2020 оны нээлттэй ажлын байрны 37%-г эзлэх боловуу гэж таамаглаж байна. Цаашид хүний нөөцийн хэрэгцээ нэмэгдэх магадлалтай ба эрэлт, нийлүүлэлтийн зөрүү нь улам ихсэх таамаглал байгаа тул асуудлын хүнд байдлыг "их" гэж үнэлнэ. Мөн хүний нөөц нь үйлдвэрлэлийг хөгжүүлэх суурь үндэс болон чухал асуудал бөгөөд стратегийн чухал байдлын хувьд ч "их" гэж үнэлнэ.

Одоогийн авч байгаа арга хэмжээ байгаа эсэхийг дүн шинжилгээ хийхийн тулд, МХХТ-ийн боловсон хүчний тоо, чанарыг сайжруулахаас гадна сургалтын үе шат бүрт ямар бэрхшээл тулгардаг болохыг дараах хүснэгтийн дагуу цэгцэлнэ.



Зураг 30 МХХТ-ийн хүний нөөцийг бэлтгэх үе шат бүрд гардаг асуудлууд

Хүний нөөцийн хэмжээг нэмэгдүүлэхийн тулд, эхлээд МХХТ-ийн салбарт дэвшин суралцах оюутны тоог нэмэгдүүлэх ёстой. Дээд боловсрол эзэмшсэн оюутнуудын хувьд аж ахуйн нэгжүүдтэй танилцах боломж хязгаарлагдмал байдаг нь ажлын байртай болоход саад болдог ч МХХТ-ийн зах зээл нь эрэлт хэрэгцээ сайтай тул одоогоор оюутнууд үүнийг асуудал гэж харахгүй байна. Харин АНН-үүдийн тал нь аль болох шилдэг сайн оюутнуудыг олж авах арга зам, боломжийг хайж байна. Оюутнуудын сонирхлыг татах цаашдын арга хэмжээ болгож Экспортын стратегийн 2.1.3.-т "Conduct school awareness programmes to expand interest in IT jobs" -г дурдагдаж байна. Хэдийгээр энэ асуудлыг хариуцах агентлаг тодорхойгүй байгаа ч БШУЯ хамтран ажиллах ба гол төлөв 15-18 насны сурагчдад таниулах сургалт явуулахаар төлөвлөж байна.

Мөн, хүний нөөцийг нэмэгдүүлэхийн тулд зөвхөн оюутан гэлтгүй бусад салбарт ажилладаг насанд хүрэгчдийг ч татан оролцуулах нь ашигтай. Гэвч одоогийн байдлаар ажиллаж буй насанд хүрэгчдэд зориулсан мэргэжил дээшлүүлэх хөтөлбөргүй байгаа бөгөөд МХХТ-ийн салбар руу шилжихэд тулгарч буй бэрхшээл өндөр хэвээр байна. Дээрх байдлыг харгалзаж үзээд асуудлын цар хүрээг "өргөн" гэж

³² [BAROMETER SURVEY ON LABOR MARKET DEMAND \(2019\)](#)

³³ [Brief Presentation on ICT Statistics Experiences of Mongolia\(2019\)](#)

үнэлнэ.

③ МХХТ-ийн хүний нөөцийн чанар

3-р бүлгийн 3-р хэсгийн (1) (Д)-д дурдсанчлан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хийсэн “Монгол Улсын ур чадварын эрэлтийн судалгаа” (2022)³⁴-д МХХТ-ийн ур чадвар нь зөвхөн МХХТ-ийн компаниудад төдийгүй олон нийтийн дунд хомс байгаа болон МХХТ-ийн компаниудад ч боловсон хүчний техникийн ур чадвар стандартын хэмжээнд хүрэхгүй байна гэсэн 2 зүйлийг онцлон тэмдэглэж байна. Мөн энэхүү судалгааны РР(2)анх удаагийн МХХТ/Цахим хүний нөөцийн ажлын семинарын үеэр компаниудын дунд явуулсан судалгаанд, компаниудын 80% -иас илүү нь ажилд авсан оюутнууд өөрсдийнх хайж буй техникийн ур чадварт нийцдэг гэж хариулжээ. Хүний нөөцийн хомсдолоос шалтгаалж тодорхой хэмжээний техникийн чадвартай оюутнуудыг ажилд авдаг ба бодит байдал дээр тэднийг ажилд авсны дараа сургахад хэдэн жил шаардагддаг. Дэлгэрэнгүйг 7-р бүлгийн 2-р хэсгээс үзнэ үү. (3) МХХТ/Цахим хүний нөөцийн ажлын анхдугаар семинарын судалгааны дүн шинжилгээ).

Мөн, тус судалгаагаар, оюутнуудын зөөлөн ур чадварт сэтгэл ханамжтай компани нь 60% -иас дээш байгаа нь техникийн ур чадварынхаас доор байгааг харуулж байна. Бас, тус тайланд дурдаж байгаа зөөлөн ур чадвар гэдэг нь ажил гүйцэтгэх үндсэн суурь болох ур чадвар болон онцлог шинж гэж тодорхойлно.

Оюутнуудын практик ур чадварын дутагдал (техник/зөөлөн аль аль нь)нь дээрх зурган дээр заасанчлан сургуулийн боловсролоор практик ур чадварыг эзэмших боломж хязгаарлагдмал байгаа, төгсөлтийн судалгааны ажлыг зөв удирдах чанартай багш нар цөөхөн байдаг гэсэн 2 асуудалд хувааж бодож болно. Ажил эрхэлж байгаа хүмүүсийн хувьд компанид ажиллангаа ур чадвараа дээшлүүлэх сургалт хязгаарлагдмал байгаа нь асуудал болов уу гэж төсөөлөгдөж байна.

МХХТ хүний нөөцийн чанар нь "(2)МХХТ хүний нөөцийн хэмжээ"-тэй адил, үйлдвэрлэлээ хөгжүүлэх үндсэн суурь болох чухал асуудал бөгөөд стратегийн чухал байдлаар "их" гэж үнэлнэ. Асуудлын хүнд байдлыг тоон үзүүлэлтээр хэмжих боломжгүй ч ур чадвар хангалтгүйг байгаа өнөөдрийн байдлыг үндэслээд "дунд" гэж үнэлнэ.

Одоогоор авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байгаа эсэх талаар, оюутнуудад практик ур чадвар эзэмших боломжийг гол төлөв боловсролын байгууллагууд бие даан олгодог ч засгийн газрын хойшдын арга хэмжээ 2.1.5. -д "Establish a Public-Private IT Skill Development Council and conduct periodic meetings" төлөвлөгдөж байна. (Боловсролын яам-ны удирдлага дор). Харин зөвлөлгөө өгөх зорилго болон зөвлөгөөг хэрхэн явуулах нь шийдэгдээгүй байна. Мөн, MDDIC 2022 оны 12-р сараас Жайкагийн техникийн хамтын ажиллагааны төслөөр кибер аюулгүй байдлын хүний нөөцийг хөгжүүлэх төслийг хэрэгжүүлж байна (2026 оны 11-р сар хүртэл хэрэгжихээр төлөвлөсөн). Энэхүү санаачилга нь кибер аюулгүй байдлын хүний нөөцийг хөгжүүлэхийн тулд аж үйлдвэр, эрдэм шинжилгээний байгууллага, засгийн газрын хамтын ажиллагааны сүлжээг бий болгох зорилготой ба багш, төрийн албан хаагчдад зориулсан кибер аюулгүй байдлын боловсролын хөтөлбөрүүдийг боловсруулж Монгол Улсад кибер аюулгүй байдлын боловсролыг дээшлүүлэх зорилготой юм.

Түүнчлэн, өндөр чанартай багш бэлтгэх томоохон арга хэмжээ одоогоор алга байна. Байгуулла дотор ур чадвар дээшлүүлэх сургалтын талаар Экспортын стратегийн 2.1.6-д "Support on-the-job training and apprenticeship schemes" заасны дагуу ур чадвар дутуу ажилчдын өнөөгийн байдлыг судалсны үндсэн дээр аж ахуйн нэгжүүдэд ургалтын төлбөр олгох зэрэг санхүүгийн дэмжлэг үзүүлэх тогтолцоог авч үзэхээр төлөвлөж байна (MDDIC-ын удирдлага дор). Ийм байдлаар төрөөс хэд хэдэн санаачилга гаргахаар төлөвлөж байгаа ба доогоор тийм ч олон санаачилга гараагүй ба үнэлгээний бусад үр дүнг харгалзан асуудлын цар хүрээг "том" гэж үнэлдэг.

³⁴ [Skills Demand in Mongolia \(2022\)](#)

Хүснэгт 27 Алхам 1. Асуудлыг нарийвчлан тодорхойлох (МХХТ, цахим хүний нөөцийг бэлтгэх)

Зүйл	Зорилт болон өнөөгийн байдлын зөрүү			Асуудал	Асуудлын үнэлгээ			Үнэлгээн ий үр дүн: Асуудлын хүрээ (том/дунд /жижиг)
	Зорилт	Өнөөгийн байдал	Нөөц		Стратегийн чухал байдал (том /дунд /жижиг)	Асуудлын хүндрэлтэй байдал (том /дунд /жижиг)	Одоо хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байгаа эсэх (Байна/байхгүй)	
Иргэдийн цахим ур чадвар	50%(2027 он)	43.8%(2021 он) Цахим банк болон цахим худалдаа хийж чаддаг хүн ам 27%	Зорилт/Одоогийн нөхцөл байдал : Цахим үндэстэн(Өрхийн судалгаа)	Иргэдийн цахим ур чадвар өндөр биш	Дунд: Хэрэглэгчийн цахим ур чадварыг дээшлүүлэхээс илүү нийлүүлэгч талыг хөгжүүлэх нь чухал байна	Бага: Зорилтот үзүүлэлтийн 80% гаруй хүртэл биэлнэ	Байна: 2005 оны e-Mongolia үндэсний хөтөлбөр, 2006 оны Боловсролыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө 2006-2015 г.м.	Бага:
МХХТ-ийн хүний нөөцийн хэмжээ	- (Экспортын стратегийн 2.1 Increase the talent pool-тай нийцнэ. Тодорхой зорилтот тоон үзүүлэлт байхгүй	2020 оны нээлттэй ажлын байранд ажилд авсан хувь нь ойролцоогоор 37%(2020 оны МХХТ-ийн бизнесийн салбрын нээлттэй ажлын байрны тоо 1600 хүн, 2019-20 хичээлийн жилийн МХХТ-ийн төгсөгчдийн тоо нь 591 хүн)	Одоогийн байдал: Нээлттэй ажлын байрны тоог нээлттэй тайлангаас авч, МХХТ-ийн мэргэжлээр төгссөн оюутнуудыг тоог Боловсролын яамнаас асуув.	МХХТ-ийн хүний нөөцийн дутагдал. Шалтгаануудыг доор дурдав. • Оюутнууд: МХХТ-ийн салбарт дэвшин суралцах боломж хазгаарлагдмал • Компаниуд: Компаниуд нь ур чадвартай оюутнуудыг ажилд авч чадахгүй • Ажил эрхлэгчид: Ажил эрхлэж байгаа хүмүүст зориулсан дахин чадваржуулах хөтөлбөр байхгүй.	Их: Хүний нөөц нь үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд суурь үндэс болдогоороо чухал асуудал мөн.	Их: 2020 оны нээлттэй ажлын байранд ажилд авсан хувь нь тооцооллоор 70%. Харин МХХТ-ийн мэргэжлээр төгсөгчид нь 591 хүн гэдэг нь хэт бага байна. Цаашид хүний нөөцийн хэрэгцээ өсөхийг бодвол хэрэгцээ болон нийлүүлэлтийн зөрөө улам ноцтой болж байна.	• Оюутнуудад зориулсан: Байхгүй(цаашдын төлөвлөгөө: Экспортын стратеги 2.1.3. Conduct school awareness programmes to expand interest in IT jobs) • Ажил эрхлэгчдэд: Байхгүй	Их

МХХТ-ийн хүний нөөцийн чанар	- (Экспортын стратегийн 2.1 Increase the talent pool-тай нийцнэ. Харин тодорхой зорилтот тоон үзүүлэлт байхгүй	Ажилтнуудын хаа техник / зөөлний ур чадварын аль алиныг хангалттай биш гэж үзэж байгаа компаниуд олон	Одоогийн байдал: • Техникийн ур чадвар: Монгол дахь ур чадварын хэрэгцээний тухай судалгаа"(2022) • Зөөлөн ур чадвар Тус судалгааны хүрээнд хийсэн анкет судалгаа	МХХТ-ийн хүний нөөцийн чанар доогуур Шалтгаануудыг доор дурдав. • Оюутнууд: Практик ур чадварыг эзэмших боломж муутай • Багш нар: Чанартай багш нар цөөн • Ажил эрхлэгчид: Компаний дотоодын дахин чадваржуулах хөтөлбөр байхгүй	Их: Хүний нөөц нь үйлдвэрлэлийг хөгжүүлэх суурь үндэс болно. Мөн хүний нөөцийн ур чадварыг дээшлүүлснээр МХХТ-ийн үйлдвэрлэлийн хөгжлийг хурдасгах боломжтой болно.	Дунд: Тоон үзүүлэлтээр үнэлэх боломжгүй боловч ур чадвар дутмаг өнөөгийн байдлыг үндэслэн "дунд" гэж үнэлнэ.	- Оюутнууд, багш нар, ажил эрхлэгчдэд зориулсан нийтлэг шинж: Байна ЖАЙКА-ийн техникийн хамтын ажиллагааны хүрээнд кибер аюулгүй байдлын хүний нөөцийг хөгжүүлэх - Оюутнуудад зориулсан: Байхгүй(цаашд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө: Экспортын стратеги 2.1.5. Establish a Public-Private IT Skill Development Council and conduct periodic meetings) - Багш нарт зориулсан: Байхгүй - Ажил эрхлэгчдэд: Байхгүй(цаашд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө: Экспортын стратеги 2.1.6. Support on-the-job training and apprenticeship schemes)	Их
------------------------------	--	---	---	---	---	--	--	----

(б) Монголын Засгийн газар болон Жайка-гийн тусламжийг чиглүүлэх судалгааны чухал чиглэлүүд

① МХХТ-ийн хүний нөөцийн хэмжээ

Хүний нөөцийн тоо хэмжээ, чанарын аль алиныг нь дэмжиж Азийн хөгжлийн банк Боловсролын яамнд харьяалагдах боловсролын салбарыг 2021-2030 он хүртэл хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөний (Education Sector Mid-Term Development Plan 2021-2030) боловсруулалт, хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлж байна. Төслийн ерөнхий тоймыг 5-р бүлгийн 1.(б) бүлгээс үзнэ үү. Боловсролын салбарт төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэхээс гадна МХХТ-ийн ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд 2024 оны 5 сард Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монгол дахь ИОМ (НҮБ-ын Олон улсын цагаачлалын байгууллага) хамтран Улаанбаатарт зохиогдсон Мишээл экспо бизнесийн үзэсгэлэн худалдаан дээр "Хөдөлмөр эрхлэлтийн яармаг-2024"³⁵-ийг хамтран зохион байгуулсан түүхтэй. Харин цаашид үргэлжлэх үгүй нь тодорхойгүй байна. Нарийвчилсэн мэдээллийг 5-р бүлгийн 2.(4)-аас үзнэ үү. Үүнээс гадна, дээр дурдсанчлан Google MDDIC-тэй хамтран МХХТ-ийн 1000 авьяастныг хөгжүүлэх зорилготой "Google-тэй хамт өсөх Монгол" төслийг сурталчилж байна.

Монголын санаа санаачлаганд ашиглаж болох Японы дэмжлэгийн эх үүсвэрийн тухайд МХХТ-ийн салбарт ажилд орох оюутнуудыг тоог нэмэгдүүлэх арга хэмжээ нь Япон маягийн хамтарсан хөдөлмөрийн яармаг байж болно. Харин МХХТ-ийн хүний нөөц нь эрэлт ихтэй байгаа тул оюутнуудад зөвхөн ажилд орох боломж олгох нь хангалттай бус юм. Оюутнуудын хувьд компаниудыг гүнзгий мэдэж, ажил хайх явцад үр дүнгүй ярилцлагын тоог багасгах нь чухал бол, компаниудын хувьд маш сайн оюутнуудыг ажилд авч чадах нь тэдний гол үнэ цэнэ юм.

Ажил эрхэлж буй насанд хүрэгчдийн дунд мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрүүд гэвэл Токио хотын захиргаанаас зохион байгуулдаг "DigiColle Tokyo" болон Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яамны "Дахин ур чадварын курс" зэрэг багтана. Харин эдгээр хөтөлбөрийн тухай дэлгэрэнгүйгээр 5-р бүлгийн 2.(5) "МХХТ, цахим хүний нөөцийг хөгжүүлэх Японы дэмжлэг эх үүсвэрүүд" -т тайлбарлана.

② МХХТ-ийн хүний нөөцийн чанар

МХХТ-ийн хүний нөөцийн чанарыг сайжруулахад чиглэсэн хөгжлийн түншүүдийн зүгээс томоохон санаачилга харагдсангүй. Нөгөөтэйгүүр, оюутнуудад практик ур чадвар эзэмших боломжийг олгох үүднээс ашиглаж болох хэд хэдэн Японы дэмжлэгийн эх үүсвэрүүд байдаг. Жишээлбэл: ЖАЙКА нь тус судалгааны туршилтын төслөөр Монголын оюутнуудад зориулсан биенес уралдаан болох DX CUP-г зохион байгуулж үзсэн. Мөн, техникийн хамтын ажиллагааны хүрээнд орон нутгийн сургалтын хөтөлбөр боловсруулах, Өвсний үндэс, техникийн хамтын ажиллагааны төслүүдээр дамжуулж МХХТ-ийн хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрүүд янз бүрийн улс оронд хэрэгжиж байна. Одоогоор ЖАЙКА нь Монгол улсад, дээр дурдсан техникийн хамтын ажиллагааны төсөл "Кибер аюулгүй байдлын хүний нөөцийг хөгжүүлэх төсөл" дээр нэмээд Өвсний үндэс техникийн хамтын ажиллагаа "Монгол улс, Нийгата, Монголын аж үйлдвэрийн шинэчлэлийг хэрэгжүүлэх зорилготой аж үйлдвэрийн цахимжуулалтын (DX-Digital Transformation) хүний нөөцийг хөгжүүлэх платформыг бий болгох төсөл"-ийг хэрэгжүүлж байна. Харин, Японд суралцах хөтөлбөр нь Монгол дахь багш нарын дутмаг байдлыг шийдвэрлэх шийдлийн нэг байж болно.

³⁵ ИОМ [Хэвлэлийн мэдээ](#) (2024 оны 7-р сарын 4-ний өдрийнхийг үзнэ үү)

Хүснэгт 28 Алхам 2. Монголын Засгийн газар болон Жайка-гийн тусламжийг тусгах судалгааны чухал салбарыг нарийвчлан тодорхойлох (МХХТ, цахим хүний нөөцийг хөгжүүлэх)

Зүйл	Асуудал	Асуудлыг шийдвэрлэхэд ЖАЙКА-гийн тусламж шаардлагатай эсэх/боломжтой эсэхийг судлах		Үнэлгээний үр дүн: Судалгааны чухал салбар
		Хөгжлийн түнш байгаа эсэх	Японы дэмжлэгийн эх үүсвэртэй эсэх	
МХХТ-ийн хүний нөөцийн хэмжээ	МХХТ-ийн хүний нөөцийн дутагдал. Шалтгаануудыг доор дурдав. • Оюутнууд: МХХТ-ийн салбарт дэвшин суралцах сонирхолыг бий болгох боломж хязгаарлагдмал • Ажил эрхлэгчид: Ажил эрхлэгчидийг дахин чадваржуулах хөтөлбөр байхгүй	Байна • ИОМ(2024 оны 5-р сард НҮБ-н Олон улсын цагаачлалын байгуулга)Монголтой ажлын байрны яармаг зохион байгуулсан) • Google(Growth with Google Mongolia Projects) • (Хэмжээ, чанарт нийтлэг)ADB- Азийн хөгжлийн банк(Боловсролын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө 2021-2030-г боловсруулах, хэрэгжүүлэх)	Оюутнуудад зориулсан: Байна • Япон маягийн хамтарсан нээлттэй ажлын байрны яармаг(Жоб семинар)	Судалгааны чухал салбар
			Ажил эрхлэгчдэд: Байна • Токио хотын "Дежи Колле TOKYO"(35 наснаас доош ажил эрхлэгч нарт өөр ажил хайхад зориулж үнэ төлбөргүй МХХТ-ийн хөтөлбөрт хамруулж, ажилд ороход нь дэмжлэг үзүүлэх) • Эдийн засгийн яамны "мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрүүд"(Мэргэжлийн, практикаар мэргэжлийн боловсрол олгох сургалтыг Эдийн засаг аж үйлдвэрийн сайд баталгаажуулах тогтолцоо)	
МХХТ-ийн хүний нөөцийн чанар	МХХТ-ийн хүний нөөцийн чанар доогуур байна. Шалтгаануудыг доор дурдав. • Оюутнууд: Практик ур чадварыг эзэмших боломж муутай • Багш нар: Чанартай багш нар цөөн • Ажил эрхлэгчид: Компаниудад дахин чадваржуулах хөтөлбөр байхгүй	Байна • (Хэмжээ, чанарт нийтлэг)ADB- Азийн хөгжлийн банк(2021-2030 оны Боловсролын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх)	Оюутнуудад зориулсан: Байна • DX CUP г.м.-ийн оюутнуудад зориулсан бизнес уралдаан • МХХТ-ийн салбар дахь хувийн хэвшил болон их сургууль түншлэлийн үйл явц • Техникийн хамтын ажиллагааны төслөөр хөтөлбөрийг хөгжүүлэх(Одоо Монголд кибер аюулгүй байдлын хүний нөөцийг хөгжүүлэх техникийн хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна)	Судалгааны чухал салбар
			Багш нарт зориулсан: Байна • Өвсний үндэс болон техникийн хамтын ажиллагаагаар ЖАЙКА-гийн МХХТ-ийн хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр(Японд суралцах хөтөлбөр)	
			Ажил эрхлэгчид: Байхгүй	

(в) Монголын засгийн газар болон ЖАЙКА-гийн дэмжлэгийн чиглэл

Алхам 2 хүртэлх агуулгыг цэгцлэж МХХТ-ийн хүний нөөцийн хэмжээ болон чанарыг дээшлүүлэх асуудалд ЖАЙКА-гийн дэмжлэгийн чиглүүлж дараах хүснэгтэд үзүүлсэн үйл ажиллагаануудыг үр ашигтай гэж үзэж байна.

Хүснэгт 29 Алхам 3. Монголын засгийн газар болон ЖАЙКА-гийн дэмжлэгийн чиглэл(МХХТ, цахим хүний нөөцийг хөгжүүлэх)


Зүйл	Үнэлгээний үр дүн		ЖАЙКА-ийн дэмжлэгийн чиглэл			
	Асуудлын цар хүрээ	Судалгааны чухал чиглэлүүд	Дэмжлэгийн цэс	Гол үйл ажиллагаа	Таамагла сан схем	Түнш
МХХТ-ийн хүний нөөцийн хэмжээ	Их	Чухал салбар	МХХТ-ийн салбарт дэвшин суралцахыг сурталчлах	Их сургууль эсвэл Коосэнд дэвшин суралцах гэж буй оюутнуудад зориулж МХХТ-ийн салбарт дэвшин суралцахыг дэмжих контент хөгжүүлэх болон бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх ※ Экспортын стратеги 2.1.3. Conduct school awareness programmes to expand interest in IT jobs-тай хамтрах	-	Боловсролын яам
			Оюутнуудад ажилд орох боломж олгох / ААН-д хүний нөөц олж авах боломж олгох	Ажлын семинар(тус судалгааны РР(2))дээр энэ тухай үзнэ	- (Монголын байгууллагад шилжүүлэх)	Нарны наадам(Япон фестивалын зохион байгуулах алба)
			Ажил эрхлэгчдэд зориулсан дахин чадваржуулах хөтөлбөрийг хөгжүүлэх	- засгийн газраас ажил эрхлэгчдэд зориулсан МХХТ-ийн дахин чадваржуулах хөтөлбөр болон түүнийг зохион байгуулах тогтолцоог бий болгоход нь дэмжлэг үзүүлэх - Дахин чадваржуулах хөтөлбөрийг зохион байгуулах боломжтой байгууллагад засгийн газрын дэмжлэгийг бий болгоход нь дэмжлэг үзүүлэх	Техникийн хамтын ажиллагааны төсөл / хувийн хэвшлийн түншлэлийн үйл ажиллагаа	Боловсролын яам
МХХТ-ийн хүний	Их	Чухал салбар	хувийн хэвшил, төр, их сургуулийн консорциум болон практик сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх	1-р алхам Хувийн хэвшил, төр, их сургуулийн консорциумыг байгуулж удирдлагын тогтвортой тогтолцоог бий болгоно ※ Экспортын стратеги 2.1.5. Establish a Public-Private IT Skill Development Council and conduct periodic meetings-тай хамтран ажиллах	Техникийн хамтын ажиллагааны төсөл	MDDIC/Эдийн засаг хөгжлийн яам/ Засгийн газрын хэрэг эрхлэх газар/Боловсролын

				2-р үе шат • Хувийн хэвшлийн талын саналыг оролцуулсан хөтөлбөрийг хөгжүүлэх тогтолцоог бий болгох Хувийн хэвшил, их сургуулийн хамтарсан төслийг хэрэгжүүлэхийг дэмжих		яам Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
		Оюутнуудад зориулсан тэмцээн зохион байгуулах		DX CUP(Тус судалгааны РР(4))-ийн үргэлжлэл	- (Монголын байгууллагад шилжүүлэх)	DX Mongolia
		(Багш нар хомсдолтой байгаад авах арга хэмжээ)Японд суралцах/интерншипын хөтөлбөрийг бий болгох		Японд суралцах/интерншипын хөтөлбөрийг бий болгох(Багш нар хомсдолтой байгаад авах арга хэмжээ)	Урт хугацааны сургалт	Боловсролын яам
		(Багш нар хомсдолтой байгаад авах арга хэмжээ)Японоос онлайнаар хичээлийг заах тогтолцоог бий болгоход нь дэмжлэг үзүүлэх		Японы их сургуультай хамтран ажиллах, Монголын дотоодын их сургуулиас онлайнаар хичээл заах тогтолцоог бий болгоход нь дэмжлэг үзүүлэх	Техникийн хамтын ажиллаганы төсөл	Боловсролын яам

2. Гарааны бизнесийн экосистемийг үүсгэн байгуулах

Гарааны бизнесийн экосистемийг бий болгоход тулгарч буй сорилтуудыг (1)хүн, (2)эд зүйлс, (3)мөнгө, (4)бодлого, хууль тогтоомж, (5)сүлжээ гэсэн 5 ангилж шинжилжүзсэн.

Overview of SU Ecosystem and Key Research Areas



Source: DTVS based on the Ministry of Economy, Trade and Industry data

※ 1. TAM: Total Addressable Market

Зураг 31 Гарааны бизнесийн экосистемийн ерөнхий байдал

(1) Хүний нөөц

Хүний нөөц нь 1 "хүний нөөцийг бүрдүүлэх" болон 2 "хүний нөөц оруулж ирэх" гэж 2 талаас авч үзнэ.

(а) Асуудал

1 "Хүний нөөцийг бий болгох"-од 1-1 "МХХТ-ийн хүний нөөцийн боловсрол", 1-2 "Бизнес эрхлэх хүний нөөцийн боловсрол" гэсэн талуудаас дүн шинжилгээ хийсэн. 2 "МХХТ-ийн хүний нөөцийг боловсрол"-ын хувьд 4-р бүлэг 1.(4)МХХТ, цахим хүний нөөц хэсэгт бичигдсэн.

1-2 "Бизнес эрхлэх хүний нөөцийн боловсрол"-ыг стратегийн чухал байдлыг "их", асуудлын хүнд байдлыг "их", асуудлын хүрээг "их" гэж үнэлсэн. Монгол улсын их сургууль болон Шинжлэх ухаан технологийн их сургууль зэрэг зарим дээд боловсролын сургуульд бизнес эрхлэгчийг бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа боловч их суруулиас гаралтай гарааны бизнесийн хэдхэн компани байгаа бөгөөд агуулгын хувьд хангалттай гэж хэлж чадахгүй. Бизнес эрхлэгчийг төрүүлэх нь Юникорн гарааны бизнесийг төрүүлэхэд зайлшгүй шаардлагатай хүчин зүйл бөгөөд гарааны бизнесийн экосистемд үзүүлэх нөлөө их тул стратегийн чухал байдлыг "том" гэж үзнэ. Мөн бизнесээ өргөжүүлэх чадвартай бизнес эрхлэгчдийг төрүүлж чадахгүй байгаа нь ноцтой асуудал учраас асуудлын цар хүрээг "том" гэж үнэлдэг. 2 "Хүний нөөц оруулж ирэх"-ийн тухайд дотоодын томоохон компани болон бусад байгууллагад ажиллах хүний нөөцийг гарааны бизнесийн экосистем руу урсгах, гадаадын хүний нөөцийг(гадаадад ажиллаж байсан Монгол хүнийг оролцуулан)Монголын гарааны бизнесийн экосистем рүү оруулах гэсэн 2 тал байгаа тул 2-1 "Дотоодын хүний нөөцийг гадагш гаргах", 2-2 "Гадаадын хүний нөөцийг оруулж ирэх" гэж ангилсан байна. Мөн, гарааны бизнесд хэрэгтэй хүний нөөцийг СхО(Chief х Officer -Ахлах мэргэжилтэн) хүний нөөц ба бусад хүний нөөц(инженерийн хүний нөөц(МХХТ-ийн хүний нөөц), борлуулалт, маркетингийн хүний нөөц, бусад хүний нөөц(бичиг хэрэг зэрэг)г.м.)-ээр хувааж тус бүрийн ажилд авах, ажлын байранд нь тогтоохтой асуудалд дүн шинжилгээ хийсэн.

2-1 "Дотоодод хүний нөөц оруулж ирэх" СхО (Chief х Officer -Ахлах мэргэжилтэн)хүний нөөцийн

тухайд стратегийн чухал байдлыг "жигжиг", хүнд байдлыг "жигжиг", асуудлын хүрээг "дунд" гэж үнэлсэн. Монголын дотоодын томоохон компанид ажилласан туршлагатай хүнийг ажилд авах хүсэлтэй бололч параметр бага тул ажилд авахад өрсөлдөөн ихтэй, ажилд авахад төвөгтэй байгаа нь өнөөдрийн бодит байдал байна. Бусад хүний нөөцийн хувьд шинэ төгсөгчид бизнес эрхлэхээс төвөгшихгүйгээр гарааны бизнесд ажилд орох эсвэл өөрөө бизнес эхлүүлэх явдал харагддаг. Өмнө нь өөр ажил хийж байсан хүний хувьд 2-3 жил болоод ажлаа солих г.м. шилжилт хөдөлгөөн их байна. Ажлаа солиход хүний нөөцийн зуучлах үйлчилгээ болон хувийн харилцаа, олон нийтийн сүлжээ г.м.-ээр шууд хандах арга нь голлож байгаа ба ажил олгоход асуудал байхгүй гэж хариулсан хүн ч байсан. Харин ч бизнесийн үүрэг хариуцлагын талаарх амлалт болон бизнесийн ур чадварын үүднээс харвал Монголын дотоодын хүний нөөцийн чанар өндөр биш, мөн ажлаас гарахад сэтгэл зовних зүйл бага гэсэн соёлын тал байгаа тул тогтвортой ажиллуулахад зардал их гардаг нь асуудал байдаг гэж сонссон тул чадварлаг хүний нөөцийг ажилд авч тогтвортой ажиллуулахтай холбоотой асуудал байгаа нь ил байна. СхО (Chief x Officer -Ахлах мэргэжилтэн)хүний нөөцийн тухайд Монголын дотоодод тус параметрийг өсгөхөд төвөгтэй бөгөөд бусад хүний нөөц(инженерийн хүний нөөц(МХХТ-ийн хүний нөөц), борлуулалт, маркетингийн хүний нөөц, бусад хүний нөөц(бичиг хэрэг зэрэг))-ийн хувьд ч мөн ижил нийт дотоодын хүний нөөцийг стандартыг нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх соёлыг өөрчлөх шаардлагатай учраас богино хугацаанд шийдвэрлэх хэцүү тул нэн яаралттай стратегийн чухал байдлыг "бага" гэж үнэлэв. Асуудлын хүнд байдлын талаар СхО (Chief x Officer -Ахлах мэргэжилтэн)хүний нөөцийг ажилд автал 1 жилээс илүү хугацаа зарцуулсан гэх байгуулга олон байгаа ч бусад хүний нөөц (инженерийн хүний нөөц(МХХТ-ийн хүний нөөц), борлуулалт, маркетингийн хүний нөөц, бусад хүний нөөц(бичиг хэрэг зэрэг))-ийг одоогийн байдлаар зохих хэмжээгээр ажилд авч байгаа гэсэн тул "дунд" гэж үнэлсэн.

2-2 "Гадаадаас хүний нөөц оруулж ирэх" тал дээр стратегийн чухал байдлыг "бага", хүндрэлтэй байдлыг "дунд", асуудлын хүрээг "дунд" гэж үнэлсэн. Монголд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авах нь тийм ч төвөгтэй биш байгаа ч өнөөгийн байдлаар гадаадын харъяалалтай хүмүүс, гадаадын гаралтай хүний нөөц гарааны бизнес рүү орж ирэх нь тийм ч их биш байна. Гадаадын зах зээлд гарч ажиллахын хувьд дотоодод сүлжээ үүссэн байгаа ба борлуулалт болон маркетинг хийж чаддаг хүний нөөц(гадаадын харъяалалтай хүний нөөц/ тухайн улсад амьдарч байгаа Монгол хүн)хэрэгтэй боловч хоорондын харилцаагүйн улмаас ажилд авах ажиллагаа төвөгтэй байдалтай байна. Асуудлын үнэлгээний тухайд гадаадын хүний нөөцийг ажилд авах нь гадаадад бизнесээ тэлэхэд Асуудлыг үнэлэхэд гадаадын хүний нөөцийг ажилд авах нь гадаад зах зээлээ тэлэхэд чухал хүчин зүйл мөн боловч нөгөө талаар гадаадад зах зээлээ тэлэхтэй холбоотой илүү чухал асуудлууд бас байна. Үүнд тухайн орны компанитай JV (Joint Venture -хамтарсан компани)эсвэл түншлэх гэх мэт аргаар бие биенээ орлох болон нөхөж ажиллах боломжтой тул стратегийн чухал байдлыг нь харьцангуй "бага", хүндрэлтэй байдлыг нь "дунд" гэж үзээд, асуудлын цар хүрээг "дунд" гэж үнэлсэн.

Хүснэгт 30 Алхам 1. Асуудлыг нарийвчлан тодорхойлох(Гарааны бизнесийн экосистемийг байгуулах (1) Хүний нөөц)

Хүснэгт 36 - Ахлах 1. Асуудлын нарийвчлан тодорхойлох (Гарааны бизнесийн экосистемийн байгуулах (1) Хүний нөөц)									
Зүйл		Зорилт болон өнөөгийн байдлын зөрүү			Асуудал	Асуудлын үнэлгээ			Үнэлгээн ий үр дүн: Асуудлы н цар хүрээ (том /дунд /жижиг)
		Зорилт	Өнөөгийн байдал	Нөөц		Стратегийн чухал байдал (том /дунд /жижиг)	Асуудлын хүндрэлтэй байдал (том /дунд /жижиг)	Одоо хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байх эсэх (Байна/Байхгүй)	
1 Хүний нөөцийг бий болгох	1-1 МХХТ-ийн хүний нөөцийн боловсрол	4-р бүлэг 1.(4) МХХТ, цахим хүний нөөцтэй нийцэх							
	1-2 Бизнес эрхлэгч хүний нөөцийн боловсрол	—(тохиргоо хийгээгүй)"Алсын хараа 2050"-д Дэлхий банкны Entrepreneurship Indicators-ээс иш татаж тоон үзүүлэлтийн зорилтыг тогтоосон боловч зөвхөн эмэгтэй бизнес эрхлэгчид хамаарах тоон үзүүлэлт	• Монгол улсын их сургууль болон Шинжлэх ухаан технологийн их сургууль зэрэг зарим дээд боловсролын байгууллагуудад бизнесийн санааг бий болгох болон бизнес эрхлэхийг дэмжиж байгаа боловч үйл ажиллагааг өргөжүүлэхтэй холбоотой дэмжлэг үзүүлдэггүй.	• ЖАЙКА-гийн тайлан(2023) ³⁶ • MONJA-д оролцох өргөдөл өгсөн гарааны бизнесүүдийн төлөв байдал • Газар дээрх ярилцлагын аргаар хийсэн судалгаа	• Бизнес эрхлэхтэй холбоотой дэмжлэг үзүүлж байгаа боловч том үр дүн гарсангүй. Инноваци болон бизнес эрхлэхтэй холбоотой чанартай хөтөлбөр гаргах боловсролын байгуулга ховор.	Их: Бизнес эрхлэгч хүний нөөцийг гаргах нь экосистемийн хувьд зайлшгүй шаардлагатай хүчин зүйл бөгөөд старатегийн чухал байдал "их"	Их: Өргөжих боломжтой бизнесийн загвартай бизнес эрхлэгчийг төрүүлж чадаагүй өнөөгийн байдлын асуудлын хүндрэлтэй байдал "их"	Байна: • Монгол улсын их сургууль болон Шинжлэх ухаан технологийн их сургууль, UFE нь өөрийн бизнес эрхлэлтийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. • Улсын 3 их сургууль(Монгол улсын их сургууль болон Шинжлэх ухаан технологийн их сургууль, Хөдөө аж ахуйн их сургууль) хамтарч хүний нөөц Япон руу илгээх хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.	Их
2 Хүний нөөц	2-1 Дотоодын хүний нөөцийн	-	• CxO (Chief x Officer -Ахлах мэргэжилтэн)хүний нөөц нь	• Газардээр нь ярилцлага	• CxO (Chief x Officer -Ахлах мэргэжилтэн)хүний нөөц нь	Бага: • CxO (Chief x Officer -Ахлах мэргэжилтэн)хүн	Дунд: • CxO (Chief x Officer -Ахлах мэргэжилтэн)х	Байхгүй	Дунд

	шилжилт хөдөлгөөний байдал		параметр цөөн тул ажилд авах талд өрсөлдөөн их Инженер, худалдааны хүний нөөцийн зах зээл жижиг, тогтвортой ажиллуулахад хүндрэлүүд их	хийх аргаар хийсэн судалгаа	Монголын дотоодод тохирох хүн ховор Бусад хүний нөөц нь үүрэг хариуцлагын амлалт болон ур чадварын үүднээс сайн хүний нөөц дотоодод цөөхөн байдаг	ий нөөцийг үндсээр нь нэмэгдүүлэх нь төвөгтэй бөгөөд стратегийн тэргүүний байдал бага Түүнчлэн, бусад хүний нөөцийг мөн адил, дотоодын хүний нөөцийг нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх соёлыг сайжруулах нь төвөгтэй	үний нөөцийг ажилд авахдаа 1-ээс дээш хугацаа зарцуулах тохиолдол байгаа ч хүндрэлтэй байдал маш их байна эдгээрээс бусад хүний нөөцийг ажилд авах нь одоогийн байдлаар дунд зэрэг		
	2-2 Гадаадын хүний нөөцийн шилжилт, хөдөлгөөний байдал	-	Хөдөлмөрийн зөвшөөрлийг авахад бэрхшээлтэй биш ч ер нь гадаадын харъяалалтай, гадаад гаралтай хүний нөөцийг гарааны бизнес руу оруулах урсгал бий болоогүй	Газардээр хийсэн ярилцлага хийх аргаар хийсэн судалгаа	Тухайн оронд харилцаатай хүний нөөцийг ажилд авах сүлжээ байхгүй	Бага: Гадаадад бизнэсээ тэлэх үүднээс чухал боловч зарим шалтгаанаар бусад асуудлууд нь том учраас харьцангуй бага	Дунд: Гадаадад бизнесээ тэлэхэд гадаад орны компанитай JV (Joint venture - хамтарсан ААН) болон түншлэл нь илүү чухал байгаа тул гадаадын хүний нөөцийг ажилд авах нь зайлшгүй нөхцөл биш тул дунд	Байхгүй	Дунд

(б) Монголын Засгийн газар болон Жайка-гийн тусламжийг тусгах судалгааны чухал салбарууд

1-2 "Бизнес эрхлэгчийн хүний нөөцийн боловсрол"-н тухайд хөгжлийн түншийн үйл ажиллагаа ажиглагдаагүй. Японы тусламжийн эх үүсвэрийн хувьд Бизнес эрхлэх боловсролын хөгжлийн бодлого(Боловсрол, шинжлэх ухааны яам)болон FoundX(Токио их сургууль), Васэда их сургуулийн Нээлттэй инновацийн стратегийн судалгааны хүрээлэн (Васэда их сургууль), J-Stax(Эдийн засаг аж үйлдвэрийн яам)зэргийг дурдаж болно. Асуудлын цар хүрээ том, дэмжлэгийн нөөц элбэг тул судалгааны тэргүүлэх салбар гэж үзсэн.

Хүснэгт 31 Алхам 2. Монголын Засгийн газар болон Жайка-гийн тусламжийг тусгах судалгааны чухал салбаруудийг нарийвчлан тодорхойлох(Гарааны бизнесийн экосистемийг байгуулах (1)Хүний нөөц)

Зүйл	Асуудал	Асуудлыг шийдвэрлэхэд ЖАЙКА-гийн тусламж шаардлагатай эсэх/боломжтой эсэхийг судлах		Үнэлгээний үр дүн: Судалгааны чухал салбар
		Хөгжлийн түнш байгаа эсэх	Японы дэмжлэгийн эх үүсвэр байгаа эсэх	
1-2 Бизнес эрхлэгчийн хүний нөөцийн боловсрол	• Бизнес эрхлэхтэй холбоотой дэмжлэг үзүүлж байгаа боловч том үр дүн гарсангүй. Инноваци болон бизнес эрхлэхтэй холбоотой чанар сайтай хөтөлбөрийг хэрэгжүүлэх боловсролын байгууллага ховор	Байхгүй	Байна • Entrepreneurship боловсролыг дэмжих арга хэмжээ (Боловсрол, шинжлэх ухааны яам) • FoundX(Токио их сургууль) • Васэда их сургуулийн Нээлттэй инновацийн стратегийн судалгааны хүрээлэн (Васэда их сургууль) • Их сургуулиас санаачилсан хурдасгах дэмжлэг (ЖАЙКА) • J-Stax(Эдийн засаг аж үйлдвэрийн яам) • Japan Innovation Campus(Эдийн засаг аж үйлдвэрийн яам)	Судалгааны чухал салбарууд

(в) Монголын засгийн газар болон ЖАЙКА-гийн тусламжийн чиглэл

1-2 "Бизнес эрхлэгчийн боловсрол"-ын тухайд "их сургуультай хамтарсан биенес эрхлэгчийн сургалтын хөтөлбөр" болон "Гадаадын гарааны бизнесийн экосистем-д хүний нөөц илгээж сургах" зэрэг дэмжлэгүүд багтана. Эхнийх нь Монголын дотоодын их сургууль болон мэргэжлийн сургуулиудтай хамтарч оюутнуудад бизнес эрхлэх боловсролын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлнэ. Сүүлийнх нь гарааны бизнесийн экосистем нь Монголоос илүү хөгжсөн орнуудын бизнес эрхлэгч болон их сургууль эсвэл инкуватор байгууламж болон зохион байгуулалттай арга хэмжээнд бизнес эрхлэгчдийг илгээж, Монголын дотоодоос авч чадахгүй чадвараас суралцуулна.

Хүснэгт 32 Алхам 3. Монголын засгийн газар болон ЖАЙКА-гийн тусламжийн чиглэл(Гарааны бизнесийн экосистемийг байгуулах (1)Хүний нөөц)

Зүйл	Үнэлгээний үр дүн		ЖАЙКА-ийн дэмжлэгийн чиглэл			
	Асуудлын цар хүрээ	Судалгааны чухал чиглэлүүд	Дэмжлэгийн цэс	Гол үйл ажиллагаа	Таамагласан схем	Түнш
1-2 Бизнес эрхлэгчийн хүний нөөцийн боловсрол	Их	Судалгааны чухал салбарууд	Их сургуультай хамтарсан бизнес эрхлэгчийн боловсролын хөтөлбөр	Монголын дотоодын боловсролын байгууллагатай хамтран бизнес эрхлэгчийн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Техникийн хамтын ажиллагааны төсөл	, Боловсрол, шинжлэх ухааны яам, МТ парк
			Гадаадын гарааны бизнесийн экосистем рүү хүний нөөцийг илгээх(Японыг оролцуулан)	Гарааны бизнесийн экосистем нь хөгжсөн орны бизнэс эрхлэгч/их сургууль руу илгээх Мөн инкубатарын байгууламж болон эвэнт арга хэмжээ зэрэгт оролцох хөтөлбөрийг хэрэгжүүлэх		

(2) Эд зүйлс

Гарааны бизнесийн хөгжилд, өрсөлдөх чадвартай технологийн үрийг бий болгох, том зах зээлийг зорилгоо болгох боломжыг хангах бизнесийн стратеги нь өөрөө нэг чухал хүчин зүйл тул эд зүйлс нь 1 "техникийн орчин", 2 "хангалттай ТАМ (Total Addressable Market)-г дагасан бизнесийн стратеги" 2-оос бүрдэнэ.

(а) Асуудал

1 "Техникийн орчин" нь, 1-1 "Их сургууль дээрх судалгааны хөгжүүлэлт", 1-2 "Хувийн хэвшил дээрх судалгааны хөгжүүлэлт" болон их сургууль, хувийн хэвшлийн хоёулангаас нь дүн шинжилгээ хийсэн.

1-1 "Их сургууль дээрх судалгааны хөгжүүлэлт" нь, стратегийн чухал байдал "бага", асуудлын хүндрэлтэй байдал "дунд", асуудалын цар хүрээг "дунд" гэж үнэлсэн. Монгол улс олон улсын патентийн өргөдөл гаргасан тоо нь 2023 онд 0 байсан. Гарааны бизнесийн 28% нь хувийн хэвшил, их сургуулийн түншлэлийг хэрэгжүүлж байгаа гэх боловч, ихэвчлэн сүлжээ болон ажилчдын ажил олголттой холбоотой чиглэлээр хамтран ажиллаж байгаа ба³⁶, их сургуулиас үүсэлтэй гарааны бизнесийн хувьд Монгол улсын их сургууль болон Шинжлэх ухаан технологийн их сургуульд цөөн хэдэн компани байгаагаас хэтрэхгүй байна. Судалгааны байгууламж болон лабораторын багаж тоног төхөөрөмжийн дутагдал, их сургуулиудын санхүүгийн дутагдал, АНН-тай хамтын ажиллагааны тогтолцоо бүрдээгүй, дээд боловсролын байгууллагын STEM хүний нөөцийг хөгжүүлэх чадвар хангалтгүй, зах зээлд гаргах чадвар дутмаг зэрэг их сургуулиудын чадвар дутуу байгаагаас болж, технологийн үрийг бизнес болгох боломжыг боловсролын байгууллагаас оюутнуудад хангалттай өгч чадахгүй байна. Мөн өдөөгийн байдлаар GAP сан (Нөхөлтийн сан) шиг санхүүгийн дэмжлэг үзүүлэх сан байхгүй байна. Харин дотоодын судалгааны түвшин тийм ч өндөр биш хөгжиж байгаа орны хувьд технологийн чадвар өндөр гарааны бизнес үүсгэх нь угаасаа саад бэрхшээл өндөр байгаа ба цаашид хөгжүүлэх нь хүндрэлтэй боловч чухал хүчин зүйлийн нэг тул стратегийн чухал байдлыг нь "бага", их сургуульд суурилсан гарааны бизнесийн тоо цөөн боловч экосистем дээрх гарааны бизнесийн тоо цөөхөн тул асуудлын хүндрэлтэй байдлыг "дунд", асуудлын цар хүрээг "дунд" гэж үнэлсэн.

1-2 "Хувийн хэвшилийн судалгааны хөгжүүлэлт" -ын стратегийн чухал байдлыг "бага", асуудлын хүндрэлийг "дунд", асуудлын цар хүрээг "дунд" гэж үнэлсэн. Deep tech-ийн тухайд судалгааны үүрэг болон инкубаторын үрэг бүхий байгууламж байхгүйн дээр аж үйлдвэрийн салбартай холбогдох цэг одоохондоо байхгүй байна. Science and Technology Park Шинжлэх ухаан технологийн парк баригдаж байгаа ба энэхүү үүргийг үүрэх болно. Стратегийн чухал байдал, асуудлын хүндрэлтэй байдал, асуудлын цар хүрээний талаар "их сургууль дээрх судалгааны хөгжүүлэлт" -тэй ижил үндэслэлээр тус бүр "бага""дунд""дунд" гэж үнэлсэн байна.

2 "хангалттай ТАМ-г эзлэх бизнесийн стратеги" нь 2-1 "Зах зээлийн хэмжээ, гадаадад бизнесээ тэлэх стратеги", 2-2 "бизнесийн компани хоорондын холбоо" гэсэн 2 үндэслэлээр дүн шинжилгээ хийсэн.

2-1 "том зах зээл, гадаадад бизнесээ тэлэх стратеги" -ийн стратегийн чухал байдлыг "том", асуудлын хүндрэлтэй байдлыг "том" стратегийн хүндрэлтэй байдлыг "том" асуудлын цар хүрээ "том" гэж үнэлсэн. Монголын хувьд гадаадад ажиллаж чадаж байгаа гарааны бизнес одоогоор 10-аас хэтрээгүй байна. Хурдасгуур нь Монголын дотоодод хэд хэдэн компани байгаа боловч гадаадад гарч ажиллахыг дэмжигч нь цөөхөн байгаа нь асуудалтай байна. Монголын дотоодын зах зээл жижиг гэсэн бодит байдлыг харгалзан үзэж бизнесээ өргөжүүлэхийн тулд гадаадын зах зээлд гарах нь зайлшгүй шаардлагатай тул стратегийн чухал байдал нь "их" байна. Мөн, А серид хүрсэн гарааны бизнес нь AND Global зэрэг 3-хан компани байгаа ба Монголтой ижил хэмжээний хүн амтай боловч олон гарааны бизгес гаргасан бусад орон(Жишээлбэл: Эстони, Армени зэрэг)байгаа тул бусад орнуудтай харьцуулсан ч энэхүү өнөөгийн байдлыг ноцтой хүнд гэж үзээд асуудлын болон асуудлын цар хүрээний хувьд "том" гэж үнэлсэн.

2-2 "бизнесийн компани хоорондын холбоо" -г старатегийн чухал байдлаар нь "дунд" хүндрэлтэй байдлыг нь "том" асуудлын цар хүрээг нь "том" гэж үнэлсэн. Монголын гарааны бизнесийн дотор ойролцоогоор 5% нь л нээлттэй инновацид(гадаад нөөцийг ашигласан инновацийг бий болгох арга. Ихэвчлэн томоохон компаниуд болон гарааны бизнесүүдийн хамтын бүтээлийн хүрээнд ашиглагддаг)оролцоогүй, Socratus болон MONOS, MSC Ventures зэрэг зарим том компаниуд гарааны бизнестэй хамтран ажиллах байдал харагддаг боловч том компаниас санхүүжилтийг авч байгаа гарааны бизнес нь одоохондоо ойролцоогоор 9%-тай байна³⁶. Асуудлын хувьд том компаниуд гарааны бизнес болон нээлттэй инновацийн талаарх ойлголт дутуу зэрэг том компанийн талын асуудал болон том компанитай хамтран ажиллах бүтээгдэхүүний хөгжүүлэлтийн түвшин, зах зээлд гаргах түвшинд хүрсэн гарааны бизнес цөөн зэрэг гарааны бизнес талын асуудалын аль алин байна гэж бодогдож байна. Нөгөөтэйгүүр Монголын дотоодод угаасаа дэлхийн түвшинд амжилттай ажиллаж байгаа том компани цөөн тул дотоодын бизнесийн компани хорондын холбоо нь гарааны бизнесийн үйл ажиллагаанд том хөгжил авчрах боломж өндөр биш гэж үзээд, стратегийн чухал байдлыг "дунд" гэж үнэлсэн. Нөгөө талаар нээлттэй инновацийн амжилттай жишээ бараг байхгүй нь бодит байдал бөгөөд асуудлын хүндрэлтэй байдал том учраас асуудлын цар хүрээг "том" гэж үнэлэв.

Хүснэгт 33 Алхам 1. Асуудлыг нарийвчлан тодорхойлох(Гарааны бизнесийн экосистемийг байгуулах (2)Эд зүйлс)

Зүйл		Зорилт болон өнөөгийн байдлын зөрүү			Асуудал	Асуудлын үнэлгээ			Үнэлгээний үр дүн: Асуудлын цар хүрээ (том /дунд /жижиг)
		Зорилт	Өнөөгийн байдал	Эх үүсвэр		Стратегийн чухал байдал (том /дунд /жижиг)	Асуудлын хүндрэлтэй байдал (том /дунд /жижиг)	Одоо хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байгаа эсэх	
1 Дэвшилтэт технологи үүсэх орчин	1-1 Их сургууль дээрх судалгааны хөгжүүлэлт	-	• 2023 оны Монголоос Олон улсын патентын өргөдөл гаргасан тоо нь 0 • Монгол улсын их сургууль болон Шинжлэх ухаан технологийн их сургууль л гарааны бизнес үүсгэсэн цөөн хэдэн жишээ байна	• ЖАЙКА-гийн тайлан(2023) , MONJA-д оролцох өргөдөл гаргасан гарааны бизнесийн төлөв байдал , Газар дээр нь ярилцах аргаар хийсэн судалгаа	, Монголын дотоодын судалгааны түвшин өндөр биш , Их сургууль нь технологийн үрийг бизнес болгох ноухау болон санхүүжилтийг бэлдэж чадаагүй	Бага: Технологийн орчин бүрэн бүрдээгүй хөгжиж буй орны хувьд технологийн өндөр чадвартай гарааны бизнесийг бий болгох нь бэрхшээлтэй тул хөгжилд чухал хүчийн зүйлийн хувьд бага	Дунд: Их сургуульд суурилсан гарааны бизнесийн тоо цөөхөн боловч нийт гарааны бизнесийн параметр нь цөөн байгаа тул асуудлын хүндрэлтэй байдлыг дунд гэж үзнэ.	Байна: Technology and Innovation Transfer Centers-г байгуулах	Дунд
	1-2 Хувийн хэвшил дэх судалгаа хөгжүүлэлт	-	, Science and Technology Park байгуулах тухай судалж байна	, Газар дээр нь ярилцах аргаар хийсэн судалгаа	, Deep tech салбарын судалгааны функц болон инкубаторын функцтай байгууламж байхгүй , Аж үйлдвэрийн салбартай	Бага: Дээрхтэй ижил	Дунд: Deep tech гарааны бизнесийн тоо цөөхөн ч нийт гарааны бизнесийн параметр цөөхөн тул асуудлын хүндрэлтэй	Байхгүй	Дунд

					холбогдсон байдал одоохондоо байхгүй		байдлыг дунд гэж үзнэ.		
2 Хангалттай ТАМ-тай бизнесийн стратеги	2-1 Том зах зээлийн хэмжээ, гадаадад тэлэх стратеги	-	, Гадаадад тэлж чадаж байгаа гарааны бизнес цөөхөн , Дотоодын хурдасгуурын гарааны бизнесийн гадаад руу өргөжих тэлэлтийг дэмжих дэмжлэг сул	, ЖАЙКА-ийн тайлан(2023) , Газар дээр нь ярилцах аргаар хийсэн судалгаа	, гарааны бизнес нь гадаадад өргөжин тэлэх хүртэл хөгжөөгүй , Гадаадын зах зээл дээрх тэлэлтийг дэмжиж чадах хангалттай чадвартай дэмжигч байхгүй	Их: Монголын дотоодын зах зээлийн хэмжээг харгалзан гадаадтай харилцаатай болох нь маш чухал	Их: Series А-д хүрсэн нь 1 компани байгаа бөгөөд өргөжих боломжтой гарааны бизнес маш цөөхөн	Байна: JICA, EBRD, MCS, Socratus зэрэг нь хурдасгах хөтөлбөрийг хэрэгжүүлж байна	Их
	2-2 Бизнесийн компанитай үүсгэсэн холбоо	-	, Гарааны бизнесийн ойролцоогоор 5% нь нээлттэй инновацид оролцож байна , Том хэмжээний компаниас санжүүжилт авсан гарааны бизнес нь ойролцоогоор 9%	, ЖАЙКА-гийн тайлан(2023) ³⁶ , Газар дээр нь ярилцах аргаар хийсэн судалгаа	, гарааны бизнес, нээлттэй инновацийн талаарх том компаниудын ойлголт дутуу • Том компаний хэрэгцээг хангах гарааны бизнес Монголын дотоодод цөөхөн байна	Дунд: Гарааны бизнесийг өргөжүүлэх нь чухал боловч Монголын дотоодын том компани цөөхөн тул нөлөөлөл бага	Их: Том компани нь SVC-ээр дамжуулан бизнесийн холбоо байгуулахыг оролдож байгаа ч амжилтанд хүрсэн тохиолдол цөөн	Байна: MCS, Monos нь хурдасгах хөтөлбөрөөр дамжуулан бизнесийн холбоог тогтоож ажилладаг	Их

(б) Монголын Засгийн газар болон Жайка-гийн тусламжийг тусгах судалгааны чухал чиглэлүүд

2-1 "Том хэмжээний зах зээл, гадаадад зах зээлээ тэлэх стратеги"-ийн хувьд 2 төрлийн дэмжлэгийг бодож байна. 1-рт чанарын талаас хандах хандлага болох, -Үр"-ийн шатан дахь гарааны бизнесийг А сериээс дээш шатанд хүртэл хөгжүүлэхийн тулд гадаад улсад илгээж ажилуулах зэрэг дэмжлэг үзүүлэх. 2-рт тоог өсгөх зорилгоор "Үр"-ийн өмнөх шатныхныг хамруулах хөтөлбөр хэрэгжүүлэх. Энэ нь одоо хэрэгжиж байгаа MONJA-г үргэлжлүүлэх хөтөлбөр болно. 2 төсөл хоёулаа техникийн хамтын ажиллагааны төсөл хэлбэрээр хэрэгжих бөгөөд тооцоолсон түнш нь MDDIC/ MT парк байх болно.

Хүснэгт 34 Алхам 3. Монголын засгийн газар болон ЖАЙКА-гийн тусламжийн чиглэл(гарааны бизнесийн экосистемийг байгуулах (2)Эд зүйлс)

Зүйл	Үнэлгээний үр дүн		ЖАЙКА-ийн дэмжлэгийн чиглэл			
	Асуудлын цар хүрээ	Судалгааны чухал салбарууд	Дэмжлэгийн цэс	Гол үйл ажиллагаа	Таамагласан схем	Түнш
2-1 Том хэмжээний зах зээлийн хэмжээ, гадаадад тэлж ажиллах стратеги	Их	Судалгааны чухал салбарууд	Чанарын хандлага: Төв Ази эсвэл Зүүн өмнөд азийн зах зээлд гарахыг дэмжих өргөн хүрээний хурдасгагч	Монголын гарааны бизнесийг гол тэлэх газар болгож буй Дундад ази болон Зүүн өмнөд ази руу тэлэлт дэмжих хурдасгах хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Техникийн хамтын ажиллагааны төсөл	• MDDIC • MT парк
			Тооны хандлага : Pre-seed (үр боловсрох өмнөх шатны) болон seed (үр боловсорч буй шатны) гарааны бизнесийг хамруулсан хурдасгах хөтөлбөр	seed (үр боловсорч буй шатны) гарааны бизнесийн тоог өсгөхийг зорьж одоогийн MONJA-г үргэлжлүүлнэ		

(в) Монголын засгийн газар болон ЖАЙКА-гийн тусламжийн арга хэмжээний чиглэл

2-1 "Том хэмжээний зах зээл, гадаадад бизнесээ тэлэх стратеги "-ийн тал дээр EBRD нь хурдасгах хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Японы дэмжлэгийн эх үүсвэр нь Эдийн заса, аж үйлдвэрийн яамны(METI)хэрэгжүүлэх Next innovator болон Жайка-гийн хэрэгжүүлж байгаа NINJA, MONJA болон JETRO-гийн хэрэгжүүлж байгаа J-Bridge зэргийг дурдаж болно. Асуудлын стратегийн чухал байдал болон хүндрэлтэй байдал нь том байгаа бөгөөд Японы дэмжлэгийн эх үүсвэрийг харгалзаж үзээд судлахад чухалчлах салбар гэж үзэв.

Хүснэгт 35 Алхам 2. Монголын засгийн газар болон ЖАЙКА-гийн тусламжийн арга хэмжээг тусгах судалгааны чухал салбарыг нарийвчилж тодорхойлох(гарааны бизнесийн экосистемийг байгуулах (2)Эд зүйлс)

Зүйл	Асуудал	Асуудлыг шийдвэрлэхэд ЖАЙКА-гийн тусламж шаардлагатай эсэх/боломжтой эсэхийг судлах		Үнэлгээний үр дүн: Судалгааны чухал салбарууд
		Хөгжлийн түнш байгаа эсэх	Японы дэмжлэгийн эх үүсвэр байгаа эсэх	
2-1 Том хэмжээний зах зээлийн хэмжээ, гадаадад зах зээлээ тэлэх стратеги	, гарааны бизнес нь гадаадад тэлэх хүртэл хөгжөөгүй байна , гадаадад тэлэхэд дэмжлэг үзүүлэхээр хангалттай чадвартай дэмжигч байхгүй	Байна: Star Venture Programme(EBRD)	Байна: , Next innovator(Эдийн засаг аж үйлдвэрийн яам)хөтөлбөрийг эхлүүлэх , NINJA, MONJA(JICA) , J-Bridge(JETRO)	Судалгааны чухал салбарууд

(3) Мөнгө

Гарааны бизнесд орох эрсдлийн мөнгийг 1 "санхүүгийн хэмжээ", 2 "олон янзын байдал", 3 "хөрвөх чадвар" гэсэн 3 үндэслэлээр авч үзнэ.


(а) Асуудал

1 "Санхүүгийн хэмжээ"-г 1-1 "дотоодын хөрөнгө оруулагчдад эрсдлийн хөрөнгө нийлүүлэлт", 1-2 "Гадаадын хөрөнгө оруулагчдын эрсдлийн хөрөнгийн нийлүүлэлт" гэсэн 2 үндэслэлээр дүн шинжилгээ хийсэн.

1-1 "дотоодын хөрөнгө оруулагчдад эрсдлийн хөрөнгө нийлүүлэлт" -ын стратегийн чухал байдлыг "их", асуудлын хүндрэлтэй байдал "их", асуудлын цар хүрээ "том" гэж үнэлсэн. Анхны хөрөнгө босгох үед цуглуулсан нийт дүн нь 13.4 тэрбум төгрөг(ойролцоогоор 0.58 тэрбум иен)(Гарааны бизнесийн тоо : 80 компани)гээд хараахан бага бөгөөд санхүүжилтийн үнэмлэхүй хэмжээ хангалттай гэж хэлж чадахгүй. Үүний цаана хувийн хөрөнгө оруулагчдын тоо хангалттай биш, хөгжөөгүй зах зээлд үндсэн хөрөнгө оруулалт хийх ёстой засгийн газрын холбогдох байгууллагуудын санхүүжилт нь нэг хэсгийн мөнгөн тэтгэмжийн хэмжээнд хүрээд зогссон гэж харагдаж байна. Дээрх шалтгааны улмаас гарааны хөрөнгийн 74% нь хувийн хадгаламжаас бүрддэг³⁶. Гарааны бизнесийг хөгжүүлэхэд зориулсан санхүүжилтийн үнэмлэхүй хэмжээний ач холбогдол нь "их" бөгөөд хязгаарлагдмал тооны ханган нийлүүлэгчдийг харгалзан үзвэл нөхцөл байдлын ноцтой байдал нь "том" бөгөөд сорилтуудын цар хүрээ нь "том" гэж үнэлэгддэг.

1-2 "Гадаадын хөрөнгө оруулагчдын эрсдлийн хөрөнгийн нийлүүлэлт" бас дотоодын хөрөнгө оруулагчдийн байдалтай адил стратегийн чухал байдал "их", асуудлын хүндрэлтэй байдал "их", сорилтын цар хүрээ "том" гэж үнэлэгдэв. Гадаадын хөрөнгө оруулагчидаас санжүүжилт авч байгаа гарааны бизнес нь өнөөдөр 5%-аас доош байна ³⁶. AND Global нь Mapүбэни болон SBI Holdings гэсэн гадаадын хөрөнгө оруулагчдаас хөрөнгө оруулалт авч байгаа ч, бусад олон гарааны бизнес нь гадаадын хөрөнгө оруулагчдаас хөрөнгө оруулалт авч чадахгүй байдалтай байгаа бөгөөд дотоодын хөрөнгө оруулагчтай ижил зарчмаар тус бүрийг "их" гэж үнэлсэн.

Figure 10: Source of initial funding, n=80




Эх сурвалж: JICA, START(2024)"MONGOLIAN STARTUP ECOSYSTEM 2023"

Зураг 32 Үүсгэн байгуулагдах эхний үеийн санхүүжилтийг бүрдүүлэх эх үүсвэр

2 "Олон янзын байдал" нь, 2-1 "хөрөнгө оруулалт", 2-2 "санхүүжилт", 2-3 "мөнгөн тэтгэмж" гэсэн 3 талаас дүн шинжилгээ хийж, "хөрөнгө оруулалт", "санхүүжилт", "мөнгөн тэтгэмж"-ийн аль алиныг нь стратегийн чухал байдал "их", асуудлын хүндрэлтэй байдал "их", асуудлын цај хүрээг "их" гэж үнэлсэн.

2-1 "хөрөнгө оруулалт"-ын талаар, хувийн хэвшлүүдэд хэд хэдэн ангел хөрөнгө оруулагч, VC нь 1, хэд хэдэн бизнесийн компани, PE (Permanent Establishment) нь 0, засгийн газрын холбогдох байгуулгын хувьд засгийн газрын сан, тэтгэвэрийн сан 2-оос гарааны бизнесд хөрөнгө оруулалт байхгүй, хандивлагчдаас гарааны бизнесд хөрөнгө оруулалт хийгээгүй, санхүүжилт өгөх хөрөнгө оруулагчдын тоо маш хязгаарлагдмал байдалтай байна. Хөгжингүй орнуудын экосистемд олон янзын хөрөнгө оруулагч байдаг ба, Монголын экосистемийн хөгжлийн хувьд ч чухал байгаа тул стратегийн чухал байдлыг "их", өнөөгийн хүндрэлтэй байдлыг "их", тиймээс асуудлын цар хүрээг "их" гэж үнэлнэ.

Figure 12: Source of follow-on funding, n=41



Эх сурвалж: JICA, START(2024)"MONGOLIAN STARTUP ECOSYSTEM 2023"

Зураг 33 Санхүүжилтийг бүрдүүлэх эх үүсвэр

2-2 "санхүүжилт" 2-3 "мөнгөн тэтгэмж" -ийн хувьд нийлүүлэгч нь хөрөнгө оруулалтаас илүү хязгаарлагдмал байна. "Санхүүжилт"-ийн хувьд Тамил зээлийн батлан даалтын сангийн төсөл саяхан байгуулагдсан ч бодитоор үйл ажиллагаа явуулж байгаа эсэх нь тодорхойгүй байна. Мөн, санхүүжилтийн гол хөрөнгө нийлүүлэгч болох ёстой банк нь жижиг дунд үйлдвэртэй ижил нөхцөл(хүү болон барьцаа)-г гарааны бизнесээс шаардаж байгаа бөгөөд одоогоор үйлчилгээ үзүүлээгүй байна. "Мөнгөн тэтгэмж"-ийн хувьд ч STF нь бага хэмжээний(MNB12B(ДНБ-ий 0.01%))-г нийлүүлсэн төдий ба гол тэтгэмж олгогч засгийн газар болон хөгжлийн дэмжлэгийн байгууллагуудын тэтгэмж хангалттай биш байна. Дээрх байдлыг харгалзаж үзээд аль ч үзүүлэлт нь "их" гэсэн үнэлгээ авна.

3 "Хөрвөх чанар" нь 3-1 "IPO", 3-2 "M&A", 3-3 "хоёрдогч зах зээл" гэсэн 3 үндэслэлээс бүрдэх бөгөөд

тус бүрийн стратегийн чухал байдал "дунд", хүндрэлтэй байдал "дунд", асуудлын цар хүрээг "дунд" гэж үнэлэгдсэн.

3-1 "IPO"-ий талаар судалгаа тайланд 80 компани орсноос 19 компани нь Exit (хувьцаа худалдах) туршлагатай гэж хариулсны 5% нь IPO байсан³⁶. IPO-ийн тоо цөөн байгаа нь асуудал гэж дурдаж болох бөгөөд шалтгааны хувьд Exit хийх хэмжээний гарааны бизнес цөөн, мөн Монголын хөрөнгийн бирж(MSE)гүйцэд хөгжөөгүйтэй холбоотой. MSE (Монголын хөрөнгийн бирж)-ийн зах зээлийн үнэлгээ нь 11 их наяд төгрөг (ойролцоогоор 472 тэрбум иен) буюу Монголын ДНБ-ий 20.8%-ийг эзлэх хэмжээний хэмжээтэй бөгөөд хөрөнгийн зах зээлийн хувьд хангалттай ажилладаггүй байна. Бүртгэгдсэн зах зээлийн хөрвөх чадвар нь бизнес эрхлэгч нарт урам зориг өгөх боловч өнөөгийн байдлаар хөрвөх чадвар нь бүртгэгдсэн түвшинд хүрсэн гарааны бизнесийн тоо цөөн тул хандлага нь дунд болон урт хугацаанд илүү болж шууд ач холбогдол багасах тул асуудлыг "дунд" гэж үнэлэв.

3-2 "M&A"-ийн хувьд дээр дурдсан 19 компанийн 95% нь томоохон компанид хувиараа байршуулж байсан туршлагатай гэж хариулсан ба өнөөгийн Exit-ийн 95% нь том компаниудын M&A гэгдэж байна³⁶. Харин Exit хийх үеийн үнэлгээ нь бусад орнуудтай харьцуулахад мөнгөний дүнгийн хэмжээ бага, эдийн засагт нөлөө ихтэй том хэмжээний гарааны бизнэсийн M&A явагдтал цаг хугацаа шаардагдахаар байна. Хөрөнгө оруулагчдын гарцыг бий болгох нь хөрөнгөө гарааны бизнесд оруулах хөрөнгө оруулагчдыг урамшуулах үүднээс чухал боловч, энэхүү нөхцөл байдлыг сайжруулахад цаг хугацаа шаардагдах тул чухал болон хүндрэлтэй байдал хоёуланд нь "дунд" гэж үнэлж байгаа ба асуудлын цар хүрээг бас "дунд" гэж үнэлсэн.

3-3 "Хоёрдогч зах зээл"-ийн хувьд одоохондоо Монголд хоёрдогч зах зээл байхгүй. Монголд хөрөнгө оруулагчдын эзэмшиж буй хувьцааг худалдах шаардлага гарсан үед хөрөнгө оруулагчид хоорондоо харилцан арилжаа хийж байгаа гэж үзэж байна. M&A-тэй ижил зарчмаар аль ч үзүүлэлтийг "дунд" гэж үнэлсэн.

Хүснэгт 36 Алхам 1. Асуудлыг нарийвчлан тодорхойлох(Гарааны бизнесийн экосистемийг байгуулах (3)Мөнгө)

Зүйл		Зорилт болон өнөөгийн байдлын зөрүү			Асуудал	Асуудлын үнэлгээ			Үнэлгээний үр дүн: Асуудлын цар хүрээ (том /дунд /жижиг)
		Зорилт	Өнөөгийн байдал	Нөөц		Стратегийн чухал байдал (том /дунд /жижиг)	Асуудлын хүндрэлтэй байдал (том /дунд /жижиг)	Одоо хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байгаа эсэх	
1 Хөрөнгийн хэмжээ	1-1 Дотоодын хөрөнгө оруулагчдын эрсдлийн хөрөнгийн нийлүүлэлт	-	, Анхны хөрөнгө босгох үед цуглуулсан нийт дүн: 13.4 тэрбум төгрөг (ойролцоогоор 580 сая иен) (80 гарааны бизнес), 2 дахь удаагийнхаас хойших хөрөнгө босгох үед цуглуулсан нийт дүн: 88.9 тэрбум төгрөг (ойролцоогоор 3.82 тэрбум иен) (41 гарааны бизнес)	• ЖАЙКА-ийн тайлан(2023) ³⁶	Гарааны бизнесд оруулах хөрөнгийн хэмжээ хангалтгүй байна. Асуудал нь дараах 2 байна - Засгийн газрын чиглэлийн байгуулгаас хөрөнгийн нийлүүлэлт байхгүй(зөвхөн мөнгөн тэтгэмж) - Хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдын тоо хангалттай биш	Их: Гарааны бизнесийн хөгжилд хөрөнгө нийлүүлэлт нэн чухал байгаа тул их	Их: Хөрөнгө оруулалт хийх үнэ цэнэ бүхий бизнес байх гэсэн урьдчилсан нөхцөлтэй боловч, өсгөх хөрөнгө бага өнөөгийн байдал бол ноцтой асуудал юм.	Байна: Шинжлэх ухаан технологийн сан(STF)-гийн тэтгэмж(гарааны бизнесд авах тухайлсан арга хэмжээ байхгүй)	Их
	1-2 Гадаадын хөрөнгө оруулагчды	-	- Гадаадын хөрөнгө оруулагчдаас санхүүжилт	- ЖАЙКА-ийн тал(2023) ³⁶	- Монголын гарааны бизнесийг сонирхдог	Их: Гадаадын хөрөнгө оруулагчдаас хөрөнгө	Их: Дээрхтэй ижил	Байна: НҮБ, ДБ-аас тэтгэмж олгодог	Их

	н эрсдлийн хөрөнгө нийлүүлэлт		авч байгаа гарааны бизнес 5%- иас бага		гадаадын хөрөнгө оруулагчид цөөн, хөрөнгийн хэмжээ хангалтгүй	нийлүүлэх нь гадаадад тэлэх суурь үндэс болж чадах тул, чухал			
2 Олон янзын байдал	2-1 Хөрөнгө оруулалт	-	• Ангел: Хэд хэдэн хүн • VC : 1 компани • PE : Гарааны бизнесд хөрөнгө оруулалт бараг байхгүй - Бизнесийн компани: Хэдэн компани гарааны бизнесд хөрөнгө оруулалт хийдэг - Засгийн газрын сан: Байхгүй - Тэтгэвэрийн сан : гарааны бизнесийн хөрөнгө оруулалт байхгүй	• ЖАЙКА-гийн тайлан(2023)³⁶ - Газар дээр нь ярилцах аргаар хийсэн судалгаа	- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчид нь Ангел, VC, бизнесийн компани байгаа бөгөөд VC нь зөвхөн 1 компани байгаа нь цөөн байна - Засгийн газраас хөрөнгө оруулалт, санхүүжилт байхгүй	Их: Хувьцаа гаргагчийн олон янзын байдлыг нэмэгдүүлэх нь цаашид экосистемийг хөгжүүлэх стратегийн хувьд чухал ач холбогдолтой юм	Их: Өсөлтийн хөрөнгө байхгүй бол бизнесийг хөгжүүлэхэд төвөгтэй тул өнөөгийн байдал ноцтой асуудалтай байна	Байна: EBRD нь Angel Investment Club-ийг байгуулсан	Их

			- Донорууд: - гарааны бизнесийн хөрөнгө оруулалт байхгүй						
2-2 Санхүүжил т	-	- Тамил зээлийн батлан даалтын сан байгуулагдса н ч ажиллаж байгаа эсэх нь тодорхой биш - гарааны бизнесд хөрөнгө санхүүжилт хийх банк бараг байхгүй	- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн зөвлөлийн бичиг материал - Газар дээр нь ярилцах аргаар хийсэн судалгаа	- гарааны бизнесд хөрөнгө санхүүжилт хийх банк бараг байхгүй • Санхүүжилттэ й холбоотой засгийн газрын үр дүнтэй дэмжлэг байхгүй	Их: Хувьцаа гаргагчид цөөхөн тул, санхүүжилт нь гарааны бизнесийг санхүүжүүлэх аргын нэг болж стратегийн хувьд маш чухал ач холбогдолтой юм	Их: Өсөлтийн хөрөнгө байхгүй бол бизнесийг хөгжүүлэхэ д төвөгтэй тул өнөөгийн асуудалтай байдал ноцтой байна	Байна: Тамил зээлийн батлан даалтын сан	Их	
2-3 Мөнгөн тэтгэмж	-	- гарааны бизнесд зориулсан мөнгөн тэтгэмж засгийн газар, засгийн газрын чиглэлийн санхүүгийн байгууллага хоёуланд нь бараг байхгүй - STF-ээс	- Газар дээр нь ярилцах аргаар хийсэн судалгаа	- Гарааны бизнесд зориулсан мөнгөн тэтгэмж засгийн газар, засгийн газрын чиглэлийн санхүүгийн байгууллага өнөөдөр бараг байхгүй. Гарааны бизнесд санхүүжүүлэл	Их: Өмч ба өрөөр санхүүжүүлэл т хийхэд төвөгтэй үе шат болон салбарт мөнгөн тэтгэмжийг олгох нь чухал ач холбогдолтой	Их: Өсөлтийн хөрөнгө байхгүй бол бизнесийг хөгжүүлэхэ д төвөгтэй тул өнөөгийн асуудалтай байдал ноцтой байна	Байна: • STF-ийн тэтгэмж(гараан ы бизнесд тухайлж зориулсан арга хэмжээ байхгүй) - Дэлхийн Банк бага хэмжээний мөнгөн тэтгэмжийг олгодог	Их	

			олгох мөнгөн тэтгэмж нь жилдээ 12 тэрбум төгрөг (ойролцоогоор 520 сая иен)(ДНБ-ийн 0.01%)ба хангалттай биш		т хийх арга хязгаарлагдмал байна				
3 Хөрвөх чадвар	3-1 IPO	-	• Exit-ийн 5% нь IPO	• ЖАЙКА-ийн тайлан(2023) ³⁶	- IPO хийж чадах түвшингийн гарааны бизнес цөөн - MSE-ийн хөрөнгийн зах зээлийн функц хангалттай биш	Дунд: Exit-ийн түвшинд хүрсэн гарааны бизнес цөөн, дунд урт хугацааны хандлагатай байгаа тул яаралтай чухал байдал бага болно	Дунд: Хөрөнгө оруулагчдын урам зоригд ихээр нөлөөлдөг	Байхгүй	Дунд
	3-2 M&A	-	- Exit-ийн 95% нь том компаний M&A - Exit-ийн үеийн үнэ цэнэ нь 12 дахин өндөр	• ЖАЙКА-гийн тайлан(2023) ³⁶	• Том компанийн M&A байгаа ч мөнгөн дүнгийн хэмжээ бага	Дунд: Хөрөнгө оруулагчдад Exit-ийн олон янзын байдал чухал боловч нэн тэргүүний ээлжинд биш	Дунд: Дээрхтэй ижил	Байхгүй	Дунд
	3-3 Хоёрдогч зах зээл	-	- Хоёрдогч зах зээл байхгүй	- Газар дээр нь ярилцах аргаар хийсэн судалгаа	- Exit хийх арга нь хязгаарлагдмал	Дунд: Дээрхтэй ижил	Дунд: Дээрхтэй ижил	Байхгүй	Дунд

(б) Монголын засгийн газар болон ЖАЙКА-ийн тусламжийг тусгах судалгааны чухал салбар

1-1 "Дотоодын хөрөнгө оруулагчдын эрсдлийн хөрөнгө нийлүүлэлт"-ийн тухайд EBRD нь Angel Investment Club-г байгуулж, Монголын дотоодын Ангел хөрөнгө оруулагчдийн нийгэмлэгийг хөгжүүлэхэд оролцож байна. Японы дэмжлэгийн эх үүсвэр бол ЖАЙКА-ийн хөгжиж буй орнуудын төр, хувийн хэвшлийн сан байгуулахад дэмжлэг үзүүлэх, Японы Санхүүгийн кооперацийн гарааны бизнесийг дэмжих хөрөнгө зэрэг Төрийн оролцоотой Венчур компаниас шууд хөрөнгө оруулалт, LP санхүүжилт, орон нутгийн захиргааны бизнес эрхлэхэд үзүүлэх санхүүжилт, тогтолцооны санхүүжилт, төрөл бүрийн тэтгэмж, Ангел албан татварын тогтолцоо зэрэг байна. Асуудлын цар хүрээ болон Японы дэмжлэгийн эх үүсвэрийг харгалзан үзээд, судлагаа чухалчлах салбарт хамруулна.

1-2 "Гадаадын хөрөнгө оруулагчдын эрсдлийн хөрөнгийн нийлүүлэлт"-ийн хувьд Дэлхийн банк тэтгэмж олгож байна. Японы дэмжлэгийн эх үүсвэрийн хувьд ЖАЙКА-ийн гадаадын хөрөнгө оруулалт, санхүүжилт байна. Асуудлын цар хүрээний хэмжээ болон Японы дэмжлэгийн эх үүсвэрийг харгалзаж үзээд судлагаа чухалчлах салбар гэж үзнэ.

2-1 "Хөрөнгө оруулалт", 2-2 "санхүүжилт", 2-3 "мөнгөн тэтгэмж"-ийн тухайд, дээр дурдсанчлан EBRD-ийн Angel Investment Club болон Дэлхийн банкны тэтгэмж олгож байгаа боловч бусад хөгжлийн түншүүдийн үйл ажиллагаа явагдаж байгаа нь мэдэгдсэнгүй. Японы дэмжлэгийн эх үүсвэр гэвэл хөрөнгө оруулалтын хувьд ЖАЙКА-ийн хөгжиж буй оруудад төр хувийн хэвшлийн сан байгуулахад нь дэмжих болон Төрийн оролцоотой Венчур компаниас шууд хөрөнгө оруулалт, LP санхүүжилт(ЛС, ЛСТ г.м.)үзүүлж, санхүүжилтийн хувьд Японы Санхүүгийн Корпорацийн бизнес эрхлэхэд дэмжих санхүүжилт үзүүлж, мөнгөн тэтгэмжийн хувьд мөн төрөл бүрийн байгууллагуудаас үзүүлж байгаа бөгөөд асуудлын цар хүрээ болон дэмжлэгийн боломжоос хамааран, судлагаа чухалчлах салбар гэж үзнэ.

Хүснэгт 37 Алхам 2. Монгол улсын засгийн газар болон ЖАЙКА-гийн тусламжийг тусгах судалгааны чухал салбарыг нарийвчлан тодорхойлох(гарааны бизнесийн экосистемийг байгуулах (3)Мөнгө)

Зүйл	Асуудал	Асуудлыг шийдвэрлэхэд ЖАЙКА-гийн тусламж шаардлагатай эсэх/боломжтой эсэхийг судлах		Үнэлгээний үр дүн: Судалгааны чухал салбарууд
		Хөгжлийн түнш байгаа эсэх	Японы дэмжлэгийн эх үүсвэр байгаа эсэх	
1-1 Дотоодын хөрөнгө оруулагчдын эрсдлийн хөрөнгийн нийлүүлэлт	SU-д оруулах хөрөнгийн хэмжээ хангалтгүй байна. Асуудал нь дараах 2 байна - Засгийн газраас санхүүжилт аваагүй (зөвхөн буцалтгүй тусламж) - Хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдын тоо хангалттай биш	Байна: EBRD нь Ангел хөрөнгө оруулалтын клубыг байгуулсан(үйл ажиллагааг Exponential Partners хариуцна)	Байна: - Шинээр хөгжиж буй орнуудын төр, хувийн хэвшлийн сан байгуулахад дэмжлэг үзүүлэх(ЖАЙКА) - Төрөл бүрийн санхүүжилт(Японы Санхүүгийн Корпораци) - Төрийн оролцоотой Венчур компаниас шууд хөрөнгө оруулалт, LP (Limited Partner) хөрөнгө оруулалт - Орон нутгийн засаг захиргаанаас олгож буй гарааны зээл, байгууллагын зээл - Төрөл бүрийн мөнгөн тэтгэмж	Судалгааны чухал салбарууд
1-2 Гадаадын хөрөнгө оруулагчдын	- Монголын гарааны бизнесийг сонирхож байгаа гадаадын хөрөнгө оруулагчид	Байна: Дэлхийн банк мөнгөн тэтгэмжийг олгож байна	Байна: Гадаадын хөрөнгө оруулалт, санхүүжилт(ЖАЙКА)	Судлахдаа чухалчлах салбар

эрсдлийн хөрөнгө нийлүүлэлт	цөөхөн, санхүүжилт хангалтгүй байна			
2-1 Хөрөнгө оруулалт	- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулагч нь зөвхөн Ангел, VC, бизнесийн компани бөгөөд VC нь зөвхөн 1 компани байгаа ба энэ нь цөөн байна - Засгийн газрын санхүүжилт, зээл байхгүй	Байна: EBRD нь Ангел хөрөнгө оруулалтын клубыг байгуулсан(үйл ажиллагааг Exponential Partners хариуцна)	Байна: - Шинээр хөгжиж буй орнуудын төр, хувийн хэвшлийн сан байгуулахад дэмжлэг үзүүлэх(ЖАЙКА) Төрийн оролцоотой Венчур компаниас шууд хөрөнгө оруулалт, LP (Limited Partner) хөрөнгө оруулалт	Судалгааны чухал салбарууд
2-2 Санхүүжилт	- Гарааны бизнесд санхүүжилт хийх банк бараг байхгүй - Санхүүжилтийн тал дээр үр дүнтэй засгийн газрын дэмжлэг байхгүй	Байхгүй	Байна: Гарааны бизнесийг дэмжих хөрөнгө(Японы Санхүүгийн Корпораци)	Судалгааны чухал салбарууд
2-3 Мөнгөн тэтгэмж	- Гарааны бизнесд зориулсан засгийн газар болон хөгжлийн байгууллагаас олгох мөнгөн тэтгэмж одоогоор бараг байхгүй, гарааны бизнесийн хөрөнгө босгох арга нь хязгаарлагдмал байна	Байна: Дэлхийн банк бага хэмжээний мөнгөн тэтгэмжийг олгож байна	Байна: • Бүтээгдэхүүн бүтээхийг дэмжих тэтгэмж(Жижиг дунд үйдвэрийг дэмжих байгуулга)	Судалгааны чухал салбарууд

(в) Монголын засгийн газар болон ЖАЙКА-гийн тусламжийн арга хэмжээний чиглэл

1 "Хөрөнгийн хэмжээ"-ний 1-1"Дотоодын хөрөнгө оруулагчдын эрсдлийн хөрөнгийн нийлүүлэлт", 1-2 " Гадаадын хөрөнгө оруулагчдын эрсдлийн хөрөнгийн нийлүүлэлт" нь " 2 үе шаттай хөрөнгө оруулалтын иений зээлийн төсөл", "хөрөнгө оруулагчдын боловсрол", "төр хувийн хэвшлийн санг байгуулах, ашиглахад дэмжлэг үзүүлэх" зэрэг байж болно. "2 үе шаттай хөрөнгө оруулалтын иений зээлийн төсөл" нь түнш-д иений зээлийг олгосноор VC болон банк руу хөрөнгө нийлүүлнэ. Ингэснээр VC нь хөрөнгө оруулалтын туршлагыг хуримтлуулж, VC салбар хөгжиж, гарааны бизнесд мөн эрсдлийн хөрөнгө нийлүүлэгдэнэ. Иений хөнгөлттэй зээлийн тусламжаар(иений хөнгөлттэй зээл) хэрэгжих ба төсөөлөгдөж буй түнш нь Сангийн яам юм.

"Хөрөнгө оруулагчдын боловсрол" тал дээр Ангел хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтын чадварыг сайжруулж, гарааны бизнэсийн хөрөнгө оруулалтын ойлголт болон аргачлалын тал дээр гарааны бизнесийн хөрөнгө босгох тухай зааварчилгааг нээлттэй болгох зэрэг хөрөнгө оруулагчдад зориулж хувь нэмэр оруулах хөтөлбөр юм. Техникийн хамтын ажиллагаа төсөл болон хэрэгжүүлэхээр төлөвлөж буй иений хөнгөлттэй зээлийн(иений зээл) түнш нь Эдийн засгийн хөгжлийн яам эсвэл Сангийн яам байна. "Төр, хувийн хэвшлийн сан байгуулж ашиглалтыг дэмжих" тал дээр Монголын засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан сан байгуулж, ЖАЙКА-аас Монголын засгийн газарт хөрөнгө оруулах зардлыг иений хөнгөлттэй зээлээр олгох төсөл хэрэгжинэ. Иений хөнгөлттэй зээлээр (иений зээл)хийх хамтын ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөж буй бөгөөд, түнш нь Сангийн яам болно.

2 "Олон янзын байдал"-ын 2-1 "Хөрөнгө оруулалт" 2-2 "санхүүжилт"-ын тухайд дээр дурдсанчлан "Төр хувийн хэвшлийн сан байгуулж ашиглахыг дэмжих", "2 үе шаттай хөрөнгө оруулалтын иений

зээлийн төсөл" байх юм. "Санхүүжилт"-ийн тухайд, Японы Санхүүгийн Корпорацийн Японд үзүүлдэгтэй адил бага хүүтэй бизнес эхлэх хөрөнгийн санхүүжилтийг төсөөлж, "Үр"-ийн өмнөх шат, "Үр"-ийн шатанд буй гарааны бизнесийг дэмжих зорилготой. Үүнийг иений хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэхээр төсөөлж, түнш нь Сангийн яам байх болно. 2-3 "Мөнгөн тэтгэмж" нь, хурдасгуур хөтөлбөрт төр хувийн хэвшлээс дэмжигчдийг татаж мөнгөн тэтгэмжтэй хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. Тус тусламж нь техникийн хамтын ажиллагааны, төслүүд байх ба түнш нь MT Park дээр хэрэгжүүлэхээр төсөөлж байна.

Хүснэгт 38 Алхам 3. Монгол улсын засгийн газар болон ЖАЙКА-гийн дэмжлэгийн арга хэмжээний чиглэл(Гарааны бизнесийн экосистемийг байгуулах (3)Мөнгө)

Зүйл	Үнэлгээний үр дүн		ЖАЙКА-гийн дэмжлэгийн чиглэл			
	Асуудлын цар хүрээ	Судалгааны тэргүүлэх чиглэлүүд	Дэмжлэгийн цэс	Гол үйл ажиллагаа	Таамагласан схем	Түнш
1-1 Дотоодын хөрөнгө оруулагчдын эрсдлийн хөрөнгийн нийлүүлэлт	Их	Судалгааны чухал чиглэлүүд	2 үе шаттай хөрөнгө оруулалтын иений хөнгөлөлттэй зээлийн төсөл	Түнш-д иений хөнгөлөлттэй зээлийг олгосноор VC болон банкинд хөрөнгө оруулалтын хөрөнгийг нийлүүлнэ	Зээл тусламж хамтын ажиллагаа (иений хөнгөлөлттэй зээл)	Сангийн яам
			Хөрөнгө оруулагчдын боловсрол	Ангел хөрөнгө оруулагчдын клубтэй хамтарсан Ангел хөрөнгө оруулагчдад зориулсан гарааны бизнесд хөрөнгө оруулах талаарх ойлголт болон аргачлалтай холбогдох зааварчилгаа танилцуулга зэрэг боловсролын хөтөлбөрийг зохион байгуулах. Гарааны бизнес дэх хөрөнгө оруулалтын эрсдэл, үнэ цэнийн үнэлгээний үзэл баримтлалын талаарх таамаглал	- Техникийн хамтын ажиллагааны төсөл - Зээл тусламж хамтын ажиллагаа (иений хөнгөлөлттэй зээл)	MDDIC Сангийн яам MT парк
1-2 Гадаадын хөрөнгө оруулагчдын эрсдлийн хөрөнгийг нийлүүлэх	Их	Судалгааны чухал чиглэлүүд	Төр, хувийн хэвшлийн сан байгуулах, ажиллуулахад дэмжлэг үзүүлэх	- Монголын засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан санхүүжилтийн сан байгуулахад дэмжлэг үзүүлэх - ЖАЙКА-гаас Монголын Засгийн газарт хөрөнгө оруулалтын зардалд зориулж иений хөнгөлөлттэй зээл олгох - Хөрөнгийн хэмжээг өсгөх, мөн хөрөнгө оруулалт татахыг зорилго болгоно.	- Зээл тусламж хамтын ажиллагаа (иений хөнгөлөлттэй зээл)	Сангийн яам

2-1 Хөрөнгө оруулалт	Их	Судалгааны чухал чиглэлүүд	Төр, хувийн хэвшлийн сан байгуулах, ажиллуулахад дэмжлэг үзүүлэх	Монголын засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан санхүүжилтийн сан байгуулахад дэмжлэг үзүүлэх - ЖАЙКА-гаас Монголын Засгийн газарт хөрөнгө оруулалтын зардалд зориулж иений хөнгөлөлттэй зээл олгох - Үндсэн хөрөнгийн хэмжээг өсгөх, мөн хөрөнгө оруулалт татахыг зорилго болгоно.	- Зээл тусламж хамтын ажиллагаа (иений хөнгөлөлттэй зээл)	Сангийн яам
2-2 Санхүүжилт	Их	Судалгааны чухал чиглэлүүд	Монголын Засгийн газрын гарааны бизнесийг санхүүжүүлэх механизмыг бий болгоход дэмжих (Хоёр шатлалт иений хөнгөлөлттэй зээлийн төсөл)	- Японы Санхүүгийн Корпорацийн схемийг Монголд нэвтрүүлэх - Санхүүжилтэд шаардлагатай хөрөнгийг хоёр шатлалтай иений хөнгөлөлттэй зээлээр олгох	- Зээл тусламж хамтын ажиллагаа (иений хөнгөлөлттэй зээл)	Сангийн яам
2-3 Мөнгөн тэтгэмж	Их	Судалгааны чухал чиглэлүүд	Ивээн тэтгэх замаар татаас олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн(өргөн цар хүрээтэй хурдасгуур, MONJA г.м.)ивээн тэтгэгчийг цуглуулан, гарааны бизнесд татаас олгох	Техникийн хамтын ажиллагааны төсөл	МТ парк

(4) Бодлого, хууль тогтоомж

(a) Асуудал

"Бодлого, хууль тогтоомж"-ын тухайд стратегийн чухал байдлыг "их", асуудлын ноцтой байдлыг "дунд", асуудлыг цар хүрээг "их" гэж үнэлэв. Одоо, монголд инноваци болон гарааны биенесийн тухай заасан хууль тогтоомж дараах байдалтай байна.

- Шинжлэх ухаан технологийн сан(STF)(1993он)
- Хөрөнгө оруулалтын тухай хууль(2013 он)
- Инновацийн тухай хууль(2014 он, (2019 онд шинэчлэн найруулсан))
- Алсын хараа 2050
- Мэдээлэл Харилцаа Холбооны Технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх тухай хууль(2024 он)

STF нь дээр дурдсанчлан мөнгөн тэтгэмжийг олгох тухай заасан бөгөөд олгох мөнгөн дүн нь хангалттай бус байна. Хөрөнгө оруулалтын тухай хууль нь хөрөнгө оруулагчдад үзүүлэх татварын хөнгөлөлтийн тухай агуулга нь хөгжингүй орнуудыхтай харьцуулахад хангалттай биш байна.

Инновацийн тухай хуульд гарааны бизнесд татварын хөнгөлөлт үзүүлэх тухай заасан байгаа боловч гарааны биенесийн тухай тодорхойлолт нь явцуу, хамрах хүрээ маш хязгаарлагдмал гэсэн асуудлуудтай байна.

МХХТ-ийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх тухай хуулийн тухайд, МТ парк нь гарааны бизнесд мэдээллийн технологитой холбоотой бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж эхэлсэн ба МХХТ-ийн

үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд Засгийн газар, орон нутгийн захиргааны эрх мэдэл ба хариуцлагыг зааж өгсөн байна. Засгийн газрын үүргийн хувьд, Засгийн газар МХХТ-ийн үйлдвэрлэлийг дэмжих Виртуал бүсийг байгуулж, Виртуал бүсэд бүртгэгдсэн компаниудад албан татвар болон татварын бус дэмжлэгийг үлүүлэх тухай заасан байна. Татварын тухай дэмжлэгийн тухай хуулийн заалтуудаас нарийвчилсан агуулгыг тодруулж чадаагүй. Татвараас бусад дэмжлэгийн тухайд, (1) Патентийн бүртгэлийн зардалтай холбоотой мөнгөн дэмжлэг олгох, (2) Экспорт явуулахад олон улсын чанар, стандартын баталгаажуулалтын зардалтай холбоотой мөнгөн дэмжлэг олгох, (3) Нийгмийн даатгалын шимтгэлд нөхөн олгобор олгох, (4) АИ-тай холбоотой үйл ажиллагаанд нийт зардлын 60%-аас дээш хувийг өөрийн хөрөнгөөр бүрдүүлсэн бол үлдэгдэлд нь мөнгөн тэтгэмж олгох, (5) Дэвшилтэт технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээний патент эзэмшигчид шагнал, урамшуулал өгөх, (6) Зээлийн баталгаа гаргах, (7) Судалгаа хөгжүүлэлтийн зардлыг хамгийн ихдээ 70%-ийн 1 удаагийн дэмжлэгийн мөнгийг олгох, (8) Санхүүжилтийн хүүтэй холбоотой дэмжлэг, (9) Өмч хөрөнгийн хугацаанаас эрт элэгдлийг зөвшөөрөх зэрэг хөнгөлөлтийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Нөгөө талаар, голдуу хүний нөөц, сүлжээг байгуулахтай холбоотой дэмжлэг болон хөрөнгө нийлүүлэлтийг нэмэрдүүлэх, гарах стратегийг төрөлжүүлэх гэх мэт дурдагдаагүй зүйл дээр, гарааны биенесийн хөгжилд шаардлагатай хүчин зүйлүүдийг цогцоор нь багтаасан гэж хэлж чадахгүй.

Бизнес эрхлэхийг дэмжих болон хөрөнгө оруулагчдын үйл ажиллагааг идэвхижүүлэхэд чиглэн, бодлогын дэмжлэгийг системчлэх нь чухал тул стратегийн чухал байдлыг нь "их" гэж үзэж байна. Харин, гарааны бизнестэй холбоотой үйл ажиллагааг шаардлагагүйгээр хязгаарлах гэх мэт зохицуулалт харагдаагүй тул асуудлын ноцтой байдлыг "дунд" гэж үнэлсэн. Бодлогын дэмжлэгийг системчлэх нь цаашдаа бодлого, хууль тогтоомжыг чанаржуулах ба гарааны бизнесийн экосистемийн дунд болон урт хугацааны хөгжилд зайлшгүй шаардлагатай байгаа тул стратегийн чухал байдлыг чухалчилж асуудлын цар хүрээг "их" гэж үнэлсэн.

Хүснэгт 39 Алхам 1. Асуудлыг нарийвчлан тодорхойлох(гарааны бизнесийн экосистемийг байгуулах (4)Бодлого, хууль тогтоомж)

Зүйл	Зорилт болон өнөөгийн байдлын зөрүү			Асуудал	Асуудлын үнэлгээ			Үнэлгээн ий үр дүн: Асуудлын цар хүрээ (том /дунд /жижиг)
	Зорилт	Өнөөгийн байдал	Нөөц		Стратегийн чухал байдал (том /дунд /жижиг)	Асуудлын хүндрэлтэй байдал (том /дунд /жижиг)	Одоо хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байгаа эсэх	
Бодлого, хууль зохицуулалт	-	Инноваци болон гарааны бизнесийн тухай заасан хууль тогтоомжуудыг доор дурдав. - Шинжлэх ухаан технологийн сан(STF)(1993он) - Хөрөнгө оруулалтын тухай хууль(2013 он) - Инновацийн тухай хууль(2014 он, (2019 онд шинэчлэн найруулгдсан)) : Инновацийн талаар засгийн газрын хүлээх үүрэг, үйл ажиллагааг тусгасан - Алсын хараа 2050 - Эдийн засгийн хөгжлийн яам болон Цахим харилцаа, хөгжлийн яам(2022 он) - Мэдээлэл Харилцаа Холбооны Технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх тухай хууль(2024 он)	-	• STF : Мөнгөн тэтгэмжийн тухай хууль. ДНБ-д эзлэх харьцаагаар харьцуулж үзсэн тохиолдолд бусад орнуудтай харьцуулахад мөнгөн тэтгэмжийн хэмжээ хангалтгүй - Хөрөнгө оруулалтын тухай хууль: Хөрөнгө оруулагчдад албан татварын хөнгөлөлт үзүүлэх нь хангалтгүй - Инновацийн тухай хууль: Гарааны бизнесд зориулсан албан татварын хөнгөлөлт байгаа ч, гарааны бизнесийн тухай тодорхойлолт явцуу, хамрах хүрээ хязгаарлагдмал	Их: Бизнес эрхлэлтийг дэмжих болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг идэвхжүүлэх эд бодлогын дэмжлэгийг системчлэх нь чухал	Дунд: Гарааны бизнестэй холбоотой хөгжүүлэх үйл ажиллагааг хЯзгаарлаагүй байна. Мөн, одоогийн арга хэмжээ зэрэг зарим үйл ажиллагаа ажиглагдаж байгаа ч хатуу зохицуулалт байхгүй тул, дунд	Байна: Гарааны бизнесд зориулсан албан татварын хөнгөлөлт, эдийн засгийн тусгай бүс байгуулах зэрэгтэй холбоотой хэлэлцүүлэг явагдаж байгаа.	Их

(б) Монголын засгийн газар болон ЖАЙКА-гийн тусламжийн арга хэмжээний чиглэл "Бодлого, хууль тогтоомж"-ын тухайд, хөгжлийн түншийн үйл ажиллагаа ажиглагдаагүй. Японы дэмжлэгийн нөөцийн тухайд Эдийн засаг аж үйлдвэрийн яамны гарааны бизнестэй холбоотой бодлого боловсруулалт, хэрэгжилт болон, ЖАЙКА-гийн Нигерийн Startup Act-ыг дэмжлэгийн туршлагыг дурдаж болно. Асуудлын цар хүрээг харгалзаж, судалгааны тэргүүлэх чиглэлүүд болгосон.

Хүснэгт 40 Алхам 2. Монголын Засгийн газар болон ЖАЙКА-гийн дэмжлэгийг тусгах судалгааны чухал чиглэлүүдийг нарийвчлан тодорхойлох(Гарааны бизнесийн экосистемийг байгуулах (4)Бодлого, Хууль тогтоомж)

Зүйл	Асуудал	Асуудлыг шийдвэрлэхэд ЖАЙКА-гийн тусламж шаардлагатай эсэх/боломжтой эсэхийг судлах		Үнэлгээний үр дүн: Судалгааны чухал салбарууд
		Хөгжлийн түнш байгаа эсэх	Японы дэмжлэгийн эх үүсвэр байх эсэх	
Бодлого, хууль тогтоомж	- STF : Мөнгөн тэтгэмжийн тухай хууль Бусад улстай ДНБ-д эзлэх хувийг харьцуулж үзэхэд мөнгөн дүн нь хангалтгүй - Хөрөнгө оруулалтын тухай хууль: Хөрөнгө оруулагчдад албан татварын хөнгөлөлт хангалтгүй - Инновацийн тухай хууль: Гарааны бизнесд зориулсан албан татварын хөнгөлөлт үзүүлдэг боловч, гарааны бизнэсийн тодорхойлолт явцуу, хамрах хүрээ хязгаарлагдмал	Байхгүй	Байна: - Гарааны бизнестэй холбоотой бодлого боловсруулалт, хэрэгжүүлэлт(Эдийн засаг аж үйлдвэрийн яам) - Нигерийн Startup Act-ад дэмжлэг үзүүлсэн туршлага(ЖАЙКА)	Судалгааны чухал чиглэлүүд

(в) Монголын засгийн газар болон ЖАЙКА-гийн тусламжийн арга хэмжээний чиглэл "Бодлого, хууль тогтоомж"-инд гарааны бизнесийн тухай хуулийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, гарааны бизнесийн тухай хууль боловсруулахад төвөгтэй байвал хөрөнгө оруулагчдад албан татварын хөнгөлөлт үзүүлэх зэрэг тусгайлсан хөрөнгө оруулалт, санхүүжилтийг дэмжих арга хэмжээг тогтоохыг судлах. Түүнчлэн Ажлын хэсэг байгуулж, MDDIC/Эдийн засгийн хөгжлийн яамтай бодлогын яриа хэлэлцээ хийж, шаардлагатай санал, дүгнэлтээр хангахв Таамаглах схем нь техникийн хамтын ажиллагааны төсөл юм.

Хүснэгт 41 Алхам 3. Монголын засгийн газар болон ЖАЙКА-гийн дэмжлэгийн арга хэмжээний чиглэл(гарааны бизнесийн экосистемийн байгуулах(4)Бодлого, хууль тогтоомж)

Зүйл	Үнэлгээний үр дүн		ЖАЙКА-ийн дэмжлэгийн чиглэл			
	Асуудлын цар хүрээ	Судалгааны чухал чиглэлүүд	Дэмжлэгийн цэс	Гол үйл ажиллагаа	Таамагласан схем	Түнш
Бодлого, Хууль тогтоомж	Их	Судалгааны чухал чиглэлүүд	Гарааны бизнестэй холбоотой хууль тогтоомжыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх	- Гарааны бизнесийн тухай хуулийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх Эсвэл хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтыг татвараас чөлөөлөх зэрэг хөшүүргийг бий болгоход хувь нэмрээ оруулах, хатуу зохицуулалтыг бууруулах асуудлыг авч үзэх ажлын хэсэг байгуулж, үйл ажиллагааг нь дэмжинэ. хөрөнгө оруулагчид зэрэгт хөрөнгө оруулалтын албан татавараас чөлөөлөх арга хэмжээ зэрэг, урамшуулалыг бий болгоход хувь нэмэр оруулахуйц зохицуулалтыг зөөлрүүлэх зэргийн хэлэлцэх ажлын хэсгийг байгуулах • ашиглалтыг дэмжих	Техникийн хамтын ажиллагааны төсөл	MDDIC/Эдийн засаг хөгжлийн яам

(5) Сүлжээ

(а) Асуудал

"Сүлжээ"-ний тухайд стратегийн чухал байдлыг "их", ноцтой байдлыг "их", асуудлын цар хүрээг "их" гэж үнэлсэн.

Дотоодын сүлжээний хувьд зөөлөн(үйл ажиллагаа, холбоо, нийгэмлэг), хатуу(инновацийн байгууламж)-ийн алин ч хангалттай гэж үзэж байна. Зөөлөн нь, үйл ажиллагаа: Startup-Challenge-Mongolia г.м., холбоо нь: Angel Investment Club г.м., нийгэмлэг нь: MT парк г.м. байгаа бөгөөд, хатуу сүлжээний хувьд, инновацийн байгууламж: MT парк, MONOS, MCS Ventuers г.м. нь орон зайг хангаж байна. Нөгөөтэйгүүр, гадаадын сүлжээний тухайд, MT паркийн хэрэгжүүлдэг Startup Challenge-н шагналт байр эзлэгчид төв Азитай холбогдох сүлжээг хангахаас цаашгүй, хатуу тал дээр онцын арга хэмжээ авсан зүйл ажиглагдахгүй байна. Экосистемийн хувьд гадаадтай холбогдох сүлжээ байгуулахыг дэмжих хүч сул, гарааны бизнес нь өөрөө хурдасгуурт хүсэлт гаргах, хувь хүмүүсийн харилцаанд тулгуурлан сүлжээ бий болгох зэрэг, төрөл бүрийн арга хэмжээ авч байгаа байдалтай байна. Сүлжээ байгуулах үүднээс гадаад дахь зах зээлээ тэлэхэд дэмжлэг үзүүлэх чадвар нь асуудал болж байна. Дээрхээс үзэхэд, стратегийн чухал байдал, ноцтой байдал, асуудлын цар хүрээ бүгдэд нь "их" гэж үнэлгээ өгсөн.

Хүснэгт 42 Алхам 1. Асуудлыг нарийвчлан тодорхойлох(гарааны бизнесийн экосистемийг байгуулах (5)Сүлжээ)

Зүйл	Зорилт болон өнөөгийн байдлыг зөрүү			Асуудал	Асуудлын үнэлгээ			Үнэлгээний үр дүн: Асуудлын цар хүрээ (том /дунд /жижиг)
	Зорилт	Өнөөгийн байдал	Эх үүсвэр		Стратегийн чухал байдал (том /дунд /жижиг)	Асуудлын хүндрэлтэй байдал (том /дунд /жижиг)	Одоо хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байгаа эсэх	
Сүлжээ	-	- Дотоодын сүлжээ Зөөлөн, хатуугийн алин ч хангалттай. Зөөлөн(Startup-Challenge-Mongolia, Angel Investment клуб, IT Park г.м.), Хатуу(IT Park, MONOS, MCS Ventures г.м.) - Гадаадын сүлжээ Зөөлн тал дээр зөвхөн МТ парк л Startup Challenge-д шагналт байр эзлэгчид төв азитай сүлжээ тогтоох боломжийг олгодог. Хатуугийн тал дээр онцын арга хэмжээ байхгүй. Экосистемийн хувьд гадаад сүлжээ тогтоохыг дэмжих чадвар сул тул, гарааны бизнес нь өөрөө хурдасгуурт хүсэлт тавих, хувь хүний харилцаанд тулгуурлан сүлжээ тогтоох зэрэг, компани бүр тусдаа арга хэмжээ авах шаардлагатай байна	- Газар дээр нь ярилцлах аргаар хийсэн судалгаа	- Гадаадын экосистемтэй тогтоосон харилцаа цөөн, гарааны бизнесүүдэд гадаадад тэлэх боломжыг өгч чадахгүй байна	Их: Гарааны бизнесийг гадаадад зах зээлээ тэлэхийн тулд гадаадтай тогтоосон сүлжээ чухал	Их: Компани бүр тус тусдаа бусад орны хөтөлбөрд өргөдлөө явуулж байгаа боловч оролцож байгаа компани нь ховор	Байхгүй	Их

(б) Монголын засгийн газар болон ЖАЙКА-гийн тусламжийн арга хэмжээний чиглэл

"Сүлжээ"-ний хувьд хөгжлийн түншийн үйл ажиллагааны тал дээр зөвхөн EBRD-ын Star Venture Program л байна. Японы дэмжлэгийн эх үүсвэрийн тухайд, JETRO болон ЖАЙКА хурдасгуур хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд, хөтөлбөрөөр дамжуулан гадаад сүлжээг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулж байна. Асуудлын цар хүрээ болон дэмжлэгийн эх үүсвэрийг харгалзан, судалгааны тэргүүлэх чиглэлүүд болгосон.

Хүснэгт 43 Алхам 2. Монголын Засгийн газар болон ЖАЙКА-гийн дэмжлэгийг тусгах судалгааны чухал чиглэлүүдийг нарийвчлан тодорхойлох(гарааны бизнесийн экосистемийг байгуулах (5)Сүлжээ)

Зүйл	Асуудал	Асуудлыг шийдвэрлэхэд ЖАЙКА-гийн тусламж шаардлагатай эсэх/боломжтой эсэхийг судлах		Үнэлгээний үр дүн: Судалгааны чухал чиглэлүүд
		Хөгжлийн түнш байгаа эсэх	Японы дэмжлэгийн эх үүсвэр байгаа эсэх	
Сүлжээ	- Гадаадын экосистемтэй тогтоосон харилцаа цөөн, гарааны бизнесүүдэд гадаадад тэлэх боломжыг өгч чадахгүй байна	Байна: Star Venture Program (EBRD)	Байна: - Global Acceleration Hub (JETRO) - NINJA, MONJA (JICA)	Судалгааны чухал чиглэлүүд

(в) Монголын засгийн газар болон ЖАЙКА-гийн тусламжийг тусгах судалгааны чухал чиглэлүүд

"Сүлжээ" -нд гол онцлох зүйл нь гадаадын экосистем/тоглогчтой Монголын гарааны бизнесийг холбох явдал юм. Үүнийг "эд зүйлс"-ийн хэсэгт дурдсанчлан гадаадын хурдасгуур хөтөлбөрөөр сонгогдсон гарааны бизнесийн гадаад сүлжээг бэхжүүлнэ. Тиймээс, "эд зүйлс"-тэй адилаар төлөвлөсөн схем нь техникийн хамтын ажиллагааны төсөл бөгөөд түнш нь MDDIC MT парк байна.

Хүснэгт 44 Алхам 3. Монголын засгийн газар болон ЖАЙКА-гийн дэмжлэгийн арга хэмжээний чиглэл(гарааны бизнесийн экосистемийг байгуулах (5)Сүлжээ)

Зүйл	Үнэлгээний үр дүн		ЖАЙКА-гийн дэмжлэгийн чиглэл			
	Асуудлын цар хүрээ	Судалгааны чухал чиглэлүүд	Дэмжлэгийн цэс	Гол үйл ажиллагаа	Таамагласан схем	Түнш
Сүлжээ	Их	Судалгааны чухал чиглэлүүд	Гадаадын хурдасгуур, MONJA г.м.-ээр тухайн газрын хурдасгууртай сүлжээ тогтоох	Дээрх өргөн цар хүрээний хурдасгуурын хөтөлбөрийг зохион байгуулах үед, тухайн газрын хурдасгууртай хамтран ажиллаж, сүлжээг бүрдүүлэх	Техникийн хамтын ажиллагааны төсөл	• MDDIC - MT парк

3. Нээлттэй өгөгдлийн ашиглалт

(1) Нээлттэй өгөгдөл

(а) Асуудал(Нээлттэй өгөгдөл)

Монголын Засгийн газрын өмчилдөг өгөгдлийг нээлттэй өгөгдөл болгоход чиглэсэн арга хэмжээ өнөөдөр хүртэл урагшлахгүй байсан боловч Дэлхийн банкны дэмжлэгтэй Ухаалаг төр төслийн 1-р үе шатын (2015-2020) дагуу 2020 он гэхэд засгийн газрын нээлттэй мэдээллийн каталогийг хөгжүүлэх

зураглал хийгдсэнээр нээлттэй өгөгдлийг дэмжих ажиллагаа урагшилсан³⁷. Бас, 2022 оноос хойш MDDIC нь Монголын яам бүрийг нээлттэй мэдээллийн каталог боловсруулахыг уриалах ажлыг тэргүүлж, одоогоор яам, агентлагууд нээлттэй мэдээллийн портал хөгжүүлэхээр өрсөлдөж байгаа ба одоогийн байдлаар MDDIC, Үндэсний Статистикийн газар, Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв зэрэг төрийн олон яам, агентлагуудын нээлттэй мэдээллийн порталуудыг интернетэд ашиглах боломжтой болсон.

Ингээд, сүүлийн үед нээлттэй порталтай холбоотой арга хэмжээ эрчимтэй явагдаж ирсэн боловч, нөгөө талаар өгөгдлийн портал бүрт өгөгдлийн хэмжээ болон чанарын тал дээр асуудал байгаа. Ойролцоогоор 700 өгөгдлийн багц байгаа нь тогтоогдсон 1212.mn-ийг үл тооцвол, портал дээрх өгөгдлийн тоо бага байна. Эхлээд яам газрууд дотроо одоогийн байдлаар нээлттэй бус байгаа өгөгдлүүдийг нээлттэй болгож, ашиглах чухал юм. Гэвч, Эрүүл мэндийн хөгжлийн төв одоогоор хөгжүүлэх шатанд явж байгаа ба, зарим яам газруудад аль хэдийнэ энэ талаар арга хэмжээ авч, хийгдэж байгаа юм байна. Мөн, өгөгдлийн тооноос гадна, замын уулзварын шууд камерийн өгөгдөл, өвчтний СТ зургийн өгөгдөл, гео өгөгдөл зэрэг янз бүрийн өгөгдөл шаардлагатай байгаагаас гадна, AI-д ашиглах том өгөгдөл, Нислэгийн тоо өссөн талаарх өгөгдлүүдийн хэрэгцээ байгааг хувийн хэвшлийн компанууд хэлж байна.

Чанарын хувьд, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ажиллуулдаг 1313.mn-д нээлттэй өгөгдлийн нэг хэсэгт гэмтэл гарсны улмаас хандалт хийж болохгүй өгөгдөл үүссэн байна. Ингэснээр вэб хуудасны гэмтэл эвдрэл болон өгөгдлийн багц бүрийн шинэчлэлийн дамтамжийг сайжруулж, нээлттэй өгөгдлийн порталын чанарыг сайжруулах нь чухал байна. Засгийн газрын өгөгдлийг нээлттэй болгох зорилго нь, мэдээллийн ил тод байдлын үүднээс гэхээс гадна, засгийн газрын өгөгдлийг компанууд болон гуравдагч этдээдүүд оновчтой ашигласнаар нийгмийн тулгамдаж буй асуудлыг шийдэх болон бизнесийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах болно.

Нөгөөтэйгүүр, Монголд нээлттэй өгөгдлийг бизнест ашиглаж байгаа тохиолдол ажиглагдаагүй ба тус орны хувийн хэвшлийн компанийн хувьд ч нээлттэй өгөгдлийг ашиглах ач холбогдлыг ойлгоогүй байх талтай байна. Үнэн хэрэгтээ РР(5) хакатонд оролцогч компаниудын дунд явуулсан санал асуулгад компаниудын 60% нь хакатонд оролцохоос өмнө нээлттэй мэдээлэл байдгийг мэддэггүй байсан гэж хариулжээ. Монгол Улсад цаашид хувийн хэвшлийнхэн нээлттэй мэдээллийн хэрэглээг дэмжих нь ойлгомжтой байгаа ба, нээлттэй мэдээллийн хэрэглээг дэмжихийн тулд төр, хувийн хэвшлийн хооронд харилцаа холбоог сайжруулж гуравдагч талын мэдээллийн ашиглалтыг сайжруулах Shilen.gov зэрэг порталууд дээр өгөгдлийн дүрслэлийг ашиглан инфографикийг сайжруулах ажил мөн дэмжигдэж байна.

³⁷ [Cabinet Secretariat Government of Mongolia \(2016\), “OPEN DATA INITIATIVE OF MONGOLIA”](#)

Хүснэгт 45 Алхам 1. Асуудлыг нарийвчлан тодорхойлох (Нээлттэй өгөгдөл)

Зүйл	Зорилт болон өнөөгийн байдлын зөрүү			Асуудал	Асуудлын үнэлгээ			Үнэлгээний үр дүн: Асуудлын хүрээ (том/дунд/жижиг)
	Зорилт	Өнөөгийн байдал	Эх үүсвэр		Стратегийн чухал байдал (том /дунд /жижиг)	Асуудлын хүндрэлтэй байдал (том /дунд /жижиг)	Одоо хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байгаа эсэх (Байна/байхгүй)	
Нээлттэй өгөгдлийн чиглэлийг боловсруулах: Ажилтнуудын ур чадвар	-	Тодорхой бус	-	Техникийн ажилтнаас бусад ажилтнуудын ур чадвар бага, удирдлагууд болон техникийн ажилтнууд хоорондоо ойлголцоогүй байж болзошгүй	Их: Бодлого нь хамгийн дээд талд байна	Бага: Порталыг боловсруулж чадах түвшингийн хамгийн наад захын ур чадвар	Байна: Дэлхийн банк	Дунд
Түүхий өгөгдлийг цуглуулах: Өгөгдлийн багцын хэмжээ	-	Портал бүр өөр - 1212.mn : Ойролцоогоор 700 статистикийн өгөгдөл - 1313.mn : 100-аас доош - Shilen.gov : 100-аас доош	Зорилт: - Одоогийн байдал: Ухаалаг төр төсөл, портал тус бүрийн вэб сайт,	- Нээлттэй өгөгдлийн ихэнх нь статистикийн өгөгдөл бөгөөд төрөл бүрийн өгөгдөл одоогоор байхгүй. Жишээлбэл: Замын уулзвар бүрийн шууд дамжуулалттай камерын өгөгдөл, өвчтний шинж тэмдэгийн СТ зургийн өгөгдөл, гео өгөгдөл, GPS өгөгдөл зэргийн олон төрлийн өгөгдөл хэрэгтэй. Дээр нь, Хакатоноор ил тод болсон AI-д оруулах том өгөгдөл, бүтэшгүй өгөгдлийн хэрэгцээ их байна. - Захиргааны байгууллага болон орон нутгийн захиргаатай уялдсан өгөгдлийг олж авах болон гүнзгийрүүлсэн судалгаа хангалтгүй	Дунд: Хувийн хэвшлийн хувьд ашиглаж болдог, сонирхолтой өгөгдөл байхгүй бол ямар ч ашиггүй	Их: Тодорхой хэмжээний өгөгдөл байгаа ч, PP(5)(Хакатон болон PoC)-д ашиглаж болох өгөгдөл бага гэдгийг оролцогчид хэлж байв.	Байхгүй	Их
Нээлттэй өгөгдлийн порталыг бүрдүүлэх:	-	【Байна Байхгүй】 MDDIC , Үндэсний	Зорилт: - Одоогийн байдал: MDDIC	- Хэрэгтэй өгөгдлийг олоход төвөгтэй - Харагдац нь сонирхол бага татдаг	Дунд: Олон портал гэнэт бий болж өгөгдлийн	Дунд: Порталын чанар тогтвортой гэж хэлж чадахгүй	Байхгүй	Дунд

Өгөгдлийн каталог байгаа эсэх, бас чанар		статистикийн газар, Эрүүл мэндийн хөгжлийн төвд батлагдсан 【Чанар】 Портал бүр өөр өөр - 1212.mn : Өгөгдлийн хандалтад асуудал байхгүй • 1313.mn : Зарим нээлттэй өгөгдөл эвдэрсэн тул хандаж чадахгүй байдалтай байна - Өгөгдлийн хандалтад асуудал байхгүй, зарим өгөгдөл дүрслэлтэй	/Үндэсний статистикийн газраас асуулга, портал бүрд вэбсайт	- Хэлний хязгаарлалт - Өгөгдлийн формат хязгаарлагдмал - Өгөгдөл шинэчлэгдэх давтамж цөөн	хайлт хийхэд төвөгтэй болов			
Хувийн хэвшлийн нээлттэй өгөгдлийн хоёрдогч ашиглалт : Хувийн хэвшил хоорондын харилцаа	-	Тохиолдол байхгүй	Зорилт: - Одоогийн байдал: MDDIC асуулга, вэбээс нь судлах	- Компанууд нээлттэй өгөгдлийн талаар ойлголтгүй, олон нийтэд танигдаагүй - Ашиглах боломжийн талаарх судалгаа урагшлахгүй байна	Их: Өгөгдлийн хэмжээ, чанарын аль алиных нь талаар хувийн хэвшлийнхний саналыг сонсох нь чухал	Их: Тохиолдол олдсонгүй ч 4 зүйлийн дотроос хамгийн их хоцрогдож явна	Байна: Хакатонг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн(эцэст нь хэрэгжүүлээгүй)	Их

(б) Монголын Засгийн газар болон ЖАЙКА-гийн дэмжлэгийг тусгах судалгааны чухал чиглэлүүд(Нээлттэй өгөгдөл)

Дээрх одоогийн нөхцөл болон асуудалтай зүйлээс гадна, тус судалгаанд хувийн хэвшлийн компани зэрэг гуравдагч этгээдүүдийн нээлттэй өгөгдлийн ашиглалтыг нэмэгдүүлэхийг чухалчилж, хувийн хэвшлийн компаниудад ашиглагдах яам газруудын нээлттэй өгөгдлийн портал дээрх өгөгдлийн багцын хэмжээг өсгөх болон хувийн хэвшлийн компаниудтай тогтоох харилцааг сайжруулах нь тэргүүлэх чиглэлүүд гэж үзэж байна.

Өгөгдлийн багцийн хэмжээ их байвал тэрийг дагаад ашиглагчын хувьд ч сонголт нэмэгдэх тул, ашиглахад дөхөмтэй болно. Төдий хэмжээний өгөгдөл байвал ашиглахад дөхөмтэй болно гэсэн нарийн тогтсон тоо байхгүй ч, тухайлбал Японы Дотоод хэрэг, харилцаа холбооны яамны e-stat-н тохиолдолд 700 орчим судалгаанд ойролцоогоор 1.5 сая өгөгдлийн багцыг ашигласан байдаг. Улмаар, e-stat-ээс гадна Токио хотын ажиллуулдаг Токио хотын өгөгдлийн каталог сайтад, Токио хотын 61 байгууллагын ойролцоогоор 3,500 өгөгдлийн багц нээлттэй байдаг³⁸. Порталын хувьд сонголтыг нэмэснээр, нээлттэй өгөгдлийг ашиглах давтамж нэмэгдэх магадлалтай. Өгөгдлийн багцын хэмжээнээс гадна, бодит цагийн өгөгдөл, бүтэцгүй өгөгдөл зэрэг өгөгдлийн олон хувилбартай байх нь ч чухал юм.

Мөн, хувийн хэвслүүдэд нээлттэй өгөгдлийг хоёрдогч ашиглалтаар ашиглах тухайд, компанийн нээлттэй өгөгдлийн талаарх ойлголт байхгүй, олны дунд сайн тархаагүй байгаа нь асуудал болж байна. Гэвч, РР(5) дээр нээлттэй өгөгдлийг ашигласан Хакатонд тэмцээний ялагчын нээлттэй өгөгдлийн талаарх ойлголт, мэдлэг хангалттай байвч нээлттэй өгөгдлийг ашигласан үйлчилгээний хөгжүүлэлтийг хийж чадсангүй. Шалтгаан нь гэвэл, зөвхөн нээлттэй өгөгдлийн хэмжээ болон өгөгдлийн агуулгыг мэдсэнээр нэмүү өртөг өндөртэй үйлчилгээг үзүүлж чадахгүй явдал юм. Чухал байдлыг харьцуулаа гэвэл, дээр дурдсан өгөгдлийн багцын хэмжээ хамгийн тэргүүний ээлжийн асуудал гэж хэлнэ.

Эдгээр асуудлыг шийдвэрлэж, порталыг ашиглахад дөхөмтэй болгож сайжруулснаар, нээлттэй өгөгдлийг ашиглах гуравдагч этгээдүүдийн өгөгдөл олж авах, уялдуулах ажиллагааг хялбашуулж өгснөөр шинэ шийдэлд хүргэх боломж үүснэ гэж таамаглаж байна.

Хүснэгт 46 Алхам 2. Монголын Засгийн газар болон ЖАЙКА-гийн дэмжлэгийг тусгах судалгааны чухал чиглэлүүдийг нарийвчлан тодорхойлох(Нээлттэй өгөгдөл)

Зүйл	Асуудал	Асуудлыг шийдвэрлэхэд ЖАЙКА-гийн тусламж шаардлагатай эсэх/боломжтой эсэхийг судлах		Үнэлгээний үр дүн: Судалганы чухал чиглэлүүд
		Хөгжлийн түнш байгаа эсэх	Японы дэмжлэгийн эх үүсвэр байгаа эсэх	
Нээлттэй өгөгдлийн чиглэлийг боловсруулах: Ажилтнуудын ур чадвар	Техникийн ажилтнуудаас бусад ажилтнуудын ур чадвар доогуур, удирдлагууд, техникийн ажилтнуудын хоорондын ойлголцол сул байж магадгүй - Нээлттэй өгөгдлийн ихэнх нь статистикийн өгөгдөл ба, олон төрлийн өгөгдөл байхгүй - Захиргааны байгууллага болон орон нутгийн захиргаатай холбоотой өгөгдөл хайж олох, гүнзгийрүүлэн судлах нь хангалтгүй	Байна: Дэлхийн банк	Байхгүй	-
Түүхий өгөгдлийг цуглуулах: Өгөгдлийн	- Нээлттэй өгөгдлийн ихэнх нь статистикийн өгөгдөл бөгөөд олон төрлийн өгөгдөл байхгүй - Захиргааны байгууллага болон орон	Байхгүй	Байхгүй	Чухал асуудал

³⁸ Дотоод хэрэг, харилцаа холбооны яамны e-stat болон Токио хотын TOKYO OPEN DATA вэб хуудас

багцын хэмжээ	нутгийн захиргаатай холбоотой өгөгдлийг хайж олох, гүнзгийрүүлэн судлах нь хангалтгүй			
Нээлттэй өгөгдлийн порталыг бүрдүүлэх: Өгөгдлийн каталог байгаа эсэх болон чанар	- Хэрэгтэй өгөгдлийг олоход төвөгтэй - Харагдац нь сонирхол бага татаж байна - Хэлний хязгаарлалт - Өгөгдлийн формат хязгаарлагдмал - Өгөгдлийг шинэчлэх давтамж цөөн - Техникийн ажилтнуудаас бусад ажилтнуудын ур чадвар доогуур, удирдлагууд, техникийн ажилтнуудын хоорондын ойлголцол муу байж магадгүй	Байхгүй	Байхгүй	-
Хувийн хэвшлүүдийн нээлттэй өгөгдлийн хоёрдогч ашиглалт Хувийн хэвшилтай тогтоосон харилцаа	- Нээлттэй өгөгдөл байгааг, мөн ашигтайг нь хувийн хэвшлийн компаниуд сайн мэдэхгүй байгаа - Хэрэгтэй өгөгдлийг олоход төвөгтэй - Харагдац нь сонирхол татахааргүй - Хэлний хязгаарлалт - Өгөгдлийн формат хязгаарлагдмал - Өгөгдлийг шинэчлэх давтамж цөөн	Байхгүй	Байхгүй	Чухал асуудал

(в) Монголын Засгийн газар болон ЖАЙКА-гийн дэмжлэгийн арга хэмжээний чиглэл(Нээлттэй өгөгдөл)

ЖАЙКА-гаас хэрэгжүүлж буй дэмжлэгийн арга хэмжээний хүрээнд яам, агентлаг бүрт нээлттэй мэдээллийн портал бий болгоход тэргүүлэгч үүрэг гүйцэтгэж байгаа MDDIC рүү саналаа хүргүүлнэ. Тодруулбал: бодлого хариуцсан мэргэжилтнүүдийн нээлттэй өгөгдлийн талаарх ур чадварыг дээшлүүлэх, нээлттэй өгөгдлийн порталын өгөгдлийн хэмжээ, чанарыг сайжруулах, хувийн хэвшлийн компани зэрэгт сурталчлах ба ашиглалтыг нэмэгдүүлэх гэсэн чиглэлүүдээр санал дэвшүүлнэ. Ажилтнуудын ур чадварын хувьд, хэдийнэ нээлттэй өгөгдлийн порталаа хөгжүүлж байгаа тул, техник хариуцсан ажилтнуудын ур чадварт онцын асуудал байхгүй гэж бодож байна. Нөгөөтэйгүүр, бодлого боловсруулах ажилтан зэрэг удирдах шатны ажилтнуудад нээлттэй өгөгдөл гэж юу болох, Монголын хувьд нээлттэй өгөгдөлтэй болох зорилго болон ашиглах хэрэгцээг сайтар ойлгуулах хэрэгтэй. Ийнхүү бодлого хариуцсан ажилтнуудын нээлттэй өгөгдлийн ур чадварыг дээшлүүлснээр, техникийн ажилтнуудад зөв заавар өгөх, зөв харилцаа үүсэх ба улсын бодлого чиглэлийг тусгасан порталын ашиглалт бий болно.

Өгөгдлийн багцын тоо, чанарыг сайжруулахын хувьд, цуглуулах өгөгдлийн төрөл, тоог нэмэгдүүлэхийн тулд, өгөгдлийг цуглуулах шатанд өгөгдлийн цуглуулах арга болон өгөгдлийн урьдчлан боловсруулалттай холбоотой дэмжлэгийг үзүүлж, улам олон өгөгдлийн багцыг нээлттэй болгож, үүний жишээнд бодит цагийн өгөгдлийг авах аргыг чадавхжуулах зэргийг дурдаж болно.

Мөн нээлттэй болгоход тохиромжтой формат(өргөтгөл)-г зөвхөн эксел биш, csv болон json үзрэг өргөн сонголттой болгосноор, өгөгдөлүүдийг уялдуулахад хялбар болгох, нээлттэй өгөгдлийг вэб дээр Business Intelligence хэрэгсэл мэт дүрслэл болгосноор, хувийн хэвшлийн компани гэх мэт гуравдагч этгээдүүд өгөгдлөөс санаа авахад дөхөмтэй болгохыг зорино.

Эцэст нь, хувийн хэвшил болон Засгийн газар хоорондоо нээлттэй өгөгдлийн хэрэглэх, ашиглах тухай семинар зохион байгуулснаар, Засгийн газрын хувьд хувийн хэвшлийн компаниудын нээлттэй өгөгдлийн хэрэгцээг ойлгож, хувийн хэвшлийн компанийн хувьд нээлттэй өгөгдлийн мэдлэг болон түүний ашиг тусыг ойлгож авах талбар бий болно. Семинарт, тус төсөлд РР(5)өөр хэрэгжүүлсэн нээлттэй өгөгдлийн хакатон болон РоСийн хэрэгжилтийн үр дүнг нэвтрүүлж, хувийн хэвшлүүдийн хувьд Засгийн газрын нээлттэй өгөгдлийг хэрэглэх, ашиглах үед мэдрэгдсэн асуудалтай тал болон хувийн хэвшлийн компаниудын зүгээс нээлттэй өгөгдлийг бизнест ашиглахад Засгийн газраас тавигдах шаардлагыг тодорхой болгосны үндсэн дээр семинарыг зохион байгуулна. Иймэрхүү Засгийн газар, хувийн хэвшлийн компаниуд хоорондын арга хэмжээ нь Монгол дахь нээлттэй өгөгдлийн бизнес дэх ашиглалтыг сайжруулахад чухал хэрэгтэй байна.

Дээрхэд үндэслэн, техникийн хамтын ажиллагааны төслийн хэрэгжүүлэх чиглэл гэвэл, гуравдагч этгээдүүд бодитоор нээлттэй өгөгдлийг ашиглахаас (ялангуяа, нээлттэй өгөгдлийг бизнестээ ашиглах хувийн хэвшлийн компаниуд) өмнө Засгийн газар, хувийн хэвшлийн аль алинд нь цогц дэмжлэг үзүүлэх шаардлагатай харагдаж байна.

Хүснэгт 47 Алхам 3. Монголын Засгийн газар болон ЖАЙКА-гийн дэмжлэгийн арга хэмжээний чиглэл (Нээлттэй өгөгдөл)

Зүйл	Үнэлгээний үр дүн		ЖАЙКА-гийн дэмжлэгийн чиглэл			
	Асуудлын цар хүрээ	Судалгааны чухал чиглэлүүд	Дэмжлэг цэс	Гол үйл ажиллагаа	Таамагласан схем	Түнш
Нээлттэй өгөгдлийн чиглэлийг боловсруулах: Ажилтнуудын ур чадвар	Дунд	-	Нээлттэй өгөгдлийг ашиглахад чиглэсэн чадваржуулах хөтөлбөр	• Нээлттэй өгөгдөл болон түүнийг ашиглах аргын талаар мэдлэг олж авах сургалтыг зохион байгуулах	Техникийн хамтын ажиллагааны төсөл	MDDIC Орон нутгийн захиргаа
Түүхий өгөгдлийг цуглуулах: Өгөгдлийн багцын хэмжээ	Их	Чухал асуудал		• Өгөгдөл цуглуулах ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх (Жишээлбэл: бодит цагийн өгөгдлийг олж авах аргыг чадавхижүүлэх зэрэг) • Хувийн хэвшилд хэрэгтэй өгөгдлийн багцыг бүрдүүлэх	Техникийн хамтын ажиллагааны төсөл	MDDIC Бусад порталын удирдлагын яам газрууд
Нээлттэй өгөгдлийн порталыг бүрдүүлэх: Өгөгдлийн каталог байгаа эсэх ба чанар	Дунд	-		• Өгөгдлийн багцын форматыг боловсруулах, чанаржуулах • Урьдчилж боловсруулсан ашиглахад дөхөмтэй өгөгдлийг бүрдүүлэх • OD порталын график зэрэг UI-г сайжруулах	Техникийн хамтын ажиллагааны төсөл	MDDIC Бусад порталын удирдлагын яам газрууд
Хувийн хэвшлүүд дэх нээлттэй өгөгдлийн хоёрдогч ашиглалт: Хувийн хэвшлийнхэнтэй тогтоосон хоорондын харилцаа	Их	Чухал асуудал		• Хувийн хэвшилд зориулж ажлын семинар зохион байгуулах(Засгийн газар нь хувийн хэвшлийнхний эрэлт хэрэгцээг мэдэхийг хичээж, хувийн хэвшил нь төрөөс цацаж байгаа мэдээллийн талаарх ойлголтоо	Техникийн хамтын ажиллагааны төсөл	MDDIC

				гүнзгийрүүлэхийг хичээнэ) • Хакатон шиг РР(5)ын арга хэмжээг хөгжүүлэх(Жишээлбэл: Асуудлыг өөрчилж Хакатоныг дахин зохион байгуулах зэрэг)		
--	--	--	--	---	--	--

(2) Өгөгдлийг уялдуулах

(a) Асуудал(өгөгдлийг уялдуулах)

Монголын одоо байгаа өгөгдлийн холболтын платформтай холбоотой арга хэмжээний хувьд, холбогдох яам газруудаас асуухад³⁹, тодорхой арга хэмжээ авч бодитоор ажиллуулаж байгаа нь тогтоогдсон. Эхлээд Монгол улсын Засгийн газрын байгууллагуудад хэдийнэ яам газрууд хоорондын нэгдсэн мэдээлэл солилцооны давхарга болох ХУР нь Enterprise Service Bus(цаашид ESB гэх)системеер ажиллаж байгаа ба, ХУР-г давхарга болгож Монголын Засгийн газрын нэгдсэн мэдээллийн сан болох Үндэсний мэдээллийн төв болон хэрэглэгчийн интерфэйс болох e-Mongolia дээр яам газрууд хоорондын өгөгдлийн харилцан холболтууд хийгдэж байна.

Хувийн хэвшилтэй хийгдэх өгөгдлийн холболтын нөхцөл байдлын талаар , Монголын иргэд төрийн үйлчилгээг онлайнаар авч чадах болсон програм болох e-Mongolia нь API функцтэй ба, хувийн хэвшлийн компани гэх гадны програм хөгжүүлэгч нар тодорхой шалгуур даваж байж e-Mongolia-тай холбогдох боломжтой. E-Mongolia-тай API-г ашигласан бодитой шийдлийн тохиолдлыг асуулгын үеэр тодорхой болгож чадаагүй ч төр, хувийн хэвшлийн өгөгдөл холболтын дэд бүтэц ажиллаж байна гэж хэлж болно. Монгол улсын дотоод дахь өгөгдлийн холболт нь хувийн мэдээлэлтэй хэрхэн харьцаж байгаа тухайд, e-Mongolia дээр бол нэвтрэх аргаар харьцаж байгаа ба, засгийн газрын байгууллага дээр хувь хүний мэдээллийг хуваалцаж болох эсэхийг хэрэглэгчидээс мэйлээр тухай бүрт асууж шалгаж байна. Бусад програмууд хувь хүний мэдээлэлтэй хэрхэн харьцаж байгаа талаар одоохондоо тодорхой биш байна.

Дээрхээс үзэхэд, Монголд, яам газруудыг дамнасан өгөгдлийн холболтын платформыг бий болгосон бөгөөд, мөн Засгийн газрын дэд бүтцийг бий болгосон нь онцын асуудал байхгүй гэж үзэж болох боловч, төр, хувийн хэвшил хоорондын өгөгдлийн холболтыг ашигласан бизнесийг бий болгох, хувийн хэвшлийн зүгээс тодорхой үйлдвэрлэлийн салбар дотроо хувийн хэвшлийн компаниуд хоорондын, үйлдвэрлэлүүд хоорондын өгөгдлийн холболтын дэд бүтэц бий болгох арга хэмжээ авч ажиллах боломжтой.

³⁹ National Data Center, e-Mongolia-аас санссан (2024/4/23)

Хүснэгт 48 Алхам 1. Асуудлыг нарийвчлан тодорхойлох (Өгөгдөлийн холболт)

Зүйл	Зорилт болон өнөөгийн байдлын зөрүү			Асуудал	Асуудлын үнэлгээ			Үнэлгээний үр дүн: Асуудлын хүрээ (том/дунд/жигжиг)
	Зорилт	Өнөөгийн байдал	Эх үүсвэр		Стратегийн чухал байдал (том /дунд /жигжиг)	Асуудлын хүндрэлтэй байдал (том /дунд /жигжиг)	Одоо хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байгаа эсэх (Байна/Байхгүй)	
Яам газар, орон нутгийн захиргаа бүрийн үндсэн системийн судалгаа	-	-	-	Орон нутаг, төвийн өгөгдлийн дэд бүтэц өөр тул өгөгдлийн ашиглалтын ачаалал нэмэгдэж байна	Бага:	Дунд(өгөгдлийн ашиглалтын ачаалал нэмэгдэж байгаа нь асуудал)	Тодорхой бус	Бага(Дарааллаар нь ХУР, e-Mongolia-ээр нэгтгэж явна)
Яам газруудыг дамнасан(орон нутгийн захиргааг оролцуулан)өгөгдлийн холболтын бүтцийг бий болгоно	Үндэсний мэдээллийн төвдөө тодорхой хэмжээний өгөгдлийг нэгтгэсний дараа одоо дараагийн шатанд, серверийн ачаалал болон кибер аюулгүй байдлын эрсдлийг багасгахыг зорилт болгож байна.	Төрийн мэдээлэл солилцох платформ ХҮР-ийг суурь болгон ашигласнаар нэгдсэн мэдээллийн сан (NDC) нь цахим Монгол зэрэг янз бүрийн интерфейстэй холбогдсон.	e-Mongolia-д асуулга хийв	Том асуудал байхгүй ч, ХУР-ын өгөгдлийг шинэчлэх(серверийн ачаалал болон аюулгүй байдлын эрсдлийг багасгах шинэ арга)тухай NDC болон e-Mongolia-д хэлэлцэгдэж байна.	Их(Монголын өгөгдлийн холболтын дэд бүтэц нь Монголын МХХТ-ийн үйлдвэрлэлийн давуу тал бөгөөд шинэчлэх, бэхжүүлэх хэрэгцээ тогтвортой өндөр байна	Бага(Хэдийнэ өгөгдлийн холболтын дэд бүтэц байгуулагдсан байгаа)	Байна(ХУР болон e-Mongolia)	Дунд(Өгөгдлийн холболтын дэд бүтцийг шинэчлэх болон шинэ арга хэлбэрийг хайх)

Хувийн хэвшлийн тодорхой үйлдвэрлэл дэх өгөгдлийн холболтын дэд бүтэц(Уул уурхай, санхүү г.м.)	-	e-Mongolia-тай API хэлбэрээр компаниудтай өгөгдлийн холболтыг гүйцэтгэж байсан. Дээрхээс бусад нь тодорхой бус	e-Mongolia-аас асуулга авсан	Цаашид компаниудын холболтыг хөгжүүлэх тал дээр сайжруулах боломжтой	Дунд(Монголын гол үйлдвэрлэлүүдийг бэхжүүлэх, үр ашгийг сайжруулахад чухал)	Их(Компаниудыг холболтын хувьд сайжруулах боломжтой)	Байна(e-Mongolia-тай хамтран ажиллаж байна)	Их(Үйлдвэрлэлүүдийг хөгжүүлэхэд өгөгдлийг хуваалцах)
Хувь хүний мэдээлэлтэй хэрхэн харьцах	Өгөгдлийн холболтын найдвартай дэд бүтцийг бий болгохыг хүсч байна	e-Mongolia нь Олт ин дээр ажилладаг	e-Mongolia-аас авсан асуулга	Онцны зүйл байхгүй	Бага(Илт тод байдлыг хадгалах тогтвортой арга хэмжээ хэрэгтэй боловч, дөхөмтэй бол хувь хүний мэдээллийг хамгаалах нь тийм ч чанга байх шаардлагагүй гэх санал ч байна)	Бага(олт-ин дээр ажилладаг)	Байна(олт-ин дээр ажилладаг)	Бага(Үйлчилгээг сайжруулах нь хувь хүний мэдээллээс илүүд тавигдах хандлагатай ба , асуудал гэж ухамсарласан нь их биш)

(б) Монголын Засгийн газар болон ЖАЙКА-ийн дэмжлэгийг тусгах судалгааны чухал чиглэлүүд(Өгөгдлийн холболт)

Дээрх асуудлын ойлголтыг үндэслэн, дэмжлэгийг тусгах судалгааны чухал чиглэл нь хувийн хэвшлийн тодорхой үйлдвэрлэлийн өгөгдлийн холболтын дэд бүтцийг бий болгох явдал болно. Монголын компаниуд хоорондын өгөгдлийн холболтын одоогийн нөхцөл байдлын талаар одоогоор судалгаа байхгүй тул тодорхой биш байгаа ч, Монголын эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хийсэн уулзалт⁴⁰ дээр эрүүл мэндийн байгууллагууд хооронд өвчтнүүдийн эмчилгээний өгөгдлийг харилцан хуваалцах хэрэгцээ их байгаа нь тодорхой байсан тул, зарим үйлдвэрлэлд өгөгдлийн холболт болон харилцан ашиглах хэрэгцээ бол тодорхой хэмжээгээр байгаа нь илэрхий байна. Мөн, сүүлийн үед Японд ч гэсэн стратегийн өмчийн өгөгдөл нь чухал болж байгаа тул, шинэ бизнес бүтээх, маркетингийг оновчтой болгох үүднээс "өгөгдөл хуваалцах" гэсэн компаниуд хооронд өгөгдөл хуваалцах арга хэмжээ явагдаж байна. Монголд ч гэсэн, тодорхой үйлдвэрлэл дээр өгөгдлийн норм стандартыг бүрдүүлэх, өгөгдлийн арилжааны зах зээлийг хөгжүүлэх зэрэг өгөгдөл хуваалцах ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохиохдоо, Японы аж үйлдвэрийн салбарын арга хэмжээнээс олон санаа авч болно.

Хүснэгт 49 Алхам 3. Монголын Засгийн газар болон ЖАЙКА-гийн дэмжлэгийг тусгах судалгааны чухал чиглэлүүдийг нарийвчлан тодорхойлох(Өгөгдлийн холболт)

Зүйл	Асуудал	Асуудлыг шийдвэрлэхэд ЖАЙКА-ийн тусламж шаардлагатай эсэх/боломжтой эсэхийг судлах		Үнэлгээний үр дүн: Судалааны чухал салбар
		Хөгжлийн түнш байгаа эсэх	Японы дэмжлэгийн нөөц байгаа эсэх	
Яам газар, орон нутгийн захиргаа бүрийн үндсэн системийн судалгаа	Орон нутаг, төвийн өгөгдлийн дэд бүтэц өөр тул өгөгдлийн ашиглалтын ачаалал нэмэгдэж байна	Тодорхой бус	Байхгүй	-
Яам газруудыг дамнасан(орон нутгийн захиргааг оролцуулан)өгөгдлийн холболтын дэд бүтцийг бий болгоно	-	Байна(ADB нь статистикийн өгөгдлийн засаглалыг бэхжүүлэх, яам газруудын мэдээллийг нэгтгэх, мэдээллийн санг хөгжүүлэх, удирдлагатай холбоотой технологийн дэмжлэг г.м.-ийг үзүүлж байна)	Байхгүй	-
Хувийн хэвшлийн тодорхой үйлдвэрлэл дэх өгөгдлийн холболтын дэд бүтэц(Уул уурхай, санхүү зэрэг)	Цаашдын компаниудын холболтыг хөгжүүлэх тал дээр сайжруулах боломжтой	Байхгүй	Байна	Чухал асуудал
Хувь хүний мэдээллтэй харьцах тухай	Тодорхой бус	Байхгүй	Тодорхой бус	-

⁴⁰ Доржмягмар Эрүүл мэндийн мэдээллийн газрын дарга (2024/3/7 уулзав)

(в) Монголын засгийн газар болон ЖАЙКА-гийн дэмжлэгийн арга хэмжээний чиглэл(Өгөгдлийн холболт)

Бодитой дэмжих арга хэмжээний хувьд, дээр дурдсанчлан Монголд яам газрууд хоорондын өгөгдлийн холболтын дэд бүтэц хэдийнэ үүссэн байгаа тул, хувийн хэвшлийн тодорхой үйлдвэрлэл дэх өгөгдлийн холболтыг хөгжүүлэхийг тэргүүлэх дэмжлэгийн санал болгож дэвшүүлнэ. Монголын үйлдвэрлэл тус бүрийн одоогийн нөхцөл байдлыг судалгаа явуулж тодорхойлон, тухайн үйлдвэрлэлийн шийдвэрлэх асуудал болон өгөгдлийн ашиглалтаар дамжуулж асуудлуудыг шийдвэрлэх боломжийг судлана. Улмаар, тус үйлдвэрлэлтэй холбоотой Японыг оролцуулсан гадаад орнуудтай өгөгдөл хуваалцах замаар үйлдвэрлэлээ хөгжүүлсэн жишээ тохиолдолыг цуглуулан, Монголд ашиглах боломжийг судлана. Тэгсний дараа, Монголын тодорхой үйлдвэрлэлийн өгөгдлийн холболтын байвал зохих дүр төрхийн талаар, хувийн хэвшлийн компаниуд, болон Монголын Засгийн газартай консорциум байгуулж, хэлэлцүүлэг хийнэ. Дараа нь, хамаарал бүхий компаниуд болон платформын хөгжүүлэлт хийх борлуулалтын компаныг сонгон авч, консорциумаар хэлэлцэж эцэслэн шийдвэрлэсэн өгөгдлийн холболтын хандлагыг(том хэмжээний өгөгдлийн холболтын зангилаа платформ болон өгөгдлийн борлуулалттай холбоотой арилжааны зах зээл гэх мэт)хэрэгжүүлэхэд шаардагдах урьдчилсан бэлтгэлийг хангана. Дээрх үйл явцыг үндэслэн, хуваалцах өгөгдлийн багцыг тогтоож, туршилт хийгдсэн бодит ашиглалт эхлэх хүртэлхийг тус техникийн төслийн дэмжлэгийн цар хүрээ гэж тогтоосон.

Хүснэгт 50 Алхам 3. Монголын засгийн газар болон ЖАЙКА-гийн дэмжлэгийн арга хэмжээний чиглэл(Өгөгдлийн холболт)

Зүйл	Үнэлгээний үр дүн		ЖАЙКА-гийн дэмжлэгийн чиглэл			
	Асуудлын цар хүрээ	Судалгааны чухал чиглэлүүд	Дэмжлэгийн цэс	Гол үйл ажиллагаа	Таамагласан схем	Түнш
Яам газар, орон нутгийн захиргаа бүрийн үндсэн системийн судалгаа	Тодорхой бус	-	Өгөгдлийн холболтын дэд бүтцийг бүрдүүлэхэд чиглэсэн чадваржуулах хөтөлбөр	• Яам газрууд, орон нутгийн захиргаа бүрийн үндсэн системийн бодит байдлыг үндэслэн, өгөгдлийн холболтын дэд бүтцийн зураг төсөл зохиох	Техникийн хамтын ажиллагааны төсөл	MDDI C
Яам газруудыг дамнасан(орон нутгийн захиргааг оролцуулан)өгөгдлийн холболтын дэд бүтцийг бий болгоно	-	-		• Яам газар • орон нутгийн захиргааны эзэмшиж байгаа өгөгдлийг өгөгдлийн холболтын дэд бүтэцэд оруулах • Яам газар, орон нутгийн захиргаа нь өгөгдлийн холболтын дэд бүтцэд оруулсан бусад байгуулгуудын өгөгдлийг ашиглах тогтолцоог бий болгох	Техникийн хамтын ажиллагааны төсөл	ХҮР удирдах яам газрууд
Хувийн хэвшлийн тодорхой үйлдвэрлэлийн өгөгдлийн холболт(Уул уурхай,	Бага:	Чухал асуудал		• Өгөгдлийн холболтыг хөгжүүлэх тодорхой үйлдвэрлэлийг сонгох • Өгөгдлийн холболтыг гүйцэтгэх хувийн хэвшлийн компаниудыг цуглуулах, сонгох	Техникийн хамтын ажиллагааны төсөл	MDDI C

санхүү зэрэг)				• Өгөгдлийн холболтод хамруулах өгөгдлийн зүйлсийг тогтоох • Дата холболтын дэд бүтэц г.м.-ийн өгөгдлийн хамтын эзэмшлийн платформыг байгуулах		
Хувь хүний мэдээлэлтэй харьцах талаар	Бага:	-		• Хувь хүний мэдээлэлтэй харьцах тухай хуулийг батлах • Тус хуулийн дагуу, хувь хүний мэдээлэлтэй харьцах тухай дүрэм журмыг тогтооно(Ялангуяа нэрээ нууцлах зэрэг хуулийн шаардлагуудыг бодитойгоор гаргаж хуулинд заана)	Техникийн хамтын ажиллагааны төсөл	ХУР удирдах яам газрууд

5-р бүлэг Тэргүүлэх чиглэлүүдийн нарийвчилсан судалгаа, дүн шинжилгээ

1. МХХТ, цахим үйлдвэрлэлийг дэмжих (МХХТ, цахим үйлдвэрлэлийг гадаадад тэлэх)

Тус судалгаа нь туршилтын төсөл дэх Япон Монголын бизнесийн тохиролоос гадна Монголын МХХТ, цахим үйлдвэрлэл болон гарааны бизнесийн гадаадын зах зээл дэх тэлэлттэй холбоотой алсын бодлогыг хэлэлцсэн. Үүнээс гадна, Монголын эдийн засгийн хөгжлийн яам нь Уул уурхайн бус салбарыг тэргүүн эгнээнд хөгжүүлэх Үндэсний экспортын стратеги болох Уул уурхайн бус салбарыг түрүүлж хөгжүүлэхийг 2023 оны 4 сараас томъёолж эхлэн мэдээллийн технологийн үйлчилгээ нь тэдгээр салбарын нэг болох ба MDDIC - Цахим хөгжил, инноваци, Харилцаа холбооны яам-тай хамтран төлөвлөгөө боловсруулсан. Үүний тулд, тус судалгаагаар хэлэлцсэн гадаадад зах зээлээ тэлэх стратеги нь хойшид Жайкагийн тусламжын бодлогод хэлэлцэгдэнэ гэдгийг бодолцон Эдийн засгийн хөгжлийн яам болон MDDIC хөгжил, инноваци, харилцаа холбооны яам-ны томъёолсон National Export Strategy-ийг тус судалгаанд иш татсан.

(1) Улсын түвшинд гадаадын зах зээлд тэлэлт хийх шалтгаан

Монголын МХХТ, цахим үйлдвэрлэл болон гарааны бизнесүүдийн гадаадад зах зээлээ тэлэх томхон зорилго нь дараах 2 байдаг.


Хүснэгт 51 Гадаадад тэлэх зорилго

Objective of overseas expansion	1 To get foreign currency (= to promote new export industry)	2 To get necessary resources (including fund and technology) from other countries
Challenges in Mongolia	- Exports depends on mining and agriculture - Landlocked	- Limited domestic resources in funding (not many VCs and accelerators) - Especially limitation in hardware industry
Opportunities in Mongolia	- Human resource: Young, STEM, Mathematical Olympiad, language fluence - Test field for new technology (such as radio wave license)	

Эх сурвалж: Судалгааны баг боловсруулав


1 дүгээрт байгаа "Гадаад валют олж авах" тал дээр доорх зургийн дагуу Монголын ҮНБ нь өдийг хүртэл уул уурхай болон хөдөө аж ахуйн эзлэх хувь өндөр ба мэдээлэл харилцаа холбооны салбар 2022 онд 2%-иас хэтрэхгүй байна. Нөгөө талаас, уул уурхай нь Олон улсын зах зээл, түүхий эдийн зах зээлийн нөлөөнд хүчтэй өртөх салбар тул дараагын тулгуур болох үйлдвэрлэл шаардлагатай байна.

GDP by division (MNT million, current price)



■ Taxes less subsidies on products
 ■ Other service activities
 ■ Arts, entertainment and recreation
 ■ Human health and social work activities
 ■ Education services
 ■ Public administration and defence; compulsory social insurance
 ■ Administrative and support service activities
 ■ Professional, scientific and technical activities
 ■ Real estate activities
 ■ Financial and insurance activities
 ■ Information and communication
 ■ Accommodation and food service activities
 ■ Transportation and storage
 ■ Wholesale and retail trade; repair of motor vehicles and motorcycles
 ■ Construction
 ■ Water supply; sewerage, waste management and remediation activities
 ■ Electricity, gas, steam, air conditioning supply
 ■ Manufacturing
 ■ Mining and quarrying
 ■ Agriculture, forestry, fishing and hunting

GDP by division (2022, current price)




■ Agriculture, forestry, fishing and hunting
 ■ Mining and quarrying
 ■ Manufacturing
 ■ Electricity, gas, steam, air conditioning supply
 ■ Water supply; sewerage, waste management and remediation activities
 ■ Construction
 ■ Wholesale and retail trade; repair of motor vehicles and motorcycles
 ■ Transportation and storage
 ■ Accommodation and food service activities
 ■ Information and communication
 ■ Financial and insurance activities
 ■ Real estate activities
 ■ Professional, scientific and technical activities
 ■ Administrative and support service activities
 ■ Public administration and defence; compulsory social insurance
 ■ Education services
 ■ Human health and social work activities
 ■ Arts, entertainment and recreation
 ■ Other service activities
 ■ Taxes less subsidies on products

Эх сурвалж: Монголын үндэсний статистикийн ерөнхий хорооны өгөгдөлд үндэслэн боловсруулав


Зураг 34 Монголын салбар тус бүрийн ҮНБ-ний өөрчлөлт ба 2022 оны бүтцийн харьцаа

Мөн, Монгол улсын төлбөрийн тэнцэл доор зураг дээрхийн адтл улайсан байгаа ба гадаад худалдааны тэнцэл ашигтай байгаа боловч МХХТ-ийн үйлчилгээ зэргийг багтаасан үйлчилгээний тэнцэл улаан хэвээрээ байна. Үйлчилгээний орлого зарлагын задаргааг харвал МХХТ-ийн үйлчилгээг оруулаад "бусад үйлчилгээ" нь, 1) МХХТ-ийн үйлчилгээний бусад улс орнуудад төлөх төлбөрийн хэмжээ, 2) тогтвортой байгаа боловч бага хэмжээний гадаадаас авдаг МХХТ-ийн үйлчилгээний орлого болох нь ойлгогдоно. Эдгээрээс гадаад валют олохын тулд МХХТ-ийн үйлдвэрлэлийг гадаадын зах зээл рүү тэлэх нь чухал МХХТ-ийн үйлчилгээг дотооддоо үүсгэж гадаадын үйлчилгээг орлуулах хэрэгцээ мөн байна.

Current account (USD million)




Service account (USD million)



Эх сурвалж: Монголын үндэсний статистскийн ерөнхий хорооны өгөгдөлд үндэслэн судалгааны баг боловсруулав.

Зураг 35 Монгол улсын төлбөрийн тэнцэл болон үйлчилгээний орлого зарлагын тэнцлийн өөрчлөлт

Үргэлжлүүлээд, "Шаардлагатай нөөцийг олж авах" тал дээр Монголын гарааны бизнесийн санхүүжилтийн байдлыг харахад доорх зургийн дагуу давтан хөрөнгө оруулалт (тухайн компанид өмнө нь хөрөнгө оруулалт хийсэн хүн үргэлжлүүлээд хөрөнгө оруулах явдлыг хэлнэ) гэхэд л 39% нь "Үүсгэн байгуулагчын хувийн хадгаламжаас" хамааралтай байгаа ба ялангуяа Ангел хөрөнгө оруулагч, венчур капитал, корпорацийн венчур капитал нарын санхүүжилт хязгаарлагдмал байна.




Эх сурвалж: Baseline survey of the Mongolian start-up ecosystem (JICA/KITE/MMCG)


Зураг 36 Монгол дахь санхүүжилтийн эх үүсвэр тус бүрийн анхдагч болон давтан хөрөнгө оруулалтын байдал

Үүнтэй холбоотой доорх зургын дагуу Монголын гарааны бизнесийн 61% нь хамгийн чухал тусламжаар хөрөнгө оруулалтыг нэрлэж байна. Мөн, улаанаар хүрээлсний дагуу Монголын гарааны бизнесийн экосистемийг бий болгоход шаардагдах зүйлд хүний нөөц болон эдийн засгийн орчноос гадна инновацийн түвшин орно.

Top 5 most needed support for start-ups



Top 5 factors to support startup ecosystem in Mongolia



Эх сурвалж: Baseline survey of the Mongolian start-up ecosystem (JICA/KITE/MMCG)

Зураг 37 Монголын гарааны бизнесүүдэд шаардлагатай тусламж болон экосистем үүсгэх бүтэц

Эдгээрээс харахад гадаадаас хэрэгтэй нөөц (санхүүжилт болон технологи) олж авах нь тус асуудлыг шийдэх нэг арга мөн.

(2) Гадаад руу зах зээл тэлэх арга хэлбэрүүд

Монголын МХХТ, цахим үйлдвэрлэл нь гадаадад зах зээлээ дараах 3 хэлбэрээр тэлдэг.


Хүснэгт 52 Гадаад руу зах зээл тэлэх арга хэлбэрүүд

Category	1 Service expansion	2 Technology collaboration	3 Fundraising
Overview	- To sell digital service/product to overseas market (including off-shore development) - If necessary, establish foreign branch	- To create new service/product through collaboration with foreign companies - Market of new service/product will be Mongolia or other countries	To raise fund from foreign investors and/or companies
Expected result	To get foreign currency	To create new product/service with foreign companies	To raise fund from foreign investors and/or companies
Target region/country	Asian countries including Central Asia and Southeast Asia	Japan, Singapore, USA and Europe	Japan, Singapore, USA and Europe

Эх сурвалж: Судалгааны баг боловсруулав

(3) Гадаад зах зээл тэлэлтийг дэмжих бодлого

Монголын МХХТ, цахим салбарыг хилийн чанадад өргөжүүлэхэд дараах хоёр бодлогыг баримталж байна.



Эх сурвалж: Судалгааны баг боловсруулав.

Зураг 38 Гадаад зах зээл тэлэлтийг дэмжих бодлого

Энэхүү 2 бодлогонд үндэслэсэн гэж ойлгогдох гадаадын зах зээлийн тэлэлтийг дэмжсэн дараахь жишээ байна.

Хүснэгт 53 Гадаадад өргөжин тэлэхийг дэмжих үйл ажиллагааны жишээ

	Activities	Overview
Policy 1: Growth of each company in overseas market	Business matching (including pitch event)	- Business matching tour or event (mainly with ecosystem partner or target country/ region) - Pitch event for foreign companies and investors - Top sales by * These activities are conducted in PP1, Japan Mission.
	Global Acceleration program	Acceleration program focusing on overseas expansion, alliance with foreign companies, or fundraising from foreign investors * This activity is partly conducted in PP3, MONJA.
	Innovation trial support	Provision and coordination of test field of new technology created in collaboration between Mongolian and foreign companies
	Consultation	- Establishment of consultation desk - Provision of consultation on overseas expansion to each company (including legal & tax matter)
	Participate in international ICT event	Participation in international ICT event (like CES and MWC) as Team Mongolia
Policy 2: Expansion of base which can expand business to overseas	Capacity building of digital companies	- Provision of information on overseas market, trade practice, etc - Training on trade practice (for ICT sector), etc
	Capacity building of human resources	Training on programming skill both for students and business persons * This activity is partly conducted in PP4, DXCUP.
Cross-cutting activities	Partnership with foreign ICT ecosystem	- Signing of MoU with foreign ICT ecosystem - Co-organizing of event or business matching with ecosystem partner * This activity is partly conducted in PP1, Japan Mission.
	National level event (such as ICT Expo)	- Conducting national level ICT event (such as ICT Expo) - Inviting foreign companies and investors
	Networking platform	- Establishment of Mongolian ICT community (focusing on Mongolian living in foreign countries) - Networking and support each other when expanding business to certain country * This activity is partly conducted in PP1, Japan Mission.
	PR	- Preparation of website to promote Mongolian ICT industry - Preparation of PR material such as brochure

Эх сурвалж: Судалгааны баг боловсруулав.


(4) Ажлын хэсэг (WG) байгуулж гадаадад зах зээл тэлэх стратегийн талаар хэлэлцэх

2024 оны 4-р сард явагдсан ажлын хэсэг гадаадад зах зээлээ тэлэх талаар стратегийг хэлэлцсэн. Үүнээс гадна, тус ажлын хэсэг хувийн хэвшлийнхний санал бодлыг өргөн хүрээнд цуглуулахын тулд урьдчилан анкет бөглүүлж түүний үр дүнд үндэслэн ажлын хэсэг хэлэлцүүлгээ явуулсан.

Гадаадад зах зээл тэлэлттэй холбоотой МХХТ-ийн компаниудаас авсан анкетын үр дүн


2024оны3-4-р сардМТ парк болон хувийн хэвшлийн хурдасгуур гэх мэт сүлжээг ашиглан, МонголынМХХТкомпаниудыг (Монголын дотоодод ААН -тэй бизнес эрхэлдэг бөгөөд хөрөнгө оруулалттай холбоотой гадаадад төв компани нь бүртгэлтэй ААН- д үүнд багтана) хамарсан гадаад зах зээл тэлэхтэй холбоотой анкетыг явуулж нийт 26 компани оролцсон. Үүнээс гадна, анкетанд оролцогчдын дунд өнгөрсөн жил Япон, Монгол бизнесийн тохируулга(1)туршилтын төсөлд оролцсон компани 8 багтсан тул зах зээл тэлэх улсаар Японыг сонгох магадлал байгааг анхаарах хэрэгтэй.

Анкетанд хариулсан компаниудын онцлогыг доорх зурагт үзүүлэв. Цаашид, "Бүтээгдхүүн/үйлчилгээ хэлбэр" болон "Компаны хэмжээ (ажиллагсдын тоо)" -оор ангилав.




Эх сурвалж: Анкетын үр дүнд үндэслэн судалгааны баг боловсруулав

Зураг 39 Бүтээгдхүүн/ үйлчилгээнээр ангиалах



Эх сурвалж: Анкетын үр дүнд үндэслэн судалгааны баг боловсруулав

Зураг 40 Компаны хэмжээ(ажиллагсдын тоо)



Эх сурвалж: Анкетын үр дүнд үндэслэн судалгааны баг боловсруулав


Зураг 41 Төв компаны байрлал

- Ахлах зөвлөгчийн зөвлөгөөний үеэр ахлах зөвлөгч Наша Тех бүлгийн зөвлөгөөний явцад гарч болох тоо хэмжээ, чанарын зөрүүг арилгахын тулд бүх багуудын нөхцөл байдлыг шалгасан. Мөн бүлгийн зөвлөгөөнд оролцох боломжгүй багуудыг хамруулж, тэмцээний онцлогт тохируулан баг бүрт зөвлөгөө өгч дэмжлэг үзүүлсэн.
- Мөн, бүх багууд тус бүр 4-5 зөвлөгөөний хуралдаанд оролцох тэгш боломжоор хангахын тулд гүйцэтгэх хорооны гишүүд бүх зөвлөх хуралдаанд ажиглагчаар оролцсон.
- Бүлгийн зааварчилгааг 2-3 долоо хоног тутамд 1 удаа, ахлах зөвлөх нь сард 2 удаа хийснээр оролцогчид өөрт хэрэгтэй бизнес, технологийн мэдээллээ цаг алдалгүй авч, тэмцээнд илүү амжилттай оролцоход нэмэлт дэмжлэг хэрэгтэй эсэхийг мэдэх боломжийг олгосон.

② Оффисын аялал хийх

- Ивээн тэтгэгч компаниудад зориулсан шинэ хөтөлбөрийн хувьд бид оролцогчдод ивээн тэтгэгчийн оффисуудтай танилцах боломжийг олгох оффисын аялал хийхээр төлөвлөсөн.
- Оффисын аялалын зорилго нь ивээн тэтгэгчид зөвлөгөө өгөх хөтөлбөртэй хамтран ажиллаагүй тохиолдолд зөвхөн тэмцээний эцсийн шатанд оролцогчидтой уулзах тул энэ байдлыг засаж сайжруулах, оролцогчдод багийн зөвлөгчөөр ажилласан ивээн тэтгэгчээс бусад компаниудын үйл ажиллагаатай танилцах нийгмийн боломжийг олгох явдал юм.
- Оффисын аялалд оролцох компаниудыг сонгохдоо ивээн тэтгэгч компани тус бүрээс тухайн оффисыг хүлээн авах боломжтой эсэхийг шалгаж, оролцогч бүх багуудын айлчлахыг сонирхож буй сонголтыг баталгаажуулсны дараа 12-р сарын 5-наас 6-ны хооронд 2 өдрийн хугацаанд хамгийн их оролцох хүсэлт ирсэн дараах 4 компанид зочиллоо.
- Тус арга хэмжээ нь тэмцээний өмнөхөн зохион байгуулагдсан тул оролцогчдын тоо төсөөлж байснаас бага байсан ч оролцогчид төдийгүй зочдыг угтан авсан аж ахуйн нэгжүүд сайнаар хүлээн авлаа.

Хүснэгт 105 Оффисын аялалын газрууд

Company Name	Tour Date and Time	Number of participants
JICA Mongolia Office	Morning of December 5, 2024	8 participants from 5 teams
Mobicom Corporation	Morning of December 5, 2024	16 participants in 9 teams
Nasha Tech LLC	Afternoon of December 6, 2024	14 participants in 9 teams
GMO Z.com Mongolia LLC (Z.com ASA Arena)	Afternoon of December 6, 2024	3 participants from 2 teams



Зураг 172 Оффисын аялалын зур зураг

③ Япон, Монгол хэлний харилцаа холбоог бэхжүүлэх

- DXCUP 2024 өвлийн бэлтгэлийн хүрээнд тэмцээний мэдээллийг цахим хуудсанд нэгтгэж, япон, монгол хэлээр хуудсуудыг үүсгэсэн.
 - Япон хэл : <https://dxmongolia.org/dxcup/2024JP/>
 - Монгол хэл : <https://dxmongolia.org/dxcup/2024MN/>

- Тэмцээний өмнө бид дүнг зарлах хэлбэр, урьдчилсан найруулга гаргаж, DXCUP-ээс 2 хоногийн дараа буюу 12-р сарын 9-нд Япон, Монгол хэлээр дүнгээ зарлаж, ивээн тэтгэгч компаниудад мэдэгдсэн.
- Цаашид зохион байгуулах арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд вэб сайтыг шинэчлэх энгийн гарын авлагыг бий болгож, мэдээллийг шуурхай түгээх системийг бий болгожээ.

④ Ивээн тэтгэгч олж авах ажлыг эрчимжүүлэх бэхжүүлэх

- Ивээн тэтгэгчийн мөнгө 2.2 сая иен босгосон нь 3 дахь DXCUP-д цуглуулсан дүнгээс бараг 3 дахин их, мөн ялагч болон бусад дэд байруудад шалгарсан багуудад олгосон нэмэлт шагналыг (ялагч багийн Японд хийсэн аялал гэх мэт) тооцож үзвэл энэ нь ивээн тэтгэлэг ихээхэн нэмэгдсэнийг харуулна.
- Өнгөрсөн хугацаанд 3 удаа ивээн тэтгэх хүсэлтийг хувийн журмаар гаргаж байсан ч энэ удаагийн тэмцээнийг ивээн тэтгэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор туршилтын журмаар Монгол, Япон улсаас ивээн тэтгэх боломжтой компаниудын жагсаалтыг гаргаж, компани тус бүртэй харилцах хялбаршуулсан гарын авлагыг гаргасан нь ивээн тэтгэгч авах үйл явцыг хялбарчлахад хүргэсэн.
- Мөн ивээн тэтгэх хөрөнгийн зорилтот хэмжээг тогтоож, удирдлагын багийн хүрээнд 7 хоног бүр зохион байгуулдаг ажлын ахицыг хэлэлцдэг хурлаар нөхцөл байдалтай танилцаж, онцгой анхаарал хандуулах шаардлагатай боломжит ивээн тэтгэгчдэд хэрхэн хандах зэрэг ажлуудыг авч үзэж, ивээн тэтгэгч авахад чиглэсэн ажлуудыг Монгол, Японы талууд үүрэг хариуцлагаа хуваалцан хэрэгжүүлсэн.
- Хойшид шийдэх асуудал гэвэл, Японы компаниудаас ивээн тэтгэх хүсэлт гаргахад нарийвчилсан зохицуулалт шаардагддаг тул менежментийн багт япон хэлээр чөлөөтэй харилцаж чаддаг боловсон хүчин байх нь зүйтэй юм. DXCUP-ийн удирдлагын бүтцийг ивээн тэтгэгчээ нэмэгдүүлж чадахуйц бүтэц болгох зорилгоор дахин зохион байгуулах шаардлагатай гэж үзэж байна.

Хүснэгт 106 3, 4-р DXCUP-ийн орлого, зарлагын харьцуулалт

		3rd DXCUP(2024)	4th DXCUP (2024Winter)
Income	Sponsorship	870,000 yen	2.11million yen (*1)
	Total amount	870,000 yen	2.11 million yen
Expenditure	Prize Money (1st-3rd)	480,000 yen	440,000 yen (*2)
	Prototype production cost	220,000 yen	440,000 yen
	MNB video production costs	(Not implemented)	230,000 yen
	FBAd,Canva, Award Board	10,000 Yen	10,000 yen
	LEDs, Advertising panels,.	13,000 yen	20,000 yen
	Venue and coffee break fee	(to be raised from a separate budget)	510,000 yen
	Simultaneous interpretation and equipment rental	(to be raised from a separate budget)	150,000 yen
	(certified public) accountant	60,000 yen	90,000 yen
	Other	87,000 yen	220,000 yen
	Total amount	870,000 yen	2,110,000 yen

※1 Нэг ивээн тэтгэгчийн төлбөр(2,500,000MNT, ойролцоогоор 110,000 иен)энэ тайлан гаргах үед батлагдаагүй тул орлогод бүртгээгүй болно.

※2 Энэ мэдээллийг гаргах үед ялагч багийн дансны мэдээллийг баталгаажуулах боломжгүй шагналын мөнгө (2,000,000MNT, ойролцоогоор 90,000 иен) шилжүүлэгдээгүй байгаа тул зардалд бүртгээгүй болно.

(г) Үр дүн

PP(4)4 дэх DXCUP-ийн дараах үнэлгээ дараах байдалтай байна.

Хүснэгт 107 РР(4)4 дэх DXCUP-ийн дараах үр дүн

Evaluation item		Results
Achievement of Objective		• Objective (1): DXCUP has been highly evaluated as a human resource development program (PBL) by the Mongolian Fund for Science and Technology (MFST), sponsoring companies, and teachers of participating universities and technical colleges, and it can be said that Objective (1) was mostly achieved. • Objective (2): While we were able to establish programs that would lead to career development, such as mentoring, special lectures, and office tours for DXCUP participating students, we received many requests from participating universities and technical colleges for additional programs (such as workshops in advance of the event). It is expected that the quality of learning will be further enhanced by considering programs throughout the year, rather than one-off events.
Resources	Personnel	• The DXCUP has established a system in which the secretariat can be fully functional with the operation of only one local mercenary, thanks to the progress made in formulating the processes and organizing various manuals for DXCUP operations. • The introduction of the Chief Mentoring and Group Mentoring System has compensated for the shortage of management personnel and has brought us much closer to an operational structure that is capable of sustainable development.
	Cost (sponsorship)	• The creation of the website and the production of panel designs could be done in-house, and costs, except for venue expenses, could be reduced, resulting in the event breaking even for the first time in its fourth year. • The manual and flow of acquiring sponsorships has been developed, and DX Mongolia is now in a position to acquire sponsorships from local companies on its own. • On the other hand, it is important to obtain major sponsorships from Japanese companies and others in order to secure the availability of one person to perform the aforementioned secretariat function, and the establishment of a system that can respond to Japanese companies, which has mainly been the responsibility of the survey team, will be an issue for the future.
Preparation	Concept	• In the 4th DXCUP, the goal was generally achieved by utilizing the previous manuals and productions while aiming to reduce the number of tasks that had been assigned to the genus to zero.
	Participating companies (selection and communication)	• Through the 3rd and 4th rounds, the transparency of the screening criteria and the results of the selection process have been improved, and the number of complaints about the selection and screening process, which had existed in the past, have been significantly reduced. • Communication errors between participating teams and sponsors have also been greatly reduced through the chief mentoring system and the accompaniment of the secretariat staff, and it has become possible to flexibly select communication tools in accordance with the wishes of the sponsors. • Participation from Japanese universities has also become an ongoing event, contributing not only to the exchange between the two countries, but also to the overall level of the competition, as well as to the promotion of entrepreneurship education in Japan.
	How to publicize the	• Referral application recommendations by the previous competing teams and teachers in charge were strengthened, and certain results were

	event	achieved, such as the promotion of awareness of the program at each school. • The online advertising campaign has also continued to attract visitors through SNS and other means, and the fact that three of the teams participating in the 4th competition applied after reading the online announcement confirms the effectiveness of the prototype advertising campaign.
Operation	Attracting audience	• Nearly 200 people attended the event. • More than half of the visitors came to the event to support each participating team, making it the largest-ever number of student participants.
	Online Streaming	• KITE was able to continue the Facebook LIVE streaming of the second and third sessions, and we were able to confirm a certain level of success, with some viewers coming from Japan on the day of the event and hearing from the sponsor company that they had listened to the video later on.

(д) Дэмжих арга хэмжээний mglggjh vgygl

Туршилтын төсөл МХХТ-ийн чиглэлээр мэргэшсэн оюутнуудыг хөгжүүлэх хөтөлбөрийг авч үзэх, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг дараах 3 чиглэл гэж үзэж байна.

- ① Японы эрдэм шинжилгээний байгууллагуудын санал болгож буй хамтарсан төслүүдийг төлөвлөх (ЖАЙКА-ын анхан шатны түншлэлийн хөтөлбөрийг оролцуулан)

3 дахь удаагийн DXCUP-д оролцсон баг туршлага хуримтлуулсны дараа Японд бизнесээ эхлүүлсэн мэдээг хүлээн авлаа. Энэхүү тохиолдол нь Их сургуулийн хувьд оролцогч багийг сонгосон сайн жишээ болж, Япон, Монголын их сургуулиудад хамтын ажиллагааны боломж байгааг харуулсан.

Одоогоор тус их сургууль Монголын их дээд сургуулиуд болон хувийн хэвшлийн компаниудтай цаашид хамтран ажиллах янз бүрийн арга хэмжээг хэлэлцэж байна. Эдгээр төслүүдийн нэг болох JICA-ийн анхан шатны техникийн хамтын ажиллагааны төслийн саналыг авч хэлэлцсэн бөгөөд тус сургууль нь МХХТ-ийн чиглэлээр суралцаж буй оюутнуудад зориулсан боловсролын хөтөлбөрийг бэхжүүлэх зорилгоор DXCUP-ийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага болох DX Mongolia болон DXCUP-д оролцогч багуудын харьяалагддаг Монголын их, дээд сургууль, техникийн коллежид техникийн зааварчилгаа өгөх юм. Түүнчлэн Япон, Монгол хоёр улсын эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагаа, хамтын бүтээлийг дэмжихэд анхаарч байна.

- ② DCON болон DXCUP хоёрын цаашдын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготой түншлэлийг бий болгох

2022 онд DXCUP-д оролцох багууд 2023 онд болох DCON-ийн финалд оролцох гэх мэт DCON болон DXCUP-ын хоорондын хамтын ажиллагаа нэмэгдсэнээс гадна DCON-ний зохион байгуулах хороонд гол үүрэг гүйцэтгэгч болохыг зорьж байгаа Японы Гүн Сургалтын Нийгэмлэг (JDLA)-тай цаашид хамтран ажиллах боломжийн талаар олон удаа ярилцсан.

Тус хэлэлцүүлгийн үеэр JDLA нь DCON -той адил гэрчилгээжүүлэх шалгалтыг (G-Test) гадаадад өргөжүүлэн тэлэх төлөвлөгөөтэй байгааг сонссон ба энэ тал дээр Монголд амжилттай хэрэгжиж буй практик ажил болох DXCUP-аас гадна нь илүү ахисан түвшний мэдлэг олж авах, хадгалахад түлхэц болох сургалтын шинэ орчинд гэрчилгээжүүлэх шалгалтыг (G-Test) нэвтрүүлэхийг сонирхдог хэд хэдэн техникийн коллеж, их дээд сургууль байгаа нь мэдэгдсэн.

Өнгөрсөн хугацаанд Жайка нь Японы Мэдээллийн технологийг дэмжих агентлагаас (IPA) зохион байгуулдаг Мэдээллийн технологийн инженерүүдийн мэргэшлийн шалгалтыг (ITEE) нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэх техникийн хамтын ажиллагааны төслийг хэрэгжүүлсэн ба хойшид JDLA нь гэрчилгээжүүлэх шалгалтыг (G-test) Монголд нэвтрүүлэх, түгээхийг нухацтай авч үзэн техникийн хамтын ажиллагааны төсөл эсвэл Өвсний үндэс техникийн хамтын ажиллагааны төсөл боловсруулах зэрэг дэмжлэгийн арга хэмжээг хэлэлцэх шаардлагатайг JDLA -д мэдэгдэв.

③ Орон нутагт тогтвортой удирдлагын тогтолцоог бий болгох

4 дэх DXCUP-ийг өмнө нь 3 удаа зохион байгуулсан туршлагатай DX Mongolia удирдан төлөвлөлт, удирдлагыг зохион байгуулснаас гадна Наша Тех ахлах зөвлөгчөөр оролцсон нь маш том сорилт болж байсан зааварчилгааны (мониторинг) ажлын чанарыг сайжруулахад хувь нэмрээ оруулсан.

Дээр дурдсан хоёр компани хамтран ажиллахад орон нутгийн ажилчдын оруулсан хувь нэмэр их байсан. Орон нутгийн боловсон хүчнийг хоёр талын хооронд зуучлагчийн үүрэг гүйцэтгэж, нягт нямбай харилцаа холбоог бий болгосноор өөр өөр байгуулгын соёлтой хоёр компанийн давуу талыг ашиглаж чадсан гэж үзэж байна.

Мөн, Дээр дурьдсанчлан DXCUP-ийг үргэлжлүүлэн ажиллуулахын тулд Японы компаниудын ивээн тэтгэх үйл ажиллагаа чухал ба 4 дэх удаагийн DXCUP-д япон хэлээр чөлөөт япон хэлээр чөлөөтэй харилцаж чаддаг орон нутгийн ажилтнууд манлайлан оролцож Японы компаниудтай янз бүрийн тохиролцоонд хүрч ажилласнаар ивээн тэтгэгчид нэмэгдэхэд нэмэр болсон. ихээхэн нөлөөлсөн.

Дээр дурдсаны дагуу орон нутаг дахь тогтвортой удирдлагын тогтолцоог DX Mongolia болон Наша Тех компаниуд хамтран ажиллах хэрэгжүүлэх санал гаргасан ба ивээн тэтгэх болон хоёр компанийн хоорондын уялдаа холбоог бүрэн хангаж дуустал (1-2 жилээр тооцсон) орон нутгийн ажилтнуудыг тасралтгүй ажиллуулахыг зөвлөж байна.

5. Туршилтын төсөл (5) Нээлттэй өгөгдөл ашиглах хөтөлбөрүүдийг шалгаж хэрэгжүүлэх

PP(5)-д хувийн компаниудад чиглэсэн "Монгол Улсын Засгийн газраас эзэмшиж буй нээлттэй өгөгдлийг ашиглан төрийн үйлчилгээг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх бизнесийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлсэн.

(1) Хэрэгжүүлэх бодлого

(a) Хэрэгжүүлэх зорилго

(1) Засгийн газрын нээлттэй мэдээллийн портал дээрх өгөгдлийн багцыг ашиглан хэрэглээний загваруудыг боловсруулах, бизнесийн үзүүлэнг зохион байгуулах замаар төсөл нь Монгол дахь хувийн компаниудад төрийн нээлттэй мэдээллийн үр нөлөөг нэмэгдүүлэх, (2) хувийн компаниудыг мэдээллээр хангах, тэдгээрийг арилжааны хэлбэрт оруулах замаар төрийн нээлттэй мэдээллээр дамжуулан нийгмийн асуудлыг шийдвэрлэх, төрийн үйлчилгээг сайжруулах, олон нийтэд нээлттэй мэдээлэл хуримтлуулах, олон нийтэд нээлттэй мэдлэгийг бий болгох, олон нийтэд таниулах мэдлэгийг бий болгоход чиглэгдэх ба хувийн хэвшлийнхний засгийн газрын нээлттэй өгөгдлийг ашиглах, мэдээлэл түгээх жишээ болно.

(б) Хөтөлбөрийн агуулга/хуваарь

Хөтөлбөрийн агуулга, хуваарийг дараах үе шаттайгаар хэрэгжүүлэв.

1. Бизнесийн санаа гаргаж чадах компаниудын өргөдлийг бүртгэж авна
2. Өргөдөл гаргагчдаас хамгийн сайн санааг санал болгосон компанийг сонгоно.
3. Сонгогдсон компаниудын дунд хакатон зохион байгуулж, шинэ санаагаар эх загварыг бүтээнэ.
4. Хакатоны үр дүнд онцгой загвар зохион бүтээж буй компаниудад бизнесийн нотлох баримтын (PoC) дэмжлэг үзүүлэх болно.
5. PoC компаниуд үр дүнгээ танилцуулж, салбарын оролцогч талуудтай холбоо харилцаа тогтоох арга хэмжээ зохион байгуулна.

Хүснэгт 108 PP(5) Нээлттэй өгөгдөл ашиглах хөтөлбөр

【Applicant Selection】 (Recruitment period: 2 months) (1) Propose business ideas aimed at solving public service issues using open data.	【Selection of Issues】 In consultation with MDDIC, it was decided to focus on the healthcare sector, where a relatively substantial stock of open data is expected. 【Use of Open Data】 Applicants are required to use open data. The use of other data is optional, with no upper limit on the number of datasets used. Business ideas utilizing open data were created in PPT format and submitted as application documents. 【Evaluation of Business Ideas】 The organizers evaluated the applicants based on their contribution to public services, monetization potential, and technical feasibility. Seven
--	--

	companies were selected and granted the right to participate in the hackathon.
【Hackathon】 (5 days) (2) Development of solutions (creation of prototypes)	【Development of Prototypes】 The seven selected companies developed prototypes of solutions for public service issues using open data. While smartphone apps are conceivable, the type of prototypes was not limited. Regarding the human mobility data (GEOTRA) provided by Mobicom Corporation, collaboration with Mobicom Corporation enabled the data to be offered free of charge. Participating companies used GeoTra as one of the open data sources. 【Support by Mentors】 Engineers and other experts were invited from MDDIC, the Health Development Center of the Ministry of Health, the IT Park, and the Ulaanbaatar Innovation Hub. They provided necessary support for the development towards implementation, including technical advice and mentoring. 【Evaluation of Deliverables】 The prototypes developed over the course of five days were evaluated based on their completeness, business model, feasibility, and potential for business proof-of-concept. Two outstanding companies were selected.
【Business Proof-of-Concept & Matching】 (3 months) (3) Implementation of technical proof-of-concept (PoC) and business proof-of-concept (PoC) (4) Matching event	【Development of Business Model】 Support was provided to further develop the business models of the prototypes created using open data in step (2), enhancing them from their initial application stage to ensure they are monetizable and contribute to solving public service issues. 【Business Proof-of-Concept】 A proof-of-concept test was conducted for the developed business models, evaluating technical feasibility, usefulness, return on investment, social acceptability, and market entry considerations. 【Support by Advisors】 Business proof-of-concept experts and experienced entrepreneurs, both within and outside the subcontracted company (DX Mongolia), provided advice and mentoring. Advisors were also invited from the government to offer guidance aimed at contributing to the resolution of public service issues. 【Evaluation of Proof-of-Concept Results】 The organizers evaluated whether the proof-of-concept results met criteria such as technical feasibility, contribution to public service issues, and a certain level of profitability. 【Implementation of Presentation (Networking Event)】 The companies that conducted the PoC presented their results, and a networking event was held with the participation of MDDIC, the Ministry of Health, Ulaanbaatar city officials, and industry stakeholders. Initially, there was also an aim to invite both domestic and international investors to appeal for investment to the projects. Unfortunately, no investors were able to attend.


(2) Hackathon болон PoC хэрэгжилт

(a) Хакатон тэмцээнд бэлтгэх

Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яам өмнө нь нээлттэй өгөгдөл ашиглан хакатон зохион байгуулахаар төлөвлөж байсан. Тодруулбал, 2023 онд MDDIC нь хувийн компаниудад зориулсан замын түгжрэлийн асуудлыг шийдвэрлэхэд нээлттэй өгөгдлийг ашиглах хакатон зохион байгуулах талаар хэлэлцэхээр төлөвлөж байсан. Гэвч, өргөдөл гаргагчийн тоо дөнгөж 7 байсан нь эхэндээ таамаглаж

байснаас 20-иос бага бөгөөд оны сүүлээр яам ажил ихтэй байснаас болж хуваарийг тохируулахад хүндрэлтэй байсан тул арга хэмжээг цуцалжээ.

Энэ нөхцөл байдлын үүднээс MDDIC -тэй хамтран 2024 онд багтаан нээлттэй мэдээлэл ашигласан хөтөлбөрийг төлөвлөж, бэлтгэж, хэрэгжүүлэхээр шийдсэн. 2024 оны 1-р сараас эхлэн дээр дурдсанчлан MDDIC-ийн санал, зорилго, хөтөлбөрийн агуулгыг хэлэлцэх зорилгоор MDDIC-тэй долоо хоног тутмын уулзалт зохион байгуулав. Энэ удаад замын түгжрэлийг шийдвэрлэх бус эрүүл мэнд, эрүүл мэндтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх сэдвийг сонгосон. Эцэст нь MDDIC, уг хакатоныг MDDIC, Эрүүл мэндийн яам, ЖАЙКА, Улаанбаатар инновацийн төв, Мобиком компанитай хамтран зохион байгуулахаар тогтлоо.




Зураг 173 Hackathon хэрэгжилтийн бүтэц

		2024											
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Preparation	Reviewing the open data hackathon 2023												
	Selecting themes for open data (traffic jam / air pollution)												
	Confirming organizers, co-organizers, and co-sponsors												
	Preparing Request For Proposals												
	Recruitment of Hackathon mentors												
	Recruitment of sub-contractors (PoC operation/mentoring)												
	Preparing PR channels to provide RFP and a list for DM												
	Preparing proposal/hackathon evaluation sheets												
	Preparing the website/SNS for Hackathon/PoC												
Hackathon / PoC	①Offering proposals												
	Selection of up to 10 companies (screening of applications)												
	②Product prototyping through hackathons (2-5 days)												
	Selection of up to 2 companies (based on the results of the hackathon)												
	③PoC /Creating business models												
	④Matching event with investors and business companies												
	Summarizing results												

Зураг 174 Hackathon болон PoC хэрэгжүүлэх хуваарь

Хакатонд оролцох хүсэлтийг 2024 оны 6-р сарын сүүлээр MDDIC-ийн салбар IT Park-ийн Facebook хаягаар авч эхэлсэн. Бид IT Park-тай хамтран оролцох багуудын зорилтот тоонд (10 компани) хүрэхийн тулд сонгон шалгаруулалтын хугацаанд компани, их дээд сургуулиудад хакатоньг сурталчлах ажлыг үргэлжлүүлсэн. Түүнчлэн хакатон тэмцээнд ментороор хангах зорилгоор Цахим Монгол, Ай Ти Парк, MDDIC, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Улаанбаатар инновацийн төв зэрэг байгууллагуудтай хэлэлцүүлэг өрнүүлж, хакатон зохион байгуулахад шаардлагатай мэдлэг, зөвлөгөөг өгөх зөвлөхүүдийг хамтран зохион байгуулагч бүрээс сонгон шалгаруулсан. Тодруулбал, Цахим Монгол нь эх загвар боловсруулах техникийн тал дээр зөвлөн туслах, чиглүүлэх үүрэгтэй байсан бөгөөд хөгжүүлэлтэд шаардлагатай мэдлэгийн талаар лекц уншдаг байв.

Хакатонд ашиглах өгөгдлийн багцын тухайд MDDIC-ийн хүсэлтийн дагуу эрүүл мэндийн салбарын нээлттэй мэдээллийг (1313.mn гэх мэт) хакатон дээр голчлон өгөхөөр шийдвэрлэсэн. Үүний цаана Монгол Улсын Засгийн газар нь тэр дундаа Эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудлыг Эрүүл мэндийн яамны удирдлага дор эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх ажлыг эрчимжүүлж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн удирддаг нээлттэй мэдээллийн портал 1313.mn болон Засгийн газрын мэдэлд байгаа эрүүл мэндийн мэдээлэлийг нээлттэй болгож гуравдагч этгээдэд үр дүнтэй ашиглах боломжийг нээж өгснөөр эрүүл мэндийн салбарт нээлттэй инноваци хийх замаар төрийн үйлчилгээг сайжруулж, асуудлыг шийдвэрлэх зорилго байсан. Гэвч 1313.mn сайтын нээлттэй өгөгдөл нь мэдээллийн багцын тоогоор хязгаарлагддаг ба зарим мэдээллийн багцад портал дээр хандах боломжгүй байсан нь үйл ажиллагаанд хүндрэл учруулсан. Иймд Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс 1313.mn сайтад байршуулаагүй ч цаашид олон нийтэд нээлттэй болгохоор төлөвлөж буй Excel форматаар 300 орчим дата багцыг оролцогч баг бүрт олгохоор тохиролцлоо. Цаашлаад эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд Монгол дахь хүн амын шилжилт хөдөлгөөний мэдээллийг ашиглахын тулд Мобиком компанид гар утасны байршлын мэдээллийн маркетингийн хэрэглүүр болох GEOTRA-ийн туршилтын хувилбарыг хакатонд зориулан өгсөн.



Зураг 175 Хакатон тэмцээнд оролцогчдын өргөдлийг хүлээн авах баннер

(6) Хакатон зохион байгуулах

Хүснэгт 109 Хакатоны тойм

Schedule	Monday, September 2, 2024 – Friday, September 6, 2024
Venue	IT Park
Participating Teams	Team Anwjin Health Map Rookie Systems Care AI Prevention Healthcare Hey Doctor (Student Teams) Data Med
Target Fields	The business idea must pertain to the "Healthcare" field. Utilization of GEOTRA and its data provided by Mobicom is optional.
Implementation Details	- Participating teams will develop solutions that serve as prototypes for businesses utilizing open data to address challenges and improve public services in the healthcare sector in Mongolia. - Utilize open data provided by the Health Development Center. - Mentors will be available at the hackathon venue to provide advice from a technical development and business perspective. The mentors are provided by the MDDIC, the Ministry of Health, the Health Development Center, IT Park, and the Ulaanbaatar Innovation Hub. - The format of the prototype is not restricted (e.g., application, smartphone app, website, hardware, etc.). - In addition to open data, outputs that combine other commonly accessible and permissible web data or APIs are also acceptable.
Data Utilized (1) Data from Ministry of Health	330 statistical datasets held by the Health Development Center (such as mortality rates, birth rates, number of hospital beds, and other healthcare-related datasets).

Data Utilized (2) Location Information Data from Mobicom	• GEOTRA: A marketing data with visualization and analytics function tool currently under development by Mobicom, utilizing mobile phone location data. Latitude and longitude data can also be downloaded in CSV format.
Mentors	• Enkhtulga Ganbat (MDDIC) • Altangerel Bolortulga (Health Development Center) • Enkhmanlai Khatanbaatar(e-Mongolia) • Bold Enkhjin(IT Park) • Gankhuyag Damdinsuren(Ulaanbaatar Innovation Hub) • Brandon Saffell (Deloitte Tohmatsu Financial Advisory LLC) • Jin Yoshida (Deloitte Tohmatsu Financial Advisory LLC)
Evaluation Method	• Scoring based on a score sheet - Product definition - Possibility of making a prototype - Profitability - Sustainability of business operation - Innovation - Attendance rate • Final decision determined by the judges' deliberation - Baatar Tungalag (MDDIC) - Davaa Sumiya (Health Development Center) - Bold Enkhjin (IT Park) - Batkhishig Zaya(JICA Mongolia Office) - Gankhuyag Damdinsuren(Ulaanbaatar Innovation Hub) - Brandon Saffell (Deloitte Tohmatsu Financial Advisory LLC)
Results	• Winner: Rookie Systems (Awarded 20 million MNT (860,000 JPY) for PoC costs) • Runner-up: Data Med (Awarded 15 million MNT (640,000 JPY) for PoC costs) The above two companies conducted PoCs and presented their results in December.

MDDIC, Эрүүл мэндийн хөгжлийн төв, IT Park, Ulaanbaatar Innovation Hub хамтран Нээлттэй мэдээллийн хакатоныг 2024 оны 9-р сарын 2-оос 6-ны хооронд зохион байгууллаа. Өргөдөл хүлээн авах эцсийн хугацаа болох 8 сарын 26 гэхэд компаниудыг оролцуулаад 12 баг хүсэлтээ ирүүлснээс эцсийн мөчид татгалзсан хэд хэдэн компанийг эс тооцвол 7 нь Хакатон тэмцээнд оролцохоор сонгогдов.

Хакатоны үр дүнд 7 компаниас 1 нь татгалзаж, бусад 6 компани өөрсдийн загваруудын талаар эцсийн байдлаар илтгэл тавьж, шүүгчдээс санал, үнэлгээ авчээ. Шүүгчдийн ерөнхий сэтгэгдэл бол бүх багууд техникийн өндөр ур чадвартай, шинэ санаагаар дүүрэн, Монголын эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд тус дөхөм болохуйц бизнес болгон арилжаалах боломжтой анхны загвартай байсан гэсэн дүгнэлт байсан. Нөгөөтэйгүүр, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс өгсөн нээлттэй мэдээллийг загвар загвартаа тусгах нь бүх багуудад хүндрэлтэй байсан гэсэн тайлбарыг бид хүлээн авсан. Эхнээсээ туршилтын загвар боловсруулах нөхцөл нь тус бүтээл нь нээлттэй өгөгдлийг агуулсан байх ёстой бөгөөд бүх багууд хакатоны турш Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс гаргасан эмчилгээний болон эрүүл мэндийн салбарын статистик мэдээлэл, мөн Мобикомоос өгсөн GEOTRA -гийн өгөгдөл буюу хоёуланг нь ашиглахад анхаарлаа хандуулсан боловч, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс өгсөн мэдээлэл нь Excel файлын статистик мэдээллээр хязгаарлагдсан ба Монголын эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж, санал зөвлөмж өгөхөд үр дүнтэй байсан ч бүх баг статистикийн мэдээллийг өөрийн загвартаа тусгахад нэлээд их бэрхшээл туулсан. Оролцогч хэд хэдэн баг хиймэл оюун ухааны загваруудыг ашиглах талаар бодож байсан нь статистик мэдээллээс илүү AI загварт ашиглаж болох том өгөгдөл, түүнчлэн текст гэх мэт чанарын өгөгдөлд ихээхэн хэрэгцээ байгаа нь тодорхой болов. Жишээлбэл, Data Med-ийн хувьд вэб хусах аргыг бие даан ашиглаж интернетээс туршилтын загварт ашиглаж болох чанарын мэдээллийг цуглуулж AI chatbot-д ашигласан. GEOTRA-ийн байршлын өгөгдөлд оролцогчид сайн үнэлгээ өгсөн бөгөөд үүнийг API-ээр дамжуулан програмуудын интерфэйсүүдэд ашиглах хэрэгцээ, мөн байршлын өгөгдлийг програмуудад оруулах (жишээ нь, хүн ам

шигүү суурьшсан газруудад сэрэмжлүүлэг гаргах) хэрэгцээ байгаа боловч GEOTRA нь хакатоны явагдах үед ажиллуулсан туршилтын хувилбар байсан бөгөөд API-д зориулагдаагүй байсан туршилтын загварт оруулах боломжгүй байв. Гэсэн хэдий ч GEOTRA-ийн өргөрөг, уртрагийн CSV өгөгдлий үнэлгээ маш сайн байсан тул хэрвээ хакатоныг удаан хугацаанд зохион байгуулсан бол туршилтын загварт ашиглах боломж байх байсан гэж үзэж байна. Өмнө дурьдсанчлан, Data Med-ийн нэгэн адил Эрүүл мэндийн хөгжлийн төвийн статистик мэдээлэл болон GEOTRA-аас бусад мэдээллийг ашиглах тал дээр оролцогч бүх багууд хүчин чармайлт гаргасан ба туршилтын загварын танилцуулга болон PoC-д зориулсан цахим Монголтой хамтран ажиллах санаануудыг танилцуулах зэргээр оролцогчид нь хэрэгтэй мэдээлэл цуглуулах бүх төрлийн боломжуудыг авч үзсэн байсан.

Дээрх үе шатнуудыг туулсны дараа загваруудын бүрэн бүтэн байдал, ТЭЗҮ-ийн боломж, цаашдын арилжаанд оруулах боломж зэргийг харгалзан үзээд онооны хуудсан дээр оноо тавьж, харилцан зөвлөлдсөний дараа Rookie Systems болон Data Med багийг PoC-д оролцох багуудаар сонгосон.

Энэхүү хакатонд Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс ирүүлсэн статистик мэдээллийг зөвхөн тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, санал гаргахад ашигласнаас дүгнэхэд төрийн байгууллагуудын мэдээллүүдээс эрэлт ихтэй нь статистикийн мэдээлэл биш харин байршлын мэдээлэл, GEO өгөгдөл, том өгөгдөл, зураг гэх мэт бүтэцгүй өгөгдөл болохыг харуулж байна. Байршлын өгөгдөл ашигладаг программууд болон, машин сургалтын алгоритм ашиглан дүрс оношлох, чатбот гэх мэт өргөн хүрээний хэрэглээтэй тул засгийн газрын ийм мэдээллийг нээлттэй болгох маш их хэрэгцээ байна. Нөгөөтэйгүүр, энэ нь статистикийн мэдээлэл нь ашиг тусгүй гэсэн үг биш санал, бодлогын зөвлөмж өгөхөд үр дүнтэй гэж үзэж байгаа юм. Тиймээс хэрэв нээлттэй мэдээллийн порталууд нь статистик мэдээллээс гадна том өгөгдөл болон бүтэцгүй өгөгдөлд хандах боломжийг олгож чадвал хувийн компаниуд болон хөгжүүлэгчдийн хувьд тэдний үнэ цэнэ өснө гэж бид үзэж байна.

Хүснэгт 110 Оролцогч баг бүрийн эх загваруудын тойм

Team	Issues to be addressed	Solution	Open Data Utilized (Excerpt)
Anvvjin	Management of hospital bed availability and al location of inpatients in domestic hospitals is not being done appropriately:	AI-powered hospital booking system linked with real-time hospital bed availability	Annual open data on hospital bed information (provided by the Health Development Center) Real-time bed availability information
Rookie System	High volume of unnecessary calls, resulting in 30% of emergency calls (so-called 119) not being answered:	AI Bot for preliminary call screening at call centers (diagnosis based on symptoms, urgency assessment)	Data on the usage of emergency calls (only summary data, used for understanding the issue) Acquisition of test results from private hospitals during PoC
Care AI	Children's dental cavities:	Educational app for children's tooth brushing Display of brushing history and risk levels	Tooth image data (not open data)
Prevention Healthcare	Preventable diseases like diabetes and hypertension	Personalized risk assessment, preventive measures suggestions, early detection advice	Personal information such as age, gender, family medical history Various test results from hospitals Targeting customers aged 40 and above using GEOTRA

Hey Doctor	Inappropriate use of medication by children when left alone:	Educational app for children's health Child monitoring function	Data on diseases and injuries Location information of crowded areas (high accident risk) provided by GEOTRA
Data Med	Lack of medical access, shortage of doctors, and insufficient medical information in rural areas:	Chatbot providing medical and drug information	E-Clinic (suggestions from 120 doctors) WHO and Ministry of Health guidelines Acquisition of data from pharmaceutical companies during PoC



Зураг 176 Хакатон тэмцээний байдал

MENTOR SCHEDULE				
TIME	Monday (September 2nd)	Tuesday (September 3rd)	Wednesday (September 4th)	Thursday (September 5th)
MINISTRY OF DIGITAL DEVELOPMENT, INNOVATION AND COMMUNICATIONS	9:00-12:00	-	-	10:00-11:00, 13:00-14:00
CENTER FOR HEALTH DEVELOPMENT	9:00-14:00	13:00-15:00	13:00-15:00	10:00-12:00
IT PARK	9:00-17:00	10:00-11:00	9:00-11:00	9:00-11:00, 15:00-16:00
INNOVATION HUB	9:00-12:00	-	10:00-12:00	11:00-12:00
E-MONGOLIA	-	15:00-17:00	13:00-14:00	14:00-15:00
DELOITTE	9:00-17:00	11:00-17:00	9:00-17:00	9:00-17:00

Зураг 177 Менторын цагийн хуваарь

(в) PoC явуулах, үр дүнг зарлах, сүлжээний арга хэмжээг зохион байгуулах

Нээлттэй өгөгдөл Hackathon тэмцээний шилдэг 2 ялагч болох Rookie Systems болон Data Med нар 2024 оны 9-р сараас 11-р сар хүртэл хакатон дээр хөгжүүлсэн үйлчилгээ/аппликейшнүүдийг боловсронгуй

болгох зорилгоор PoC (Proof of Concept - үзэл баримтлалын баталгаа) хэрэгжүүлсэн. PoC-г Монголд хэрэгжүүлэхэд практик дэмжлэг шаардлагатай байсан тул DX Mongolia-г орон нутгийн туслан гүйцэтгэгчээр сонгосон бөгөөд тус компанийн Төгөлдөр тэргүүтэй зөвлөгч нарын баг PoC-ийг хэрэгжүүлэхэд тусалсан.

Тус PoC-ийн үр дүнг холбогдох яам, MDDIC-д мэдээлж нээлттэй мэдээллийн хэрэглээг цаашид сурталчлах, эрдэм шинжилгээний байгууллага, МХХТ-ийн компаниуд, VC-тэй харилцах харилцааг дэмжих, нээлттэй мэдээллийн хувийн хэвшил дэх хэрэглээ, түүнийг ашигладаг үйлчилгээг арилжааны хэлбэрт шилжүүлэх ажлыг хурдасгах зорилгоор 2024 оны 12 дугаар сарын 6-ны өдөр сүлжээний арга хэмжээг зохион байгуулсан.

Хакатоноор Дата Мед нь цахим клиник (120 эмчийн санал), ДЭМБ, Эрүүл мэндийн яамны удирдамж гэх мэт өвчлөлийн талаарх мэдээллийг цуглуулж, чатботоор дамжуулан эмнэлгийн болон эмийн мэдээллээр хангахыг зорьсон. PoC-ийн үеэр чатботын хариултын үнэн зөвийг сайжруулахын тулд компани нь онлайн эмийн сан болох МЕИС-тэй хамтран ажиллаж, тус компаниас эмийн талаарх мэдээллийг авсан.

Үүний үр дүнд доор үзүүлсэн шиг chatbot-ыг хийж дуусгасан бөгөөд одоогоор чатботыг МЕИС-ийн үйлчилгээ болгон гаргахаар төлөвлөж байна.

Бизнес эерэгээр урагшилж байгаа нь сайшаалтай. Гэвч нээлттэй мэдээллийн ашиглалтын хувьд зөвхөн нээлттэй өгөгдөл нь арилжаанд ороход хангалтгүй байсан тул мэдээллийн нарийвчлалыг сайжруулахын тулд хувийн компаниудын мэдээллийг ашиглах шаардлагатай болсон зэрэг нь нээлттэй өгөгдлийн ашиглалтын хязгаарлагдмал талыг харуулсан.



Зураг 178 Data Медийн илтгэл

Helper chatbot for online pharmacy



Зураг 179 Data Med-ийн чатбот

Бодит мэдээлэлд үндэслэн яаралтай тусламжийн шаардлагагүй дуудлага их байсныг харуулж,

яаралтай дуудлагад хариу өгөх хурдмуу байгааг харуулж, хиймэл оюун ухааны роботуудыг ашиглан дуудлагын төвийн урьдчилан шүүлт хийх програмыг боловсруулсан. Тодруулбал, AI Bot нь шинж тэмдгийг оношлох, хэргийн яаралтай байдлыг тодорхойлох, түүнчлэн яаралтай бус бусад лавлагаанд зохих хариулт өгөх зорилготой юм. PoC-ийн хувьд тэд GYALS хувийн эмнэлэгтэй хамтран ажиллаж, AI Bot-д 100 эмнэлгийн шинжилгээний үр дүнг сургаж хариултын нарийвчлалыг сайжруулсан.

Нийгмийн тулгамдсан асуудлуудыг зөв тодорхойлж, шийдвэрлэх арга барил нь оновчтой байсан гэж бид үзэж байгаа ч Data Med-ийн нэгэн адил зөвхөн нээлттэй өгөгдлийг ашиглан шийдлийг олоход хүндрэлтэй гэдгийг олж мэдсэн.



Зураг 180 Rookie System-ийн илтгэл

Medical test

100 гаруй өвчтөний
шинжилгээний мэдээлэл
болон эмчийн зөвлөмж

Зураг 181 Rookie Systems-ийн ашигладаг эмнэлгийн шинжилгээний үр дүн

Модератороор DX Mongolia-ийн Төгөлдөр ажиллаж хэлэлцүүлэг өрнүүлээ. Тухайн өдөр олон төрлийн оролцогчид оролцож, янз бүрийн санал бодлыг сонсох боломж гарах тул хэлэлцүүлэг хийх хүнийг тусад нь бэлдэлгүй хүн бүрийг оролцох боломжтой нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулахаар шийдсэн.

MDDIC-ээс нээлттэй мэдээлэлтэй холбоотой хууль эрх зүйн тогтолцоо бий болж, нээлттэй мэдээллийг хадгалах орон зай бий болсон тухай тайлбар хийв. Дараагийн шатанд засгийн газар болон хувийн компаниуд мэдээлэл оруулах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн.

МУИС -аас зөвхөн төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн саналыг зорилтот өгөгдөлд тусгах бус, олон талын мэдээлэл агуулсан цахим Монголоос нээлттэй болгох боломжтой өгөгдлийг

нээлттэй мэдээллийн платформд шилжүүлэхийг хүссэн.

ПоС-д оролцсон 2 компани онцлог зүйл компаниуд хоёулаа хиймэл оюун ухаан ашиглаж байсан явдал юм. Тиймээс суралцах нь заавал тоон мэдээлэлд тулгуурлах албагүй; текст эсвэл эмнэлгийн шинжилгээний үр дүн гэх мэт нарийн төвөгтэй мэдээлэл ч үнэ цэнэтэй байж болно. Иймд нээлттэй мэдээллийн тухай ойлголтыг өмнөхөөсөө илүү өргөжүүлэх шаардлагатай байж магадгүй талаар ярилцсан.

Үүнтэй холбогдуулан MDDIC- ээс "Түүхий өгөгдөл эсвэл боловсруулсан өгөгдөл (инфографик мэдээллийн хураангуйг оруулаад)

гаргах нь дээр үү?" гэсэн асуултыг тавьсан. MDDIC- ийн хувьд боловсруулсан өгөгдөл нь үнэ цэнэтэй гэж үзэж байсан бол (түүхий өгөгдлийг хадгалах нь MDDIC-д үнэ цэнэ нэмэхгүй), оролцогчдын дийлэнх олонхи нь түүхий мэдээлэл авах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн.

Төгсгөлд нь ноён Төгөлдөр энэ удаагийн хэлэлцүүлэг шиг салбар, төр, эрдэм шинжилгээний байгууллагуудын дунд нээлттэй мэдээллийг тасралтгүй хэлэлцүүлдэг форумын ач холбогдлыг тайлбарлаж, ажлын хэсэг байгуулах, мөн MDDIC-аас төсөв хуваарилах саналыг дэвшүүлэв. MDDIC-ийн н.Батзаяат ажлын хэсэг байгуулах тал дээр нааштай хандаж, санхүүгийн эх үүсвэрийг бодолцоно гэсэн хариултыг өглөө.



Зураг 182 Хэлэлцүүлгийн хэсэг

(г) Үнэлгээ

PP(5)-ийн тухайд урьдчилан таамаглаж байсан асуудлуудыг дараах байдлаар шийдвэрлэв.

Хүснэгт 111 PP(5) Хүлээгдэж буй асуудал ба шийдэх арга хэмжээ

Evaluation Item		Outcome	Anticipated Issues	Countermeasures
Achievement of Objective		Addressed	Ensuring a sufficient number of applicant companies and the realization of a certain number of prototype developments	Secured sufficient applicant companies and led to prototype development, allowing two companies to proceed to PoC.
Resources	Personnel	Resolved	Need to arrange mentors for engineers in addition to MDDIC	Coordinated with MDDIC, and so on, which provided e-Mongolia engineers as mentors.
	Costs	Resolved	Cost adjustments for co-hosting with MDDIC	Adjusted through meetings with MDDIC and other co-hosts, reaching general agreement on venue and mentor budgets, and executed within the initial budget.
	Operation Sub-contractor	Resolved	Need to arrange an appropriate local subcontractor for PoC support	Selected DX Mongolia, which has extensive PoC experience, as the subcontractor.
Preparation	Program Content	Resolved	Mismatch between data sought by private sector and data provided by government, and private sector was unable to	Proper understanding of private sector needs through pre-discussions with stakeholders

			conceive business ideas due to data-centric approach • There may not be a sufficient number of prototype developments. • Depending on the quality of the prototypes, it may not be possible to hold a matching event with investors.	• Prior notification to private companies about data formats on the open data portal • Unification of data formats used • Decided on event feasibility after meetings with the hackathon program managers at the MDDIC.
	Participation of Companies (Recruitment /Selection)	Resolved	• Possibility of insufficient number of applications	• Reviewed notification methods for the canceled hackathon hosted by MDDIC • Maximized use of effective notification methods and available networks.
Operations	-	Addressed	• Possible ambiguity in role distribution among mentors	• Coordinated with co-hosts in advance, ensuring appropriate mentor placement.
After Implementation	-	Addressed	• Potential criticism of ambiguous evaluation criteria	• Created a scoring sheet and established clear evaluation criteria.

Хакатоны дараа оролцогчдын дунд хакатоны талаарх санал хүсэлт, Монгол дахь нээлттэй мэдээллийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлын талаарх хэрэглэгчдийн байр сууринаас санал асуулга явуулсан. Үр дүнг доор харуулав.

Хүснэгт 112 Нээлттэй мэдээлэл хакатоны дараа оролцогчдын судалгааны үр дүн

1. Evaluation of This Hackathon Program					
Rating (5-point scale)	1	2	3	4	5
Number of Respondents	0	0	2	2	4

2. Self-Evaluation in This Hackathon Program					
Rating (5-point scale)	1	2	3	4	5
Number of Respondents	0	1	1	4	2

3. Did Mentoring and Lectures Support Prototype Development?					
Rating (5-point scale)	1	2	3	4	5
Number of Respondents	0	0	2	4	2

4. Was Five Days a Sufficient Period for Development?			5. Would You Participate in Other Open Data Hackathons?		
Yes	5		Yes	6	
No	3		I don't know.	2	

6. Was Early September a Suitable Time for the Hackathon?			7. Was the Venue Suitable for Hosting the Hackathon?		
Yes	5		Yes	8	
No	3		No	0	

8. Did You Know About Open Data Before Applying?			9. Was the Provided Data Sufficient for Prototype Development?		
Yes	3		Yes	2	
No	5		No	6	

10. Are the Currently Released Statistical and Time Series Data by the Government Valuable for Development?		
Yes	3	
No	5	

11. What Kind of Data Held by the Mongolian Government or Ulaanbaatar City Would You Like to Use?	
Early screening medical data	
Unprocessed data	
Data in API-accessible formats	
Public transportation data	
Stock market data (stock prices, raw market indicators, etc.)	
Personal data	
Niche data	

12. What Measures Do You Think Are Effective to Promote the Use of Open Data? (Multiple answers allowed)	
Diversification of data formats	6
Diversification of data types	6
Frequent hosting of hackathons and datathons	4
Introduction of overseas examples	3
Integration of open data portals	2

Дээрх судалгааны үр дүнгээс үзэхэд хакатон нь ерөнхийдөө сайн үнэлгээ авсан бөгөөд цаг хугацаа, зохион байгуулах газар болон зохион байгуулалтын бусад асуудалд ч ямар нэгэн асуудал гараагүй байна. Гэсэн хэдий ч оролцогчдод олгогдсон мэдээллийн төрөл, хэмжээ нь нээлттэй өгөгдлийг боловсруулахад хангалтгүй байсан гэсэн санал олон байсан. 10-р асуултад дурьдсанчлан статистикийн өгөгдөл болон цаг хугацааны тэнхлэгийн өгөгдөл нь нээлттэй өгөгдлийн хувьд бизнесийн хэрэглээнд тийм ч их ач холбогдолтой биш, харин 11-р асуултад дурдсанчлан, эмчилгээнд зориулсан зурган өгөгдөл, API-тай холбогдож болох өгөгдөл, нийтийн тээврийн мэдээлэл гэх мэт хялбархан холбогдох боломжтой өгөгдлүүд, мөн AI загварчлалд зориулсан том өгөгдөл болон бизнесд эрэлт хэрэгцээтэй 3 зүйл бол өгөгдлийн төрөл зүйл, өгөгдлийн формат болон хэмжээ гэдэг нь ойлгомжтой байна. Эдгээр хэрэгцээ шаардлагад нийцүүлэн Монголын нээлттэй мэдээллийн порталын сайжруулалт нь мэдээллийн төрөл, форматыг төрөлжүүлэх явдал мөн.

(д) Дэмжих талаар санал

Монгол Улсад нээлттэй мэдээллийн хэрэглээг дэмжихэд дэмжлэг үзүүлэх саналуудыг доор дурдлаа. Нээлттэй өгөгдөл нь мэдээлэл цуглуулах, цэвэрлэх, өгөгдлийг ашиглах, нийгмийн бодит асуудлыг шийдвэрлэх, төрийн үйлчилгээг сайжруулах хүртэлх олон үе шатыг хамардаг бөгөөд илүү гүнзгий ойлголт, практик хэрэглээнд хүргэхийн тулд бүх үе шатыг хамарсан иж бүрэн дэмжлэг шаардлагатай.

1. МХХТ-ийн хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх

- ✓ (Засгийн газар) Нээлттэй өгөгдлийг ашиглах хувийн хэвшлийн чадавхийг бэхжүүлэх хөтөлбөр боловсруулах: Төрийн байгууллагын ажилтнуудад зориулсан хувийн хэвшлийнхэн бас хэрэглэх мэдээлэл цуглуулах аргыг хөгжүүлэх, мэдээллийн форматыг оновчтой болгох, стандартчилах, портал график болон UI-г сайжруулах чадварыг хөгжүүлэх
- ✓ (Хувийн хэвшил) Бизнесийн ашиг тустай корпорацийн мэдээллийг задруулах кейс судалгааг гаргаж (Япон гэх мэт гадаадаас авсан жишээ, хувийн мэдээллийг нэрээ нууцлах арга гэх мэт) хувийн хэвшлийнхний мэдээллээ нээх сонирхлыг нэмэгдүүлэх (Лавлагаа болгох үүднээс гадаадад байгаа хувийн хэвшлийн мэдээллийг нээлттэй болгосон жишээг оруулав).

✓

Хүснэгт 113 Гадаад улс орнуудын хувийн хэвшлийнхний мэдээллийг нээлттэй болгосон жишээ

Newmont Corporation (Canada) *Formerly GoldCorp Inc.	In 2000, the company published its geological data on its website and held a contest called the "Gold Corp Challenge" with a cash prize, which allowed them to receive analysis results from a wide range of experts, leading to their growth into a major corporation.
Uber (USA)	In 2017, Uber launched "Uber Movement," making billions of anonymized traffic data from various cities available as open source for non-commercial purposes and reusable.
HealthData 29 (Spain)	The platform anonymizes medical data from patients in private hospitals nationwide and provides it free of charge to researchers. The development of the platform was supported by Microsoft's Open Data Campaign. *Open Data Campaign: An initiative led by Microsoft to promote the openness of data across industries, government, and academia, aiming to alleviate the concentration of data within a few companies or organizations and enabling all organizations, regardless of size, to utilize data and contribute to solving societal issues.

2. Төрийн үйлчилгээг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө/стратегийг боловсруулахад үзүүлэх дэмжлэг

- ✓ Монголын засгийн газрын PP(5)хакатон болон бизнесийн үзүүлэнгийн хөтөлбөрөөр дамжуулан хувийн компаниудын хэрэгцээ шаардлагыг судалсны дараа нээлттэй өгөгдлийг ашиглах бодлогыг тодорхойлох, бодлогын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлнэ.


3. Төр, хувийн хэвшлийн ажлын хэсэг байгуулах, ажиллуулахад дэмжлэг үзүүлж, хувийн хэвшилтэй харилцах суваг байгуулах боломжийг бүрдүүлэх

- ✓ (Засгийн газар) Хувийн хэвшлийнхэнтэй сургалт семинар зохион байгуулах: PP(5)-ийн үр дүнд тулгуурлан санал солилцох замаар хувийн хэвшлийн хэрэгцээг (өгөгдлийн ирээдүйтэй талбар, формат гэх мэт) тодорхойлох.

7-р бүлэг Стратеги боловсруулах

1. Монгол улс MDDIC-ийн МХХТ, цахим үйлдвэрлэл болон гарааны бизнес хөгжүүлэхэд тулгарах асуудал ба стратеги

Тус судалгаанд, Монгол улсын МХХТ, цахим үйлдвэрлэлийн хөгжил болон гарааны бизнесийг хөгжүүлэх үед шийдвэрлэх ёстой асуудал болон Монголын Засгийн газар болон ЖАЙКА-гийн дэмжлэгийн арга хэмжээний саналыг боловсруулсан. ЖАЙКА-гийн зарим дэмжлэгийн арга хэмжээний саналын тухайд 7-р бүлэгт танилцуулсанчлан туршилтын төслөөр тус судалгааны хүрээнд үр дүн нь батлагдсан. Дээр хэлэлцсэнийг үндэслэн, Монгол улсын МХХТ, цахим үйлдвэрлэлийн хөгжил болон гарааны бизнесийн хөгжил гэсэн зорилгыг хэрэгжүүлэхэд тулгарах асуудал болон Монгол улсын хэрэгжүүлэх ёстой арга хэмжээний саналын хамаарлыг доор харуулав.



Зураг 183 Монгол улсын МХХТ, цахим үйлдвэрлэлийн хөгжил болон гарааны бизнесийн хөгжил дэх асуудал ба арга хэмжээний санал

МХХТ, цахим үйлдвэрлэл болон гарааны бизнесийн хөгжил гэсэн зорилго нь, МХХТ-ийн хүний нөөц, компаний тоог өсгөх(хэвтээ тэнхлэг)ба том ба дунд хэмжээний компани, гарааны бизнесийн компаниудын борлуулалтын хэмжээг өсгөх(босоо тэнхлэг)гэсэн 2 чиглэлд хувааж бодож болно. МХХТ-ийн хүний нөөц хомс асуудлыг оюутнуудад МХХТ-ийн салбарт дэвшин суралцахыг сурталчлах мөн ажил эрхлэгчдийг дахин чавдаржуулах хөтөлбөрт хамруулах зэрэг хүний нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой. Мөн, хүний нөөцийн чанарыг дээшлүүлэхийн тулд үйлдвэрлэл, төр, их сургуулийн консорциум байгуулах болон дадлага хийлгэх хөтөлбөрт хамруулах зэрэг арга байна. Компанийн тоог нэмэгдүүлэх тухайд, их сургуулийн судалгаа хөгжүүлэлтийг чадавхижуулах болон бизнес эрхлэгчдийн боловсролыг хөгжүүлэх нь чухал арга болно.

Гарааны бизнесийг хөгжүүлэхэд, том компанитай холбоо тогтоох болон эрх зүйн орчин бүрдүүлэх, төр, хувийн хэвшлийн сан зэрэг санхүүгийн талын дэмжлэгийн схем бий болгох г.м. хэрэгтэй болно. Мөн, гадаадын том компанитай холбоо тогтоохыг дэмжих нэгэн арга болгож дотоодын РоС орчинг бүрдүүлэх нь ч бас үр дүнтэй байна. Том компани, гарааны бизнесээс үл хамааран нийтлэг асуудал гэвэл, МХХТ-ийн компаний таран хуваагдах, жижигрэн хуваагдах асуудал байна. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд ажлын хэсэг зэрэг сүлжээ бүрдүүлэх талбарыг хангаж өгснөөр хамтын ажиллагаа

болон хамтран ажилласнаар харилцан нөлөөлж том амжилт гаргах найдвар үүснэ. Мөн, дотоодын зах зээл хязгаарлагдмал байдаг болон гадаадын валют авахдаа ашигт малтмалаас хараат байдалтай байгаа нь ч компаниудын хөгжилд саад учруулах шалтгаан болж байна. Энэ асуудлын тал дээр засгийн газар хувийн хэвшилээс худалдан авалт хийх хэмжээг нэмэгдүүлэн дотоодын хэрэгцээг шинээр бий болгох, хувийн хэвшлийн гадаадад тэлэхэд нь дэмжлэг үзүүлвэл үр дүнтэй. Мөн, нээлттэй өгөгдлийн ашиглалтыг нэмэгдүүлснээр, шинэ зах зээл, үйлчилгээ бий болох найдвар байна.

2. ЖАЙКА-гийн Монгол улсын МХХТ, цахим үйлдвэрлэл болон гарааны бизнесийн хөгжилд үзүүлэх дэмжлэгийн арга хэмжээний санал

Өмнөх хэсэгт үзүүлсэнчлэн арга хэмжээний саналын олонхи хэсэгт ЖАЙКА-гийн дэмжлэгийг үзүүлэх боломжтой бөгөөд тодорхой дэмжлэгийн саналын талаар 4-р бүлэгт тайлбарласан байгаа. Энд сэдэв бүрийн дэмжлэгийн санал болон тус бүрийн дэмжлэгийн саналуудыг тэргүүлэх чиглэлийн дарааллын дагуу танилцуулна.


(1) Тэргүүлэх чиглэлийн дарааллын талаарх ойлголт

4-р бүлэгт мастер төлөвлөгөөг боловсруулах, МХХТ, цахим үйлдвэрлэлийг гадаадад тэлэх, МХХТ, цахим хүний нөөцийг хөгүүлэх, гарааны бизнесийн экосистемийг бий болгох, нээлттэй өгөгдлийн ашиглалтыг тэргүүлэх чиглэлүүд болгож ЖАЙКА-ийн дэмжлэгийн арга хэмжээний саналыг боловсруулсан. Эдгээр дэмжлэгийн сэдвүүдэд болон сэдэвүүд хооронд, сэдэв дотроо гэх мэтээр тэргүүлэх дарааллыг тодорхойлж, ЖАЙКА-ийн ажиллах дарааллыг богино хугацаа(1-2 жил дотор эхлүүлэх), дунд хугацаа(3-4 жилийн дотор эхлүүлэх), урт хугацаа(5-аас дээш жилийн дараа эхлүүлэх)-гаар хувааж ангилсан.

Сэдвүүд хоорондын эрэмбэ дарааллын хувьд, Монголын Засгийн газраас хүсэлт ирүүлсэн эсэхээр үнэлсэн. Сэдэв доторх эрэмбэ дарааллын хувьд (1)Бусад дэмжлэгийн саналтай харьцуулахад дэмжлэгийн нөлөөлөл болон (2)Дэмжлэг үзүүлэхэд хялбар амар байх(нэмэлт нөөцийн шаардлагатай эсэх болон хэмжээ)-гээр үнэлсэн. Дэмжлэгийн сэдвийн хувьд эрэмбэ дараалал дээгүүрх сэдвийг дотор нь тус бүрийн дэмжлэгийн арга хэмжээг авч үзэхдээ, (1) Дэмжлэгийн нөлөөллийг илүү чухал гэж үзсэн ба, эрэмбэ дараалалын хувьд доогуур сэдвийн тухайд (2)-н дэмжлэгийн хялбар байдлыг илүү чухалчилж тус бүрийн дэмжлэгийн саналын эрэмбэ дарааллыг тогтоосон.

Дэмжлэгийн сэдвүүдийн дотроос, гадаадад тэлэх болон гарааны бизнесийн экосистемийг бий болгохын тухайд Монголын Засгийн газраас ЖАЙКА-д хүсэлт гаргасан тул, бусад сэдвүүдтэй харьцуулахад эрэмбэ дараалалыг нь өндөр гэж үнэлсэн. Эдгээр нь дэмжлэгийн нөлөөлөл их, их чухал арга хэмжээнээс эхлүүлэхийг санал болгоно. Мөн, хүсэлт ирүүлээгүй сэдвүүд болох хүний нөөцийг хөгжүүлэх, нээлттэй өгөгдлийн ашиглалтын тухайд нэмэлт нөөцийн зарцуулалгүй дэмжиж болохоор зүйлийг нь шууд эхлүүлж, нэмэлт нөөц шаардлагатай дэмжлэгийн хувьд Монголын Засгийн газартай хэлэлцсэний үр дүнд, дунд урт хугацааны дэмжлэгийн төлөвлөгөө, хэрэгжүүлэлтийн саналыг дэвшүүлнэ.

Мөн, мастер төлөвлөгөөг боловсруулахыг судалгааны тэргүүлэх чиглэлүүд гэж үнэлсэн боловч, Монголын Засгийн газраас хүсэлт ирүүлсэнгүй. Монголын Засгийн газар ч хөгжлийн стратеги боловсруулж түүний дагуу холбогдох талуудыг оролцуулан төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн чухлыг ойлгож байгаа боловч, МХХТ-ийн үйлдвэрлэлийн салбарын технологийн дэвшил болон чиг хандлагын өөрчлөлтийн хурд, мөн Монголын Засгийн газрын арга хэмжээ авч ажиллах хурд зэргийг бодвол, дунд урт хугацааны төлөвлөгөөг үр ашигтай хэрэгжүүлж чадахгүй байх магадлалтай байгаа тул, хамгийн уртдаа 2-3 жил орчмын төлөвлөгөө байх нь ашигтай гэсэн бодолтой байгаагаа илэрхийлэхээс гадна 5-10 жил орчмын мастер төлөвлөгөө хийх хүсэлт ирүүлсэнгүй. Мөн, мастер төлөвлөгөөг боловсруулах сэдэв дотор дэмжлэгийн саналын тоо 1 байсан тул, сэдвийн дотор эрэмбэ дараалал тогтоосонгүй.



Зураг 184 Сэдэв хооронд болон сэдэв доторх эрэмбэ дарааллыг шийдвэрлэх арга

Сэдэв тус бүрийн доторх эрэмбэ дарааллыг дараах байдлаар тогтоохыг санал болгож байна. Сэдэв тус бүрийн нарийвчилсан тайлбарыг (2)-(5)-д оруулна.

Хүснэгт 114 Дэмжлэгийн арга хэмжээний санал : МХХТ, цахим үйлдвэрлэлийг дэмжих (МХХТ • цахим үйлдвэрлэлийн гадаадад тэлэх)

Зүйл	Асуудал	Дэмжлэгийн агуулга				Дэмжлэгийн эрэмбэ дараалал		
		Дэмжлэгийн цэс	Гол үйл ажиллагаа	Таамагла сан схем	Түнш	Дэмжлэгийн нөлөөлөл	Дэмжлэгийн амар хялбар байдал	Эрэмбэ дараалал
Цахим худалдааны тэнцэл	- Гадаадын компаниуд г.м.-тэй сүлжээ хангалтгүй - Гадаадын зэх зээлд гарч бизнес эрхлэхэд санхүүжилт дутагдалтай - МХХТ-ийн хүний нөөц хомс - Монголын МХХТ-ийн бренд дэлхийд танигдаагүй - МХХТ-тай холбоотой статистикийн мэдээлэл хангалттай биш	Монголын МХХТ, цахим үйлдвэрлэлийн гадаадад тэлэхэд дэмжих тогтолцоог бий болгох	- Монголын МХХТ, цахим үйлдвэрлэлийг гадаадад тэлэхийг дэмжихтэй холбоотой ажлын хэсэг байгуулах, менежмент - Төр, хувийн хэвшил нэгдэж гадаадад тэлэхийг дэмжих арга хэмжээг хэлэлцэх, мониторинг хийх, үнэлгээ хийх	Техникийн хамтын ажиллагааны төсөл	MDDIC, MT парк	Их	Дунд зэрэг	Богино хугацаа
		Монголын МХХТ, цахим үйлдвэрлэлийг гадаадад илүү сайн таниулах	Монголын МХХТ, цахим үйлдвэрлэлийн гадаадад илүү сайн таниулах зорилгоор брендинг стратеги болон нэгдсэн хэрэгслийг боловсруулах(J-Startup-н арга хэмжээнээс санаа аваад)			Их	Дунд зэрэг	Богино хугацаа
		Монголын МХХТ, цахим үйлдвэрлэлийн гадаадад тэлэхэд хувь нэмэр оруулах хүний нөөцийг бэлтгэх	Технологи, бизнесийн хоёр талын сургалтаар дамжуулан, Монголын МХХТ, цахим үйлдвэрлэлийн гадаадад тэлэхэд хувь нэмэр оруулах хүний нөөцийг бэлтгэнэ.			Их	Дунд	Богино хугацаа
		Монголын МХХТ, цахим үйлдвэрлэл ба гадаадын экосистемтэй хамтрахыг дэмжих	Экосистемийн харилцан холболттой холбогдох MoU байгуулах(гарааны бизнесүүд харилцан бие биенийхээ бүс нутаг дээрх тэлэлтийг дэмжих г.м.), Японд урьж авчрах, бизнесийн тохируулга хийх зэргээр Монголын МХХТ, цахим үйлдвэрлэл болон гадаадын экосистемтэй хамтрахыг дэмжинэ.			Их	Дунд зэрэг	Богино хугацаа

		Монголын МХХТ, цахим үйлдвэрлэл(ялангуяа гадаад орнуудтай бизнес хийх)-тэй холбоотой статистик мэдээллийг бүрдүүлэх	Монголын МХХТ, цахим үйлдвэрлэл(ялангуяа гадаад орнуудтай бизнес хийх)-тэй холбоотой статистик мэдээллийг бүрдүүлнэ.		Үндэсний статистикийн хороо, Монголын төв банк MDDIC, МТ парк	Бага:	Хялбар	Дунд хугацаа
--	--	--	---	--	---	-------	--------	--------------

Хүснэгт 115 Дэмжлэгийн арга хэмжээний санал: МХХТ, цахимын хүний нөөцийг хөгжүүлэх

Зүйл	Асуудал	Дэмжлэгийн агуулга				Дэмжлэгийн саналуудын эрэмбэ дараалал		
		Дэмжлэгийн цэс	Гол үйл ажиллагаа	Таамагласан схем	Түнш	Дэмжлэгийн нөлөөлөл	Дэмжлэгийн хялбар байдал	Эрэмбэ дараалал
МХХТ-ийн хүний нөөцийн хэмжээ	МХХТ-ийн хүний нөөцийн дутагдал. Шалтгаануудыг доор дурдав. - Оюутнууд: МХХТ-ийн салбарт дэвшин суралцах сонирхолтой болгох боломж хязгаарлагдмал - Ажил эрхлэгчид: Ажил эрхлэгчдийг дахин чадваржуулах хөтөлбөр байхгүй	МХХТ-ийн салбарт дэвшин суралцахыг сурталчлах	- Их сургууль эсвэл Коосэнд дэвшин суралцах гэж буй сурагчдад зориулж МХХТ-ийн салбарт дэвшин суралцахыг сурталчилсан контент хийх болон үйл ажиллагааг идэвхжүүлэх ※Export Strategy 2.1.3. Conduct school awareness programmes to expand interest in IT jobs-тай хамтран ажиллах	Техникийн хамтын ажиллагааны төсөл	Боловсрол, шинжлэх ухааны яам	Их	Дунд	Дунд хугацаа
		Оюутнуудад ажилд орох боломж олгох / ААН-д хүний нөөцийг олж авах боломжийг олгох	Ажлын семинар(тус судалгааны РР(2))-г үзэх	-(Тухайн орны байгуулгад шилжүүлэх)	МОЈС	Бага:	Хялбар	Богино хугацаа
		Ажил эрхлэгчдэд зориулсан дахин чадваржуулах хөтөлбөрийг хөгжүүлэх	- Засгийн газраас ажил эрхлэгчдэд зориулсан МХХТ-ийн дахин чадваржуулах хөтөлбөр болон түүнийг зохион байгуулах тогтолцоог бий болгоход нь дэмжлэг үзүүлэх - Дахин чадваржуулах хөтөлбөрийг зохион байгуулах боломжтой байгуулгад засгийн газраас дэмжлэг үзүүлэх схемийг бий болгоход нь дэмжлэг үзүүлэх	Техникийн хамтын ажиллагааны төсөл	Боловсролын яам	Бага:	Хэцүү	Урт хугацаа

МХХТ-ийн хүний нөөцийн чанар	МХХТ-ийн хүний нөөцийн чанар доогуур байна. Шалтгаануудыг доор дурдав. • Оюутнууд: Практик ур чадварыг эзэмших боломж муутай • Багш нар: Чанартай багш нар цөөн Ажил эрхлэгчид: Компани дотроо дахин чадваржуулах хөтөлбөр байхгүй	Хувийн хэвшил, төр, их сургуулийн консорциум болон практик сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх	1-р алхам • Хувийн хэвшил, төр, их сургуулийн консорциумыг байгуулж удирдлагын тогтвортой тогтолцоог бий болгоно ※Export Strategy 2.1.5. Establish a Public-Private IT Skill Development Council and conduct periodic meetings-тай хамтран ажиллах 2-р алхам • Хувийн хэвшлүүдийн саналыг оролцуулсан сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх тогтолцоог бий болгох • Хувийн хэвшил, их сургуулийн хамтарсан төслийг хэрэгжүүлэхийг дэмжих	Техникийн хамтын ажиллагааны төсөл	MDDIC, Эдийн засгийн хөгжлийн яам, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Боловсролын яам, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам	Их	Хялбар (※)	Богино хугацаа (※)
		Оюутнуудад зориулсан тэмцээн зохион байгуулах	• DX CUP(Тус судалгааны РР④)-г үзэх	- (Монголын байгуулгад шилжүүлэх)	DX Mongolia	Дунд	Хялбар	Богино хугацаа
		(Багш нарын хомсдолыг арилгахад авах арга хэмжээ)Японд суралцах/дадлагын хөтөлбөрийг бий болгох	• Японд суралцах/дадлагын хөтөлбөрийг бий болгох(Багш нарын хомсдлыг арилгах арга хэмжээ)	Урт хугацааны сургалт	Боловсролын яам	Дунд зэрэг	Дунд зэрэг	Дунд хугацаа
		(Багш нарын хомсдлыг арилгах арга хэмжээ)Японоос онлайнаар хичээл заах тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлэх	• Хамтран ажиллах их сургуультай болох, Монголын дотоодын их сургуулиас онлайнаар хичээл заах тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлэх	Техникийн хамтын ажиллагааны төсөл	Боловсролын яам	Дунд	Дунд	Дунд хугацаа

※Нөлөөлөл ихтэй, хялбар эхлүүлж чадах зэргийг үнэлж эхний алхамд аж үйлдвэр, их сургуулийн консорциум байгуулахыг шийдсэн.

Хүснэгт 116 Дэмжлэгийн арга хэмжээний санал: Гарааны бизнесийн экосистемийг үүсгэн байгуулах

Зүйл	Асуудал	Дэмжлэгийн агуулга				Дэмжлэгийн агуулгын эрэмбэ дараалал		
		Дэмжлэгийн цэс	Гол үйл ажиллагаа	Таамагла сан схем	Түнш	Дэмжлэгийн нөлөөлөл	Дэмжихэд хялбар байдал	Эрэмбэ дараалал
【Хүний нөөц】 Бизнес эрхлэгч хүний нөөцийн боловсрол	Бизнес эрхлэхтэй холбоотой дэмжлэг үзүүлж байгаа боловч, том үр дүн гарах болоогүй. Инноваци болон бизнэс эрхлэхтэй холбоотой чанар сайтай хөтөлбөрийг хэрэгжүүлэх боловсролын байгууллага ховор	Их сургуультай хамтарсан бизнес эрхлэгчийн боловсролын хөтөлбөр	• Монголын дотоодын боловсролын байгуулгатай хамтран бизнес эрхлэгчийн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Техникийн хамтын ажиллагааны төсөл	Боловсролын яам, МТ парк	Дунд	Хялбар	Богино хугацаа
		Гадаадын гарааны бизнесийн экосистем рүү хүний нөөцийг илгээх(Японыг оролцуулан)	• Гарааны бизнесийн экосистем нь хөгжсөн орны бизнэс эрхлэгч/их сургуульд илгээх Мөн инкубатарын байгууламж болон эвэнт арга хэмжээ зэрэгт оролцох хөтөлбөрийг хэрэгжүүлэх			Дунд	Хялбар	Богино хугацаа
【Эд зүйлс】 Том зах зээлд гарах, гадаадад тэлэх стратеги	• Гарааны бизнес нь гадаадад тэлэх хэмжээнд хүртэл хөгжөөгүй • Гадаадад тэлэхэд хангалттай чадвартай дэмжигч байхгүй	Чанарын хандлага: Төв ази эсвэл зүүн өмнөд азийн зах зээлд гарахыг дэмжих өргөн хүрээний хурдасгуур	• Монголын гарааны бизнесийг тэлэх гол газар болох Төв ази болон Зүүн өмнөд ази руу тэлэхийг дэмжих хурдасгуурын хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Техникийн хамтын ажиллагааны төсөл	MDDIC, МТ парк	Их	Хялбар	Богино хугацаа
		Тоон хандлага : Үрсэлгээний бэлтгэл шат болон үрсэлгээний шатан дахь гарааны бизнесийг хамруулсан хурдасгуур хөтөлбөр	• Үрсэлгээний шатны гарааны бизнесийн тоог өсгөхийг зорьж одоогийн MONJA-г үргэлжлүүлнэ			Их	Хялбар	Богино хугацаа

【Хөрөнгө】 Дотоодын хөрөнгө оруулагчдын эрсдлийн хөрөнгө нийлүүлэлт	Гарааны бизнесд оруулах хөрөнгийн хэмжээ хангалтгүй байна. Асуудал нь дараах 2 байна	2 үе шаттай хөрөнгө оруулалттай иений хөнгөлттэй зээлийн төсөл	• Түнш-д иений хөнгөлттэй зээлийг олгож, тэр нь Венчур компани болон банканд хөрөнгө оруулалт хийнэ.	Иений хөнгөлттэй зээлийн хамтын ажиллагаа (иений хөнгөлттэй зээл)	Сангийн яам	Их	Хэцүү	Дунд хугацаа
	• Засгийн газрын чиглэлийн байгуулагаас хөрөнгийн нийлүүлэлт байхгүй (зөвхөн мөнгөн тусламж) • Хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдын тоо хангалтгүй	Хөрөнгө оруулагчдын боловсрол	• Ангел хөрөнгө оруулагчдын клуб зэрэгтэй хамтран ажиллаж Ангел хөрөнгө оруулагчдад зориулсан боловсролын хөтөлбөрийг зохион байгуулна. Гарааны бизнесийн хөрөнгө оруулалтын эрсдэл, үнэ цэнийн үнэлгээний ойлголтын талаарх контенттэй байхаар таамаглаж байна.	- Техникийн хамтын ажиллагааны төсөл - Хөнгөлттэй зээлийн тусламж үзүүлэх хамтын ажиллагаа (иений хөнгөлттэй зээл)	MDDIC, Сангийн яам, IT Park	Их	Хэцүү	Дунд хугацаа
【Санхүү】 Гадаадын хөрөнгө оруулагчдын эрсдлийн хөрөнгийг нийлүүлэх	Монголын гарааны бизнесийг сонирхох гадаадын хөрөнгө оруулагчид цөөн, хөрөнгийн хэмжээ хангалттай биш	Төр, хувийн хэвшлийн сан байгуулах, удирдлагын дэмжлэг	• Монголын Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан санхүүжилтээр сан байгуулахыг дэмжих • ЖАЙКА-гаас Монголын Засгийн газарт хөрөнгө оруулалтын зардалд зориулж иенийн зээл олгоно • Хөрөнгийн хэмжээг өсгөх болон, хөрөнгө оруулалтыг татахыг зорилго болгох	Хөнгөлттэй зээлийн тусламж үзүүлэх хамтын ажиллагаа (иений хөнгөлттэй зээл)	Сангийн яам	Их	Хэцүү	Дунд хугацаа
【Хөрөнгө】	• Хувийн хэвшил нь, хөрөнгө	Төр, хувийн хэвшлийн сан	• Монголын Засгийн газар болон хувийн	Хөнгөлттэй	Сангийн яам	Их	Хэцүү	Дунд хугацаа

Олон янзын байдал(хөрөнгө оруулалт)	оруулагч нь зөвхөн Ангел, Венчур компани, бизнесийн компани бөгөөд Вечур компани нь зөвхөн 1 компани тул цөөн байна Засгийн газраас хөрөнгө нийлүүлэх, санхүүжилт хийсэн удаа байхгүй	байгуулах, удирдлагын дэмжлэг	хэвшлийн хамтарсан санхүүжилтээр сан байгуулахыг дэмжих - ЖАЙКА-аас Монголын Засгийн газарт хөрөнгө оруулалтын зардлын зориулалтаар иений хөнгөлттэй зээл олгох - Үндсэн хөрөнгийн хэмжээг өсгөх болон, хөрөнгө оруулалт татахыг зорилго болгох	зээлийн тусламж үзүүлэх хамтын ажиллагаа (иений хөнгөлттэй зээл)				
【Хөрөнгө】 Олон янзын байдал(санхүүжилт)	- Гарааны бизнэсд санхүүжилт хийх банк бараг байхгүй - Санхүүжилтийн талаарх Засгийн газрын оновчтой дэмжлэг байхгүй	Монголын Засгийн газрын гарааны бизнесийг санхүүжүүлэх механизмыг бий болгоход дэмжих (Хоёр шатлалтай зээлийн иений хөнгөлөлттэй зээлийн төсөл)	Японы Санхүүгийн Корпорацийн схемийг Монголд нэвтрүүлэх - Санхүүжилтэд шаардлагатай хөрөнгийг хоёр шатлалттай зээлээр иений хөнгөлөлттэй зээлийг олгох	Хөнгөлттэй зээлийн тусламж үзүүлэх хамтын ажиллагаа (иений хөнгөлттэй зээл)	Сангийн яам	Их	Хэцүү	Дунд хугацаа
【Санхүү】 Олон янзын байдал(мөнгөн тэтгэмж)	Гарааны бизнесд зориулсан Засгийн газар болон хөгжлийн байгууллагаас олгох мөнгөн тэтгэмж бараг байхгүй, гарааны бизнесийн санхүүжүүлэлтийн арга хязгаарлагдмал	Ивээн тэтгэгчээс мөнгөн тэтгэмж олгох хөтөлбөрийг зохион байгуулах	Гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрөөр(өргөн цар хүрээтэй хурдасгуур, MONJA г.м.)ивээн тэтгэгчдийн сонирхолыг татаж гарааны бизнесд мөнгөн тэтгэмж олгох	Техникийн хамтын ажиллагааны төсөл	IT Park	Дунд зэрэг	Хялбар	Богино хугацаа
【Бодлого хууль】	STF: Татаасын тухай заасан	Гарааны бизнесд холбоотой хууль	Гарааны бизнесийн тухай хууль	Техникийн хамтын	MDDIC/Эдийн засгийн	Их	Дунд	Богино хугацаа

тогтоомж】	хууль. Бусад орнуудын ДНБ-д эзлэх хувьтай харьцуулж үзэхэд, мөнгөн дүн хангалтгүй • Хөрөнгө оруулалтын тухай хууль: Хөрөнгө оруулагчдад үзүүлэх албан татварын хөнгөлөлт хангалтгүй • Инновацийн тухай хууль: Гарааны бизнесд зориулсан албан татварын хөнгөлт байгаа ч, гарааны бизнесийн тухай тодорхойлолт явцуу, хамрах хүрээ хязгаарлагдмал	тогтоомжын зохицуулалтыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх	боловсруулахад дэмжлэг үзүүлэх • Эсвэл, хөрөнгө оруулагчид зэрэгт хөрөнгө оруулалт хийснээрээ татвараас чөлөөлөгдөх арга хэмжээ зэрэг урамшуулал бий болгох, хатуу чанга зохицуулалтыг зөөлрүүлэх г.м.-г судлах • Дээрхтэй холбогдох ажлын хэсгийг байгуулах, ажиллуулах	ажиллагааны төсөл	хөгжлийн яам			
【Сүлжээ】	• Гадаадын экосистемтэй холбогдох харилцаа ховор, гадаадад тэлэх суурийг SU-д нийлүүлж чадахгүй байна	Гадаадын хурдасгуур, MONJA зэргээр дамжуулан тухайн газрын хурдасгууртай сүлжээ тогтоох	• Дээрх өргөн цар хүрээний хурдасгуурын хөтөлбөрийг зохион байгуулах үед, тухайн газрын хурдасгууртай хамтран ажиллаж, сүлжээг бүрдүүдэх	Техникийн хамтын ажиллагааны төсөл	• MDDIC • МН парк	Их	Хялбар	Богино хугацаа

Хүснэгт 117 Дэмжлэгийн арга хэмжээний санал: Нээлттэй өгөгдлийг ашиглах(Нээлттэй өгөгдөл, өгөгдлийн холболт)

Зүйл	Асуудал	Дэмжлэгийн агуулга				Эрэмбэ дараалал		
		Дэмжлэгийн цэс	Гол үйл ажиллагаа	Таамагла сан схем	Түнш	Дэмжлэгийн нөлөөлөл	Дэмжлэг үзүүлэх хялбар байдал	Эрэмбэ дараалал
【Нээлттэй өгөгдөл】 Нээлттэй өгөгдлийн чиглэлийг боловсруулах: Ажилтнуудын ур чадвар	- Техникийн ажилтнуудаас бусад ажилтнуудын ур чадвар доогуур байна - Нээлттэй өгөгдлийн чухал байдлыг ойлгох нь удирдлага болон нэг хэсгийн ажилтнуудад хязгаарлагдаж байна	Нээлттэй өгөгдлийг ашиглах чадавхийг хөгжүүлэх хөтөлбөр	Нээлттэй өгөгдөл болон түүнийг ашиглах аргын талаар мэдлэг олж авах сургалтыг зохион байгуулах	Техникийн хамтын ажиллагааны төсөл	MDDIC、Орон нутгийн захиргаа	Дунд	Хялбар	Богино хугацаа
【Нээлттэй өгөгдөл】 Түүхий өгөгдөл цуглуулах: Өгөгдлийн багцын хэмжээ	- Нээлттэй өгөгдлийн ихэнх нь статистикийн өгөгдөл бөгөөд одоогоор олон төрлийн өгөгдөл байхгүй - Захиргааны байгуулга нь орон нутгийн захиргаа хамтран мэдээллийн төрөл зүйлийг тодорхойлох, судлах ажил хангалтгүй байна		- Өгөгдөл цуглуулах ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх (Жишээлбэл: бодит цагийн өгөгдлийг олж авах чадавхийг дээшлүүлэх г.м.) - Хувийн хэвшилд хэрэгтэй өгөгдлийн багцыг бүрдүүлэх	Техникийн хамтын ажиллагааны төсөл	MDDIC、бусад порталын удирдлагын яам газрууд	Их	Хэцүү	Богино хугацаа
【Нээлттэй өгөгдөл】 Нээлттэй өгөгдлийн порталыг хөгжүүлэх: Өгөгдлийн каталог байгаа эсэх ба чанар	- Хэрэгтэй өгөгдлийг олж авахад төвөгтэй - Харагдац нь сонирхол татахуйц биш - Хэлний хязгаарлалт - Өгөгдлийн формат хязгаарлагдмал - Өгөгдлийг шинэчлэх дамтамж цөөн		- Өгөгдлийн багцын форматыг боловсруулах, чанаржуулах - Урьдчилж боловсруулсан ашиглахад дөхөмтэй өгөгдлийг бүрдүүлэх - OD (Organization Development - байгууллагын хөгжил)порталын график зэрэг UI (User Interface)-г сайжруулах	Техникийн хамтын ажиллагааны төсөл	MDDIC、Бусад порталын удирдлагын яам газрууд	Дунд	Дунд	Богино хугацаа

【Нээлттэй өгөгдөл】 Хувийн хэвшилүүд дэх нээлттэй өгөгдлийн хоёрдогч ашиглалт: Хувийн хэвслүүдтэй харилцах харилцаа	- Нээлттэй өгөгдөл байгаа, түүний чухал хэрэгтэйг хувийн хэвшлийн компаниуд ойлгоогүй байна - Өгөгдлийн багцын хэмжээ, чанар аль нь ч хангалтгүй бөгөөд ашиглахад дөхөмтэй биш		- Хувийн хэвшилд зориулж ажлын семинар зохион байгуулах(Засгийн газар нь хувийн хэвслүүд дэх өгөгдлийн хэрэгцээг судлаж олж авахыг хичээж, хувийн хэвслүүд нь төр мэдээллийг нээлттэй болгож түгээж байгааг ойлгох ойлголтоо гүнзгийрүүлнэ) - Хакатон шиг РР(5)ын арга хэмжээг хөгжүүлэх(Жишээлбэл: Асуудлыг өөрчилж Хакатонг дахин зохион байгуулах г.м.)	Техникийн хамтын ажиллагааны төсөл	MDDIC	Их	Хялбар	Богино хугацаа
【Өгөгдлийн холболт】 Яам газар, орон нутгийн захиргаа бүрийн үндсэн системийн судалгаа	Орон нутгийн болон төвийн өгөгдлийн дэд бүтэц өөр өөр тул өгөгдлийн ашиглалтын ачаалал нэмэгдэж байна	Өгөгдлийн холболтын дэд бүтцийг бэхжүүлэхэд чиглсэн хөтөлбөр	Яам газрууд, орон нутгийн захиргаа бүрийн үндсэн системийн бодит байдлыг үндэслэн, өгөгдлийн холболтын дэд бүтцийн зураг төсөл зохиох	Техникийн хамтын ажиллагааны төсөл	MDDIC	Бага:	Хялбар	Богино хугацаа
【Өгөгдлийн холболт】 Яам газруудыг дамнасан(орон нутгийн захиргааг оролцуулан)өгөгдлийн холболтын дэд бүтцийг бий болгоно	-		- Яам газар, орон нутгийн захиргааны эзэмшиж байгаа өгөгдлийг холболтын дэд бүтцэд оруулах - Яам газар, орон нутгийн захиргаа нь өгөгдлийн холболтын дэд бүтцэд орсон бусад байгууллагуудын өгөгдлийг ашиглах тогтолцоог бий болгох	Техникийн хамтын ажиллагааны төсөл	ХҮР-ын удирдлагын яам газрууд	Дунд	Дунд	Богино хугацаа

【Өгөгдлийн холболт】 Хувийн хэвшлийн тодорхой аж үйлдвэрийн өгөгдлийн холболт(Уул уурхай, санхүү зэрэг)	Хувийн хэвшлийн компаниуд өгөгдлөө өгдөггүй тул хувийн хэвшлийн компаниудын эзэмшдэг өгөгдлүүд ашиглагдахгүй байна		- Өгөгдлийн холболтыг хөгжүүлэх тодорхой аж үйлдвэрийг сонгох - Өгөгдлийн холболтыг гүйцэтгэх хувийн хэвшлийн компаниудыг бүртгэж авч, сонгох - Өгөгдлийн холболтод хамруулах өгөгдлийн төрөл зүйлсийг тогтоох - Дата холболтын дэд бүтэц г.м. өгөгдлийн хамтын эзэмшлийн платформыг байгуулах	Техникийн хамтын ажиллагааны төсөл	MDDIC	Их	Хэцүү	Дунд хугацаа
【Өгөгдлийн холболт】 Хувь хүний мэдээлэлтэй харьцах	-		- Хувь хүний мэдээлэлтэй харьцах тухай хуулийг боловсруулах - Тус хуулийн дагуу, хувь хүний мэдээлэлтэй харьцах тухай дүрэм журмыг тогтооно(ялангуяа нэрээ нууцлах гэх мэт хуульд нийцсэн гол нөхцлийг зааж хэрэгжүүлнэ)	Техникийн хамтын ажиллагааны төсөл	ХҮР-ын удирдлагын яам газрууд	Бага:	Хэцүү	Урт хугацаа

(2) МХХТ, цахим үйлдвэрлэлийг дэмжих (МХХТ · цахим үйлдвэрлэлийн гадаадад тэлэх)

Монголыг ашигт малтмалын хараат байдлаас гарахад чиглүүлэн дараагийн аж үйлдвэрийн тулгуурыг бий болгох нь өгөгдсөн сэдэв болоод байгаа бөгөөд МХХТ, цахим үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд ялангуяа гадаадад тэлснээр гадаад валютыг олж авах нь сэдэв болно. Мөн, МХХТ, цахим үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь, зөвхөн гадаад валютыг олоод зогсохгүй, өөрийн орны цахимтай холбоотой үйлчилгээг худалдан авснаар гадаадад төлбөр хийхийг багасгаж, дунд урт хугацаагаар цахим худалдааны алдагдлыг багасгахад хувь нэмэр оруулж чадна.

МХХТ, цахим үйлдвэрлэлийг гадаадад тэлэх үеийн асуудал гэхэд, гадаадын компаниудтэй сүлжээ холбоо байхгүй, гадаадад тэлэх хөгжлийн хөрөнгө хангалтгүй, МХХТ-ийн хүний нөөц хомс, Монголын МХХТ-ийн бренд хангалттай танигдаагүй, МХХТ-ийн үйлдвэрлэлийн тухай статистикийн мэдээлэл хангалтгүй зэргийг дурдаж болно. Эдгээр асуудлууд хоорондоо хамааралтай дээр нь, дэмжлэгийн бодлого нь тогтолцоогоо байгуулахаас эхлээд төрөл бүрийн бодлого хэрэгжүүлэх хүртэл нэг багцаар хөгжүүлэх нь үр ашигтай бөгөөд үр дүнтэй гэж бодогдож байна.

Тиймээс, "Хүснэгт 122 Дэмжлэгийн арга хэмжээний санал: МХХТ, цахим үйлдвэрлэлийг хөгжүүлэх(МХХТ, цахим үйлдвэрлэлийг гадаадад тэлэх)-д дурдсанчлан, (1)Монголын МХХТ, цахим үйлдвэрлэлийн гадаадад тэлэхэд нь дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгох,(2)Монголын МХХТ, цахим үйлдвэрлэлийг гадаадад улам таниулах, (3)Монголын МХХТ, цахим үйлдвэрлэлийн гадаадад тэлэхэд хувь нэмэр оруулах хүний нөөцийг бэлтгэх, (4)Монголын МХХТ, цахим үйлдвэрлэл болон гадаадын экосистемийн холболтыг хөгжүүлэх, (5)Монголын МХХТ, цахим үйлдвэрлэл (ялангуяа гадаадынхантай арилжаа хийх)-тай холбоотой статистик мэдээллийг бүрдүүлэх гэсэн 5 арга хэмжээг багтаасан техникийн хамтын ажиллагааг санал болгоно. Мөн, энэ 5 зүйлээс, (1)ээс(4) нь ялангуяа Монголын Засгийн газар, компаниудын хэрэгцээнд нийцэх арга хэмжээ мөн бөгөөд, "дэмжлэгийн нөлөөлөл" нь "их", "эрэмбэ дараалал" нь "богино хугацаа"-ны байр суурьтай байгаа ба (5)-ын тухайд НҮБ-ын тогтоосон Олон улсын стандартын дагуу ажиллах хэрэгтэй тул, "дэмжлэгийн нөлөөлөл" нь "бага", "эрэмбэ дараалал" нь дунд хугацаа" гэсэн байр суурийг эзлүүлсэн.

(3) МХХТ, цахимын хүний нөөцийг хөгжүүлэх

Тус сэдэв нь Монголын Засгийн газраас хүсэлт ирүүлээгүй, нийт сэдвийн эрэмбэ дараалал нь гадаадад тэлэхийг дэмжих болон гарааны бизнесийн экосистемийг бий болгохтой харьцуулахад хойшлуулагдах асуудал юм. Тиймээс, дэмжлэг үзүүлэхэд хялбар байдал(нэмэлт эх үүсвэр шаардлагатай эсэх болон хэмжээ)-г чухалчилж эрэмбэ дарааллыг тодорхойлсон.

(а) МХХТ-ийн хүний нөөцийн хэмжээ

МХХТ-ийн салбарт дэвшин суралцах оюутнуудын тоог нэмэгдүүлэх сурталчилгааны үйл ажиллагаа нь цаашдын МХХТ-ийн хүний нөөцийг ихээр нэмэгдүүлэхийн хувьд дэмжлэгийн нөлөөлөл ихтэй юм. Нөгөөтэйгүүр, ЖАЙКА-аас дэмжлэг үзүүлэх тохиолдолд сурталчилгааны контентыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх болон сурталчилгааны чадварыг бэхжүүлэх зэрэг нэмэлт эх үүсвэр хэрэгтэй болно. Тиймээс дэмжлэг үзүүлэх хялбар байдал нь дунд, эрэмбэ дарааллыг "дунд хугацаа"-гаар хийх үйл ажиллагаа гэсэн байрыг эзлүүлсэн.

Ажлын семинарийн тухайд тус төслийн хүрээнд Япон фестивалын зохион байгуулах газар болох Нарны Наадамд хариуцуулахаар төлөвлөж туршилтын төслийг хэрэгжүүлсэн. Дэмжлэгийг хүртэх нь зөвхөн арга хэмжээнд оролцогчид болох тул дэмжлэгийн нөлөөлөл бага гэж үнэлсэн боловч, нэмэлт нөөц шаардлагагүй, эрэмбэ дарааллыг "богино хугацаа" гэж үнэлсэн.

Одоо ажил эрхэлж байгаа хүмүүст зориулсан дахин чадваржуулах хөтөлбөрийг хөгжүүлэх нь МХХТ-ийн хүний нөөцийг богино хугацаагаар нэмэгдүүлэх боломжтой дэмжлэг мөн бөгөөд нөлөөлөл их гэж үнэлнэ. Нөгөө талаар, Японы бэлэн хөтөлбөрийг ашиглаж болох ч Монголын хөтөлбөрийг бас боловсруулах хэрэгтэй болж, тус дэмжлэгт хүний нөөц, зардал, цаг хугацааны нөөц илүү их шаардагдана. Тиймээс эрэмбэ дарааллыг "урт хугацаа" гэж үнэлэв.

(б) МХХТ-ийн хүний нөөцийн чанар

Аж үйлдвэр, төр, их сургуулийн консорциум болон түүгээр дамжуулан практик хөтөлбөрийг хөгжүүлэх нь дэмжлэгийн нөлөөлөл их байна. Практик ур чадварыг эзэмших боломж ховор байгаа нь хүний нөөцийн чанарыг сайжруулахад учирч байгаа саад юм. Аж үйлдвэрийн салбарын хэрэгцээнд тулгуурласан сургалтын хөтөлбөр боловсруулснаар, дээд боловсролын байгууллагад нэн даруй ажиллах

боломжтой МХХТ-ийн авъяас чадварыг хөгжүүлэх боломжийг олгоно. Мөн, аж үйлдвэр, төр, их сургуулийн консорциум нь тус холбоонд нэгдсэн байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлснээр, аж үйлдвэр, их сургуулийн хамтарсан төслийг хэрэгжүүлэх болон компаниуд дээрх дадлагын ажлыг нэмэгдүүлэх зэрэг олон үр дүнгүүд хүлээгдэж байна. Эдгээр үр дүнгээс давалгаалах үр дүн ч өндөр байна гэж үзэж байна. Сургалтын хөтөлбөр хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн тулд нэмэлт эх үүсвэр хэрэгтэй болох боловч, 1-р алхам болох аж үйлдвэр, төр, их сургуулийн консорциумыг тус төслийн хүрээнд бүрдүүлсэн ажлын хэсгийг тулгуурлан байгуулах боломжтой гэж үзэж, дэмжлэг үзүүлэхэд хялбар гэж үнэлсэн. Тиймээс, эрэмбэ дараалал нь "богино хугацаа" -гаар хийх дэмжлэг гэж тогтоогдсон. Мөн, тус төслийн хүрээний ажлын хэсгийг төсөл дууссаны дараа ч үргэлжлүүлэн ажилуулж, түүний салбар хэсэг болгож боловсролын салбарын ажлын хэсгийг байгуулснаар аж үйлдвэр, төр, их сургуулийн консорциумыг саадгүйгээр байгуулах боломжтой болно. Гэвч, одоогийн ажлын хэсэг нь боловсролын байгуулга болон Боловсролын яамнаасцөөн хүмүүс оролцож байгаа тул, оролцогчдыг сонгох, нэмэгдүүлэх шаардлагатай юм. Мөн консорциумыг үр ашигтай, тогтвортой үйл ажиллагаа болгохын тулд Монголын Засгийн газар санаачлагатай ажиллах шаардлагатай. Монголын Боловсролын яаммөн MDDIC нь тус консорциумыг даргалж бие дааж хэлэлцүүлгийг удирдах тогтолцоог бий болгох хэрэгтэй байна.

Оюутнуудад зориулсан бизнес уралдаан нь, тус төсөлд туршилтын төслөөр зохион байгуулсан DX CUP-ийн үргэлжлэл болж зохиогдохоор төлөвлөгдөж байна. Дэмжлэгийг хүртэх нь зөвхөн арга хэмжээнд оролцсоноор хязгаарлагдах тул дэмжлэгийн нөлөөлөл бага гэж үнэлсэн ч, нэмэлт эх үүсвэрийг ихээр шаардахгүй тул дэмжлэг үзүүлэх нь хялбар гэж үнэлнэ. 7-р бүлэгд дурдсанчлан, DX Mongolia болон Nasha Tech-н 2 компани хамтран ажиллаж, улмаар ивээн тэтгэгчийг олж авах, 2 компани хоорондын зохицуулалтыг хийж дуустал газар дээрээс нь хүн цалинжуулж ажиллуулснаар туршилтын төслийг үргэлжлүүлэх боломжтой болно гэж үзэж байна. Тиймээс эрэмбэ дарааллыг "богино хугацаа" -гаар хэрэгжүүлнэ гэж үнэлэв.

Багш нар хомс гэсэн асуудлыг шийдвэрлэхийн тулд Японд суралцах / дадлагын схемийг бий болгох, мөн Японы их сургуультай хамтарсан онлайнаар хичээл заах тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлэх боломжтой. Эдгээр арга хэмжээ нь МХХТ-ийн чанартай хүний нөөцийг бэлтгэхэд, зөвхөн чанар биш, МХХТ-ийн хүний нөөцийн хэмжээг өсгөхөд ч хувь нэмэр оруулна. Дэмжлэгийг хүртэх нь зөвхөн ажлын семинар болон DX CUP шиг арга хэмжээнд оролцсоноор хязгаарлагдахгүй тул дэмжлэгийн нөлөөлөл дунд гэж үнэлсэн. Дэмжлэгийн хялбар байдлын хувьд дадлага хийх схемын хувьд JEED-ийн схем, онлайн хичээлийн хувьд ЖАЙКА нь Токио их сургуулийн Мацүо Ивасава профессор нарын лаборатортой хэрэгжүүлж байгаа Япон, Африкийн хамтарсан судалгаа болон сургалтын хөтөлбөрийг бий болгох дэмжлэг зэрэг, Монголд ч хэрэглэх боломжтой бэлэн контент бий. Харин Монголд хэрэглэхдээ уг зорилгод нийцүүлэх тохируулга хийх шаардлагатай тул дэмжлэгийн хялбар байдлыг дунд гэж үнэлж, эрэмбэ дараалал нь "дунд хугацаа" -гаар хэрэгжүүлэх ажил гэж эрэмбэлнэ.

(4) Гарааны бизнесийн экосистемийг үүсгэн байгуулах

Гарааны бизнесийн экосистемийн үзэл баримтлал нь өмнөхтэй алил **【Хүний нөөц】【Эд зүйлс】【Мөнгө】【Бодлого • хууль тогтоомж】【Сүлжээ】** гэж ангилж авч үзэж байна.

(а) Хүний нөөц

Бизнес эрхлэгч хүний нөөцийг боловсролын төрөл зүйлд багтааж дэмжлэгийн цэс нь "Их сургуультай хамтарсан бизнес эрхлэгчийн боловсролын хөтөлбөр" ба "Гадаадын гарааны бизнесийн экосистемд хүний нөөцийг илгээх(Японыг оролцуулан)" болох ба нөлөөлөл нь "дунд", дэмжлэгийн хялбар байдлыг "хялбар" гэж үнэлж, эрэмбэ дарааллын 3-р байрыг эзлэх сэдэв болгон тогтоосон байна. Учир нь, гарааны бизнесийн экосистемийн хувьд, бизнэс эрхлэгч хүний нөөцийг бэлтгэх нь экосистемийн дунд, урт хугацааны хөгжлийг дэмжихэд чухал боловч, нөлөөллийн хувьд үр дүн нь шууд гарахгүй, дунд урт хугацааны дараа гарах тул нөлөөллийг "дунд" гэж үнэлсэн. Дэмжлэгийн хялбар байдал нь Японд бас бизнес эрхлэгчдийн боловсролтой холбоотой хөтөлбөрийг хэд хэд хэрэгжүүлж байгаа учраас "хялбар" гэж үнэлэв.

(б) Эд зүйлс

Зорилтот зах зээлээ өргөжүүлэх болон гадаадад тэлэх стратегитэй холбогдох дэмжлэгийн цэс болох "чанарын хандлага", "тоон хандлага" -г нөлөөлөл "их" бөгөөд дэмжлэгийн хялбар байдлыг "хялбар" гэж

үнэлж, эрэмбэ дарааллын хамгийн дээгүүр сэдэв болгож тогтоосон байна. Учир нь гарааны бизнесийн экосистемийг хөгжүүлэхэд, амжилттай жишээ болох гарааны бизнесийн экосистемийг бий болгох болон гарааны бизнесийн параметрын өсөлт нь нөлөөлөл ихтэй гэж бодож байна. Мөн, Монгол шиг хүн ам багатай улсын хувьд, гадаадад тэлэхийг урьдчилсан нөхцөл болгосон бизнес загварыг бий болгох нь гарааны бизнесийн хөгжилд чухал ч, гадаадад тэлэхэд дэмжлэг үзүүлэх сэдвээр илүү хүчтэй дэмжлэгийн хөтөлбөр ховор тул одоогийн дэмжлэг хангалттай биш байна. Гадаадад тэлэхэд нь дэмжлэг үзүүлэхэд анхаарсан гарааны бизнесийн дэмжлэг нь нөлөөлөл ихтэй, мөн, туршилтын төсөл (1)(3)-ын хэрэгжилтээр хөтөлбөрийн удирдлагын мэдлэг чадвар, Монгол, Япон, бусад орнуудын дэмжигчидтэй сүлжээ байгуулах г.м.-ийг бүрдүүлж чадаж байгаа учраас дэмжлэгийг илүү үр дүнтэй, үр ашигтай хэрэгжүүлэхийн тулд эрэмбэ дараалалын хамгийн дээгүүр сэдэв гэж тогтоосон.

(в) Мөнгө санхүү

Мөнгө санхүүгийн хэмжээ болон олон янзын байдал(хөрөнгө оруулалт, санхүүжилт)-д зориулсан дэмжлэгийн арга хэмжээ болох "хоёр шатлалын хөрөнгө оруулалтын иений хөнгөлөлттэй зээлийн төсөл", "хөрөнгө оруулагчдын боловсрол", " төр, хувийн хэвшлийн сан байгуулах, удирдлагыг дэмжих", "Монголын Засгийн газраар гарааны бизнесийн санхүүжилтын механизмыг бий болгоход нь дэмжлэг үзүүлэх(хоёр шатлалтай зээл иений хөнгөлөлттэй зээлийн төсөл)" нь нөлөөллийн хувьд "их" байгаа ч, дэмжлэгийн хялбар байдал нь "хэцүү" байгаа тул, дунд хугацаагаар хэрэгжүүлэх сэдэв гэж тогтоосон. Мөнгө, санхүүгийн хэмжээ, олон янзын байдал нь гарааны бизнесийн хөгжилд зайлшгүй шаардлагатай тул, нөлөөлөл ихтэй боловч, одоогийн байдлаар Монголд иений хөнгөлөлттэй зээлийн төсөл болон гадаадын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн төсөл хэрэгжүүлэхэд төвөгтэй байгаа тул, богино хугацаагаар дэмжлэг үзүүлэх нь бас хэцүү тул дунд хугацаагаар хэрэгжүүлэх сэдэв болгосон. Олон янзын байдал(мөнгөн тэтгэмж)-ын зүйл ангид зориулсан "ивээн тэтгэлэгийн хөтөлбөрийг ашиглан мөнгөн тэтгэмж олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх"-ын тухайд, SU-д хөрөнгө нийлүүлэх нь чухал боловч, мөнгөн тэтгэмж нь өмч хөрөнгөөр худалдан авалттай холбоотой дэмжлэгтэй харьцуулбал нөлөөлөл доогуур байх тул, нөлөөллийг "дунд" гэж үнэлэв. Мөн, дэмжлэг үзүүлэх хялбар байдлын талаар, тодруулбал MONJA г.м.-ийн гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрөөр ивээн тэтгэлэгийг цуглуулан мөнгөн тэтгэмж олгохыг төлөвлөж байгаа тул "хялбар" гэж үнэлэв.

(г) Бодлого • Хууль тогтоомж

"Гарааны бизнестэй холбоотой хууль тогтоомжыг боловсруулах дэмжлэг"-ийн нөлөөллийг "их", дэмжлэгийн хялбар байдлыг "дунд", эрэмбэ дарааллыг 2-р байрны хамгийн дээгүүрх сэдэв гэж тогтоож байна. Гарааны бизнесийн экосистемийг хөгжүүлэхэд, гарааны бизнестэй холбоотой олон янзын бодлого, хууль тогтоомжын систем нь агуулга болон үйл ажиллагаандаа тохирсон байх нь чухал боловч, одоохондоо гарааны бизнесийн хууль шиг тогтолцооны бодлого, хуулийн тогтолцоо байхгүй тул агуулгын хувьд хангалттай биш тул нөлөөллийг "их" гэж үнэлэв. Нөгөөтэйгүүр, дэмжлэг үзүүлэх хялбар байдлын хувьд бодлого, хууль тогтоомжыг хөгжүүлэхэд туслах холбогдогч талууд олон байгаа тул, дэмжлэг үзүүлэх хялбар байдлыг "дунд" гэж үнэлэв.

(д) Сүлжээ

"Өргөн цар хүрээний хурдасгуур, MONJA -гаар тухайн газрын хурдасгууртай холбох сүлжээ тогтоох" тухай【Эд зүйлс】- ангилалд дурдсан ба, Монголын гарааны бизнес-йн хувьд гадаадад тэлэхтэй холбоотой дэмжлэг нь түүний хөгжилд нөлөөлөл ихтэй тул, нөлөөллийг "их" гэж үнэлж байна. Хэрэгжилтийн бодитой саналын хувьд, 【Эд зүйлс】-ыг дэмжих хөтөлбөрөөр гадаадын хурдасгууртай сүлжээ тогтоохыг төлөвлөж байгаа ба туршилтын төслийн(3)"-ын сүлжээг ашиглах боломжтой тул дэмжлэг үзүүлэх хялбар байдлыг "хялбар" гэж үнэлэв.

(5) Нээлттэй өгөгдлийн ашиглалт

Тус сэдэв нь МХХТ, цахим хүний нөөцийг бэлтгэх сэдэвтэй адил Монголын Засгийн газраас хүсэлт ирүүлээгүй бөгөөд нийт сэдвийн эрэмбэ дараалал нь гадаадад тэлэхийг дэмжих болон гарааны бизнесийн экосистемийг бий болгохоос доош байна. Тиймээс, дэмжлэг үзүүлэх хялбар байдал(нэмэлт эх үүсвэр шаардлагатай эсэх, хэмжээ)-г чухалчилж эрэмбэ дарааллыг тогтоосон.

Эрэмбэ дарааллын хувьд "Түүхий мэдээлэл цуглуулах: өгөгдлийн багцын хэмжээ" болон "хувийн хэвшлийн өгөгдлийн багцын хоёрдогч ашиглалт: Хувийн хэвшлийнхэнтэй харилцах харилцаа" 2-ын

дэмжлэгийн нөлөөлөл их бөгөөд богино хугацаанд эхлүүлэх боломжтой сэдэв тул хамгийн өндөрт эрэмбэлсэн байна.

"Түүхий өгөгдөл цуглуулах: өгөгдлийн багцын хэмжээ" -г хамгийн тэргүүлэх ээлжинд сонгосон учир нь, Хакатон • PoC-г хэрэгжүүлсний үр дүнд, одоо байгаа Монголын нээлттэй өгөгдлийн портал дээрх өгөгдлийн багцаар(голдуу статистикийн өгөгдөл)бизнесийг хөгжүүлэх, дэлгэрүүлэх нь хангалтгүй байсан тул, нээлттэй өгөгдлийн порталын өгөгдлийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай нь илт болсон. Хакатон, PoC-д олон баг AI ашигласан програмын хөгжүүлэлтийг хийхээр судалж байсан тул том өгөгдөл шиг өгөгдлийн багцын хэрэгцээ их байв. Гэвч, статистикийн өгөгдөл нь AI-н моделинг хийхэд ашиглах боломжгүй, мөн програм хөгжүүлэлтэд тохиромжгүй тул оролцогч багууд эдгээрийн ашиглалтын зориулалтыг олж чадаагүй. Энэ үр дүнг үндэслээд, одоогий байдлаар нээлттэй өгөгдлийн порталын ихэнх хэсгийг эзэлж буй статистикийн өгөгдөл нь өгөгдлийг багц бүрд хэрэглэгдэх хэмжээ нь бага, ашиглагдах үнэ цэнэ бага тул, статистикийн өгөгдлөөс тусад нь өгөгдлийг багц бүрийн хэмжээг боломжын хирээр нэмж, AI-тай тохирох өгөгдөл(бүтэцгүй өгөгдөл болон байршлийн мэдээллийн өгөгдөл, цаг уурын өгөгдөл, мэдрэгчийн өгөгдөл)-ийн нээлттэй өгөгдлийн порталд ашиглаж болохоор болгохын тулд "түүхий өгөгдлийг цуглуулах: өгөгдлийн багцын хэмжээ"-г тэргүүлэх сэдэв болгож, Монгол улс нээлттэй өгөгдлийн хэмжээ болон төрлийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлж байхыг санал болгож байна. Нөгөөтэйгүүр, нээлттэй мэдээллийн портал дээр зөвхөн статистикийн мэдээллээс гадна ямар төрлийн өгөгдлийг байршуулах талаар гүнзгий ярилцах шаардлагатай тул энэ зүйлд цаг хугацаа шаардагдах болно гэж үзэж байна.

Мөн, "хувийн хэвшлийн нээлттэй өгөгдлийн хоёрдогч ашиглалт: "Хувийн хэвшилтэй харилцах"-ыг нэн тэргүүний зорилт болгон сонгох болсон шалтгаан нь өмнөх Хакатон, PoC -ын үеэр хувийн хэвшлийн ашиглахыг хүссэн өгөгдөл нь засгийн газрын нээлттэй мэдээллийн портал дээр байршуулсан мэдээллээс ялгаатай болох нь ойлгогдсон тул нээлттэй мэдээллийн үйлчилгээ үзүүлэгчийн хувьд Монголын төрийн байгууллагууд эхлээд хувийн хэвшилд ямар төрлийн өгөгдөл хэрэгтэй байгааг ойлгох шаардлагатай байгаа. Энэ талаар энэ удаа PoC-г хэрэгжүүлэх захиалга өгсөн DX Mongolia-ийн ноён Төг Цахим яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга ноён Батзаяатай төр, хувийн хэвшлийн санал солилцох уулзалтыг тогтмол хугацаанд зохион байгуулах тухай санал гаргах төлөвлөгөөтэй ба энэ санал нааштай судлагдаж байгаа байдалтай байна.

Өгөгдөл холболтын талаар "яам газруудыг дамнасан(орон нутгийн захиргааг оролцуулсан)өгөгдлийн холболтын дэд бүтцийг байгуулах" болон "хувийн хэвшлийн тодорхой аж үйлдвэрийн өгөгдөл холболтын дэд бүтэц(Уул уурхай, санхүү зэрэг"-г хамгийн тэргүүлэх сэдэв болгож сонгосон. Яам газрууд хоорондын мэдээлэл солилцох платформын тухайд, мэдээлэл солилцох платформыг гадаадад экспортлох урьдчилсан алхам болгон одоо байгаа ХҮР хуваалцах платформыг дотооддоо ашиглахыг дэмжих нь үр дүнтэй гэж үзсэн тул үүнийг сонгосон.

Хувийн хэвшлийн тодорхой салбаруудад мэдээлэл солилцох дэд бүтцийг бий болгох тухайд Японы жишээг авч, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй томоохон үйлдвэрүүдэд мэдээлэл солилцох платформыг хөгжүүлснээр одоо байгаа үйлдвэрүүдийн үр ашгийг дээшлүүлж, сэргээх боломжтой гэж үзэж байна.

Гэхдээ хувийн хэвшлийн тодорхой салбаруудад мэдээлэл солилцох, хамтран ажиллах платформ байгуулах нь зөвхөн хувийн хэвшлийн оролцоотойгоор хэрэгжиж боломжтой бөгөөд үүнийг хувийн хэвшлийнхэн удирдан чиглүүлэх шаардлагатай байна. Тиймээс ЖАЙКА үүнийг урт хугацаанд Монголын өгөгдлийн хамтын ажиллагааны платформыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх дунд болон урт хугацааны зөвлөмж болгож үнэлэв. Мөн, Монголын одоогийн өгөгдөл солилцох платформ болох ХҮР-ийг дотооддоо ашиглахын зэрэгцээ Монголын компаниудын хилийн чанад дахь тэлэлт, экспортын стратегийг Монголын ХҮР-тэй холбосноор бий болох бүтээгдэхүүний нэг нь хувийн хэвслүүдийн хилийн чанадад тэлэх явдал юм.

(6) Цаашдын чиглэл

Энэхүү судалгааны зорилго нь МХХТ-ийн салбарыг сурталчлахад дэмжлэг үзүүлэх хэрэгцээний талаар өргөн хүрээтэй мэдээлэл цуглуулж, үйлдвэрлэлийг дэмжихэд хувь нэмрээ оруулах боломжтой чиглэл, хандлагыг тодорхойлоход оршиж байв. Судалгаагаар МХХТ болон цахим салбарыг гадаадад өргөжүүлэх, гарааны бизнесийн экосистемийг бий болгоход дэмжлэг маш чухал хэрэгтэй байгаа бөгөөд Монголын засгийн газар ч өндөр хэрэгцээ байгааг хүлээн зөвшөөрсөн салбар гэж тодорхойлсон.

Мөн тэдгээр чиглэлүүд дэх тодорхой дэмжлэгийн арга хэмжээний санал болон эрэмбэ дарааллыг судалж тогтоосон.

Нөгөө талаас, МХХТ-ийн салбарын хөгжил бол гайхамшигтай бөгөөд гадаад орчин нь байнга өөрчлөгдөж байдаг. Мөн засгийн эрх солигдох болон тогтолцооны өөрчлөлтөөр Монголын Засгийн газрын баримталж байгаа чиглэл ч өөрчлөгдөж болзошгүй. Тиймээс, цаашид тухайн салбарт үзүүлэх дэмжлэгийг судлахдаа, тус судалгааны үр дүнгээс санаа авч, улам нарийвчилсан мэдээллийг цуглуулж, дэмжлэгийн бодитой чиглэлийг боловсруулах шаардлагатай юм.